

Швейцарид болсон Фа Конференц

Ли Хонжи

1998 оны 9 сарын 4–5, Женев хот

Бүгдэд өдрийн мэнд хүргэе!

Та нарын дунд сууж байгаа зарим нь дөнгөж сая Сингапурд болсон Фа конференцээс шууд энд ирсэн, бас зарим нь бусад улс, орон нутгаас энд яаран ирсэн хүмүүс байна, мөн шинэ сурагчид байна. Бид Фа конференц хийж байгаагийн гол зорилго бол нэг нэгнийхээ туршлагаас суралцах, өөрийн дутагдлыг илрүүлэх, бясалгалдаа хамтдаа ахих явдал юм. Мөн энэ арга хэмжээ нь Фа дэлгэрүүлэх үйл ажиллагаа болдог. Бидний хүсч байгаа зүйл бол өөрсдийгээ бясалгалаар дээшлүүлэх, зүгээр нэг хэлбэрдэх явдал биш. Тиймээс ирээдүйд бид Фа конференц хийхэд энэ зарчмыг санаж байх хэрэгтэй, сурагчдад үнэхээр үр нөлөөтэй байлгах хэрэгтэй. Ийм коференц хийхийн өмнө бид энэ талаар сайн бодолцсон байх хэрэгтэй, туршлага солилцох олон конференц ойр ойрхон болбол хүний өрсөлдөх сэтгэл гарч болзошгүй, та нар тэгж хийвэл бид ингэж хийнэ гэнэ. Тэгж болохгүй. Бид бүгд Фа дагуу сурагчдын бясалгалд тус болохуйц конференц ингэж зохион байгуулж байх хэрэгтэй.

Энд нилээд хэдэн хуучин сурагчид байна. Та бүхнийг харахад таатай байна. Та нар бясалгалын хүрээнд өөрсдийгээ үнэхээр үсрэнгүй дээшлүүлж байгаа. Та нар өөрсдийнхээ өөрчлөлтийг хэдийгээр харж чадахгүй байгаа ч гэсэн тэр өөрчлөлт бол их том. Удахгүй та бүхэн үүнийг үзэх болно. Миний сэтгэл та нарт хангалуун байгаа.

Та нар Фа конференц дээр миний зааж байгаа Фа-г сонсож мөн өөрсдөө Жуан Фалунь номоо үргэлж уншиж гүнзгийрүүлэн судлах явцдаа олон зүйлийн үнэн илэрлийг харж байна, Номын өөр гүн ойлголттой болж байна. Үүний зэрэгцээ би та нарын бясалгалын явц болон орчлон ертөнцийн бүтцийн өөр нэг хэлбэрийн танин мэдэхүйн талаар ярья. Би эхлээд орчлон ертөнцийн бүтцийн нэг төрлийн талаар ярья. Үүний өмнө тайлбарлах зүйл байна: Үнэндээ, Фа бол орчлонг ертөнцийг бүтээсэн. Миний орчлон ертөнцийн талаар ярьж байгаа нь орчин үеийн шинжлэх ухааныг ямар нэгэн өндөр төвшинд хүргэх зорилготой биш, мөн та нарт зарим мэдлэг өгөх гэсэн хэрэг бас биш. Харин энэ нь та нарыг бясалгуулахын тулд юм. Яагаад гэвэл орчлон ертөнц Фа-тай зохицож байдаг. Зорилго нь чамайг бясалгалаар өөр өөр оршихуйд хүргэхэд юм, өөрөөр хэлбэл та нар өөрсдийн бүтсэн өөр өөр оршихуйдаа буцах, орчлон ертөнцийн өөр өөр түвшний орон

зайд буцах болно. Энэ Фа бол сансар ертөнц лугаа агуу том, хязгааргүй, тэр ухагдахуун чиний төсөөлөлд байхгүй. Өнөөдөр би өөр өнцгөөс ярина, та нарын ойлголт миний ярихад хоцрохгүй байх эсэхийг харъя.

Би эхлээд сансар орчлонгийн талаар ярья. Сансар орчлонгийн талаар ярихдаа материйн талаас түүнийг яаж ойлгох талаар эхэлж ярья. Орчин үеийн шинжлэх ухаан ямарч хөгжингүй байсан түүний материйн талаархи ойлголт бол маш гүехэн. Бүхэл сансар орчлонгийн хувьд харьцуулбал дурьдах ч хэрэггүй. Би сансар ертөнцийг анхдагч элемент, ширхэг хэсгүүдээс бүтсэн гэсэн. Тэгвэл тэр анхдагч элемент нь юунаас бүтсэн бэ? Тодорхой байдлаар тайлбарлах хэрэгтэй. Сансрын биетийн янз бүрийн давхаргын ойлголтоор (ертөнцийн давхарга биш) сансрын биет хэр том бэ? Зөвхөн нэг сансрын биетийн эзлэх хэмжээ асар том. Нэг сансрын биет тэдэн ертөнцийн давхаргаас бүрдэнэ гэсэн тогтсон тоо байхгүй. Зарим нь 10 мянга хүртэлх ертөнцийн давхаргаас тогтоно, зарим нь 100 сая ертөнцийн давхаргаас тогтдог. Энэ ойлголт бол асар уудам. Тиймээс сансрын биет болгон төсөөлшгүй уудам сансрын нэг орон зай.

Хүмүүс ертөнцийн талаар төсөөлөн ярихдаа танин мэдсэн галактикийн тооны хүрээнд ярьдаг. Орчин үеийн шинжлэх ухаанд ажиглан харж чадах орон зай нь хүмүүсийн ярьдаг жижиг ертөнц юм. Дэлхийг эхлэл цэг болгон авч үзье. Энэ жижиг манай ертөнцөөс эхлэн энэ хэмжээний гурван мянган ертөнц нийлж хоёр дахь давхаргын ертөнц бүрддэг. Тэр хоёр дахь давхаргын ертөнцийн хэмжээний гурван мянган ертөнцөөс гурав дахь давхаргын ертөнц бүрддэг. Та бүгд боддоо, өсөх хэмжээ нь асар том, гэхдээ энэ нь нэг эхлэл цэгийн хувьд ойлголт. Энэ ертөнцөд дэлхийн хэмжээний ширхэг зөвхөн ганц байдаггүй. Дэлхийн хэмжээний ширхэгүүд ертөнц даяар тархсан байдаг, тоолшгүй олон. Би ертөнцийг хэр том болохыг зөвхөн нэг ширхэгийг эхлэл болгон хэллээ. Үнэндээ ийм хэмжээний ширхэгүүд сансар орчлон даяар тархсан байдаг. Тэдгээр нь бүх зүйлд хаа сайгүй байдаг. Тэд бүгд ийм хэлбэрийн тэлэх системтэй, томоос бага руу, багаас том руу тэлсэн байдаг. Хүн төрөлхтөнд энэ жижиг ертөнцийн давхарга хүртэл асар том. Үүн доторхи янз бүрийн хэмжээний галактик-ширхэгүүд маш олон. Яагаад вэ? Хэдийгээр маш өндөр түвшний Буддууд, Гэгээрэгчид, Дао нар бүхнийг хардаг ч гэсэн энэ тоосонцоруудын ширхэгийг тоолох бодол хэнд ч байгаагүй. Уудам сансрын биет даяар тархан орших одууд бол сансарт хөвөх тоосонцрууд гэсэн үг.

Ийм хэмжээний гурван мянган ертөнцүүд үргэлжлэн олширч тэлсээр нэгэн хэлхээ болно, тэдгээр нь цааш үргэлжлэн тэлсээр нэг давхарга үүсгэнэ. Дунджаар нэг мянга дахь тийм давхаргад хүрэхэд сансрын энэ эхний биетийн хязгаарт хүрнэ. Тийм хэмжээ зөвхөн ганц биш, энэ нь бас л нэг ширхэг болно, ийм түвшний ширхэгүүд энгүй сансрын уудам даяар тархсан байдаг. Тэр хүрээнээс цааш бүрэн хоосон орон зай эхэлнэ. Ямар хоосон бэ? Хэрэв энэ системийн ямар нэгэн биет үүнд нэвтэрвэл өөрөө задарч устахтай адил. Яагаад гэвэл энэ системийн хүрэн доторхи аль ч бодис гэсэн амьтай, мөн чанар, онцлог, бас бодолтой. Тийм хэмжээний микро хоосонд орсон ширхэгний амь, бодол нь тэтгэгдэхгүй учраас нэн даруй задран устана. Өөрөөр хэлбэл үүнд унасан бүх зүйл задарч устана. Үүнийг ингэж тайлбарлавал ойлгоход арай амар. Тэр хоосон орон зайнаас цааш сансрын илүү том хэмжээний сансрын биетүүд оршино. Энэ орон зайн амь бодь тэр тал руу алхам ч ойртож чадахгүй, улам микро оршихуйд улам микро элементүүд байдаг. Бүр том хэмжээнд матери болон амины ухагдахуун нь тухайн сансрын биетэд өөр байдаг, матери

гэсэн ухагдахуун байдаггүй. Сансрын биетүүдийн хүрэн доторхи ертөнцүүдийн давхарганы тоо адилгүй. Гэхдээ сансрын биет болгон хамгийн микро, анхдагч ширхэгээс тогтдог. Мөн бүх анхдагч ширхэг элементүүд орчлон ертөнцийн Жэнь, Шань, Рэн (Үнэн, Нинжин, Тэвчээр) мөн чанараас тогтдог.

Миний энд ярьж байгаа ухагдахуун бол маш их нарийн. Хүний хэл үнэхээр хязгаарлагдмал, тиймээс та нар их анхааралтай сонсоорой. Жишээ нь: Хамгийн том матери нь ямар нэгэн түвшний сансрын биетийн ширхэг. Тэр нь бас өөрийн системийн хязгааргүй микро хэсгээс бас тогтдог, тэдгээр нь нэгдсээр байгаад тэр түвшний ширхэгийн хэмжээнд хүрдэг. Үүнийг ширхэгүүдийн хэвтээ тэнхлэгт холбогдсон систем гэдэг. Энэ нь материйн ширхэгүүд зөвхөн босоо тэнхлэгийн микро системээс тогтдоггүй гэсэн үг. Гэхдээ тэр нь микро хэсгээс том хэмжээнд хүртэл, түүнээс ч бүр том хэмжээний зүйлсээс нэгэн зэрэг тогтдог бөгөөд өөрийн системийг үүсгэдэг. Энгийн үгээр хэлбэл энэ системийн түвшин бүрийн янз бүрийн хэмжээний ширхэг болгон микро системээс тогтсон нэг системийг төлөөлдөг. Гэхдээ энэ системийн түвшин бүрийн янз бүрийн хэмжээний ширхэгүүд бас хаа сайгүй тархдаг. Тиймээс энэ системийн янз бүрийн хэмжээтэй ширхэгүүдийн хооронд бас хэвтээ тэнхлэгийн бүтцийн систем үүсдэг. Түүний хамгийн анхдагч ширхэг элементүүд болон хамгийн том давхаргын ширхэгүүд хоорондоо их хол зайтай.

Тэгвэл туйлын анхдагч матери гэж юу вэ? Энэ бол ус. Гэхдээ миний хэлж байгаа ус бол бидний энгийн хүний амьдралд байдаг ус биш. Өөр орон зайн түвшингүүдэд оршдог гол, горхи, нуур, далай тэнгист байдаг ус ч бас биш. Энэ ус бол тухайн түвшин дэх сансрын биет дэхь бүх матери, амь бодийг үүсгэдэг. Чи үүнийг "Үндсэн эх матери" гэж хэлж болно. Энэ ус нь бидний энгийн хүний орон зайд орших усны ухагдахуунаас их ялгаатай. Тодорхой хэлбэл үүнийг үхмэл ус гэж болно, ямар ч хөдөлгөөн байхгүй. Энэ бол огт хөдөлгөөнгүй үхмэл, түүн дотор ямар нэгэн зүйл чулуудвал долгион огт үүсэхгүй, ус багахан ч үсрэхгүй.

Бид одоо энэ усны талаар ярингаа хүний орчлонд байдаг усны талаар эхлээд ярья. Бид энгийн хүний шинжлэх ухаан дээр авч ярья. Манай хүн төрөлхтний нийгэмд орчин үеийн эрдэмтэд бодисыг органик ба органик бус гэж ангилдгийг бүгд мэднэ. Энэ бол зөвхөн энэ орон зайн хязгаарлагдмал ойлголт. Матери зөвхөн энэ гадаргуйн орон зайн бодисоос тогтдоггүй. Эрдэмтэд органик бодис гэж энэ орон зайд орших амьтай зүйлсийг хэлдэг. Жишээ нь: мод, цэцэгс, ургамал, амьтан болон хүн багтана. Эдгээр нь чухамдаа энэ орон зайн уснаас бүтээгдсэн. Та нар хүний биеийн 90% гаруй хувь нь уснаас тогтдог гэж мэднэ. Бид хүмүүс энэ орон зайн уснаас тогтдог. Ус бүх зүйлийг бүтээж чадна гэж би урьд хэлж байсан. Зөвхөн орчин үеийн эрдэмтэд учрыг нь олж чадахгүй байгаа. Энэ орон зайн ус ургамлыг ургуулж чадна. Ургамлыг гартаа базаад шахаад байвал хлорофилийн ногоон мөхлөгнөөс өөр юу ч үлдэхгүй. Мөн хлорофилийн ногоон мөхлөгийг дахин задалбал уснаас өөр зүйл үлдэхгүй. Өөрөөр хэлбэл энэ орон зайд хүмүүсийн органик гэж нэрлэдэг бүх зүйлс үнэн хэрэгтээ энэ орон зайн уснаас бүтдэг, ус бол бүгдийг биежүүлж бүтээдэг гэсэн үг.

Тэгвэл би чамд хэлье, органик биш зүйл гэдэг нь үнэндээ дээд түвшний усаар бүтээгдсэн. Гэхдээ орчин үеийн шинжлэх ухаан үүнийг танин мэдэж чадахгүй, тэдгээрийг

амьгүй гэж үздэг. Гэхдээ тэд үнэндээ амьтай. Тэдгээрийн орших хэлбэр орчин үеийн шинжлэх ухааны танин мэддэгээс их ялгаатай. Одоогийн шинжлэх ухаан энэ үзэл бодлоороо үргэлжлэн явбал хүмүүс тэдгээрийн хэлбэрийг хэзээ ч танин мэдэж чадахгүй. Эртний Хятадад бясалгагчдын дунд ийм нэгэн яриа байсан: "Тэнгэрийн хүмүүс-Бурхад их чадвартай, тогоонд чулуу хийгээд ус гаргаад авчихдаг". Энэ нь үлгэр шиг сонсогдсон ч үлгэр биш. Сансрын биетийн хүрээнд орших энэ орчлон ертөнцийн ямар ч биетийг үүсгэгч анхдагч нь бол ус. Бүр микро ус ямар байдаг вэ? Түүнээс илүү микро ус ямар байдаг вэ? Энэ бол төсөөлөхийн аргагүй, илэрхийлэх ч боломжгүй. Би та нарт зөвхөн нэг санаа л өгч байна.

Миний сая хэлсэн бол өөр түвшингүүдийн ширхэг хэсгүүд бүгд хамгийн суурь, анхдагч элементтэй байдаг. Тэдгээр хэсгүүд нь бүхэлдээ босоо болон хэвтээ байршилтай байдаг, яг манай дэлхийтэй адил. Олон галактикийн системүүд нийлж нэг ертөнц болдог, олон ертөнцүүд нийлж бүр том хэмжээний ертөнцийг үүсгэдэг. Бид дэлхийг эхлэл цэг болгон авч байна, яагаад гэвэл бид хүмүүс энд байна, мөн би энд Фа зааж байна. Тиймээс би дэлхийг эхлэл цэг болгон авч байна. Гэхдээ дэлхий бол ертөнцийн бүх бодисын эхлэл цэг биш. Бид эргэн тойрондоо оршиж байгаа зүйлсийг хамгийн бодит материаллаг гэж үздэг. Урьд би Фа зааж байхдаа хүмүүсийг будлиулахгүйн тулд тэдгээрийг хамгийн доод түвшний матери гэж хэлсэн. Гэхдээ үнэндээ тэдгээр нь цорын ганц материаллаг зүйлс биш. Та нар үүнийг үндсэн матери гэж болно, өөрөөр ч хэлж болно. Дээд матери гэж байдаг, бас түүнээс дээд матери, мөн түүнээс ч дээдийн дээд матери гэж байдаг гэх мэт...

Гурамсан ертөнцийн хүрээнд дэлхийн бөмбөрцөг хэвтээ болон босоо тэнхлэгийн төвд оршдог. Ширхэг хэсгүүдийн хэмжээний хувьд дэлхий бас дунд нь ордог. Мөн өөр матери байдаг, түүний жин нь манай дэлхийгээс илүү. Гэхдээ энэ нь миний урьд ярьж байсан жин биш. Ямар нэгэн атом, атомын цөмийн жин маш их. Гэхдээ ийм нэг ойлголт биш, энэ бүх материйг хүн төрөлхтөн таньж чадна гэсэн үг биш. Би дээд материйн тухай ярьж байна, хүний орон зайд орших матери биш. Энэ матери бол энэ орон зайн матераас ширхэгийн хувьд, гадаад бүтцийн байдлаараа давуу. Тэгэхээр хамгийн том дээд материйн эхлэл цэг бол Гурамсан Ертөнцийн зах юм. Хамгийн жижиг материйн эхлэл цэг бол Гурамсан Ертөнцийн хязгаар дотор байдаг. Хүн төрөлхтний мэдэх энэ оршин байгаа орон зай бол том бага материйн дунд оршдог, материйн эхлэл цэг юм. Хэрэв хүмүүний орон зайн түвшинд орших бүх зүйлсийг матери гэвэл Гурамсан Ертөнцийн доторх хүний орчлонгийн материас бага зүйлсийг матери биш гэж хэлмээр, түүнээс бага зүйлсийг бүр матери биш гэх үү, тэгээд Гурамсан Ертөнцийн хамгийн жижиг ширхэг хүртэл үргэлжлэнэ. Миний урьд хэлсэн орчлон ертөнцийн хэмжээний тухай ойлголт бол энгийн хүмүүсийн хэмжээг ойлгодог ухагдахуунтай адил биш.

Сансар ертөнцийн хувьд бүхэлдээ бас ялгаагүй. Бүх ширхэг хэсгүүд амьд, тэд амьтай. Тэгвэл боддоо, ертөнцийн хязгаар хэр их уудам байсан ч бас амьд. Гэхдээ сансрын биетийн хязгаар дотор тоолшгүй олон янз бүрийн хэмжээний ширхэг хэсгүүд байдаг, ширхэг болгон нь бие даасан амьдралтай. Энэ орчлон ертөнцөд хичнээн тэнгэрийн давхарга байдаг вэ? Хэдэн давхар ертөнцүүд байдаг вэ? Хэдэн давхар сансрын биетүүд байдаг вэ? Үүний дотор байгаа хэн ч сансар ертөнцийн ямар уудам том болохыг, ямар нарийн бүтэцтэй болохыг мэдэж чадахгүй. Миний ярьсан сансрын биет бол хэдэн арван

сая гаруй давхрын ертөнцөөс тогтдог, гэхдээ энэ нь агуу сансрын хувьд бол тоосонцор, нэгэн жижиг ширхэг. Хэрэв чи маш холын холд харваж очоод тэндээс эргэж харвал хүний хувьд ширхэг элснээс ч бага харагдана. Тэрнийг бүр холоос харвал тоосонцроос ч бага харагдана. Түүнээс ч бүр холоос харвал тэр харагдахаа болино. Би сая энэ талаар янз бүрээр тайлбарлалаа. Энгийн үгээр хэлбэл сансар ертөнц бүхэлдээ ширхэгээс бүтдэг, тэр ширхэг бас ширхэгээс бүтдэг. Түүнээс бүр өргөн хүрээнд авч үзвэл ширхэгээс бүтдэггүй болно. Түүнийг үгээр илэрхийлэх аргагүй, мөн хүмүүст хэлж болохгүй.

Хүний сэтгэлгээ хязгаарлагдмал, ширхэг нь ширхэгээс тогтдог гэж миний хэлсэн бол энгийн ойлголт өгч байгаа юм. Үнэн хэрэгтээ яг тийм биш, сансар ертөнцийн бүтцийн нарийнийг хүний хэлээр тайлбарлах боломжгүй. Бидний энэ орон зайнаас гарвал бодол, цаг хугацаа, орон зай, аминий хэлбэр бүгд өөрчлөгдөнө. Ялангуяа орон зайн цаг хугацааны зөрөө тод харагдана. Ширхэг хэсгүүд хоорондоо их ялгаатай. Жишээ нь: Гаригсын хооронд их хол зай оршдог гэдгийг бид мэднэ. Бидний бие махбодь, мод, агаар гэх мэт бүгд молекулаас тогтдогийг бид мэднэ. Молекул бас ширхэг хэсгийн нэг түвшин, гариг-ийн түвшнээс бага. Өөрөөр хэлбэл гаригаас бага хамгийн том ширхэг хэсэг бол молекул. Молекулаас доош хамгийн том ширхэг хэсэг бол атом. манай хүн төрөлхтний ойлголтоор молекул атом хоорондоо их ойрхон, бараг зайгүй. Гэхдээ чи тэр орон зайд орвол тэр орон зайд бас өөрийн цаг хугацаа, байдал бас их уудам том орон зай болохыг олж мэднэ. Түвшин болгонд ийм байдаг. Молекул гаригсын хооронд орших бид орчлон ертөнцийг агуу том гэж мэдэрдэг. Хэрэв чи атом молекулын дунд зогсож байвал тэр орчлон үүнээс ч том болохыг мэдэрнэ. Өөрөөр хэлбэл үүнийг ойлгохын тулд тэр цаг хугацаа, орон байдалд нийцэх хэрэгтэй.

Миний сая ярьсан бол та нар гаригсын хооронд их зай байдгийг хардаг, харин хүний төсөөллөөр молекулуудын хоорондох зай ойрхон, гэхдээ үнэндээ их зайтай гэдгийг хэллээ. Ширхэг хэсгүүд тоолшгүй олон амь бодийг бүрдүүлж чадна, хүн бас багтана, мөн төрөл бүрийн амьтад, янз бүрийн ургамлууд, мод, цемент, ган бас төмөр, бидний амьдралыг тэтгэдэг агаар. Би урьд хүн төрөлхтөн бол үнэхээр овоолсон шороон дотор амьдарч байна гэж хэлсэн. Өт хорхой шороон дотор мөлхөж байдаг. Хүн Бурхдын нүдэнд бас шороонд шигдсэн ийм байдалтай харагддагийг та нар мэдэх үү? Яагаад? Бид хүмүүс шороог л шороо гэдэг, харин Бурхдуудын хувьд молекулууд, Гурамсан Ертөнцийн молекулуудыг шороо, хамгийн бохир заваан зүйл, шороо гэж үздэг. Үнэхээр шороо юм. Тэгвэл боддоо: Тэдгээр Бурхдад энэ дэлхий орчлон ямар харагддаг вэ? Агаар молекулаас тогтсон, та нарын эргэн тойронд байгаа бүх зүйлс молекулаас тогтсон. Энэ орон зайн ус бас молекулаас тогтсон, агаар мөн адил. Бурхад молекулыг шороо гэж үздэг, тиймээс хүн шороонд бүрэн булуулсан, шороонд шигдэн амьдардаг-хүн ийм л орчинд амьдардаг. Ийм байдлаар тайлбарлахад та нар магадгүй Барууны шашны Иегов болон Есүс бас Бурхан хүнийг шорооноос бүтээсэн гэж хэлснийг ойлгоно, тийм үү? Дорнодод бол хүмүүс Нюй Ва бурхан хүнийг шорооноос бүтээсэн гэж ярьдаг. Миний энэ тайлбарын дараа та нарт үүнийг ойлгоход амар. Бурхад энэ орон зайн материас ширхэгээс бүрдсэн хэсгийг шороо тоос гэж үздэг. Үнэндээ ийм л байдаг.

Би сая хэллээ, ширхэг хэсгүүд нь орон зайд орших бүх зүйлсийг бүтээдэг. Сансрын биетүүд уудам бөгөөд олон төрөл. Орчлон ертөнц илүү бичил микро ширхэгүүдээс бүтэх тусам улам үзэсгэлэнтэй сайхан харагддаг. Үнэндээ том ширхэгүүд илүү том сансрын

биетийг, эсвэл илүү том амь бодийг бүрдүүлж чадна. Эдгээр гаригууд бидний нүдэнд нэг нэгнээсээ их хол зайтай харагддаг, харин том амь бодийн хувьд хоорондоо ойрхон харагддаг, хүний нүдэнд молекулуудын хоорондох зай ойрхон харагддагтай адилхан. Тэгвэл хүн гаригуудын хооронд харсан зүйл нь нэг амь бодийн биений хэсэг байж болох уу? Өөрөөр хэлбэл тэд бүр том амь бодийг бүрдүүлж чадах уу? Тийм л гэсэн үг, урьд аварга хүмүүс, одой хүмүүс байсан. Энгийн хүмүүс үүнийг байсан, байгаагүй гэж ярих ч яахав, би зарчмын хувьд ярьж байна, одоо цаг хугацаа л өөрчлөгдсөн. Түүх одоогийн энэ үед ирсэн учраас түүх соёл энэ үедээ зохицох ёстой. Тиймээс өнөөгийн нийгэм ийм болсон. Хүмүүс нүдэнд харагдахгүй, мэдрэхүйд өртөхгүй зүйлд итгэхээ больсон. Тэд улам итгэхгүй болох тусам үнэнийг бага мэдүүлнэ. Яагаад гэвэл хүмүүс муйхар болсон. Мөн хүний итгэхгүй байх нь урьдаас зохицуулагдсан. Хүмүүс бүхнийг санаснаараа болгохыг хүсдэг, гэхдээ хэзээ ч тэгж чадаагүй гэж би хэлдэг.

Хүмүүс бүхнийг удирдахыг хүсдэг, ардчиллыг байгуулахыг хүсдэг, энэ талаар ярихад хүн хэзээ ч юуг ч удирдаж байгаагүй, орчлон хорвоог Бурхан удирддаг. Хэнд төрөлхөөс их аз жаргал, чадвар заяасан байна түүнд дээд эрх мэдэл төлөвлөгддөг, хэнд бага аз жаргал чадвар тохионо, түүнд дээд албан тушаал яасан ч олдохгүй. Парижийн коммун засаглалыг устгаж чадаагүй. Би хэлье, түүхэнд Францын ерөнхийлэгч байсан хүмүүс бүгд урьд Хятадын гүрний эзэн хаадууд байсан, тэд зөвхөн өөрөөр зохицуулагдсан. Би үүгээр бүх зүйлс Бурхдаар зохицуулагддаг гэж хэлж байна. Тэгвэл өнөөгийн хүний нийгэмд гарч байгаа нам эвслүүдийн хоорондын тэмцэл бол одоогийн хүн төрөлхтний орших байдал. Та нар эрт дээр үед тийм зүйл байгаагүйд итгэлтэй. Өнөөдрийн хүн төрөлхтөн бол үнэндээ хувирсан хүн төрөлхтөн, хувирсан нийгэм. Энэ талаар би ярих гэж бодоогүй.

Бид сая орчлон ертөнцийн янз бүрийн ширхэг хэсгүүд янз бүрийн хэмжээний амь бодийг үүсгэж чадна гэж хэлсэн. Гариг бүр дээр амьдрал оршдог, гэхдээ энэ хүн төрөлхтний орон зайд оршдоггүй, тиймээс хүмүүс үүнийг мэддэггүй. Өнөөгийн шинжлэх ухаан дорой хөгжилтэй, энэ орон зайн хүрээнд мөлхөж явдаг болохоор үүнийг мэддэггүй. Үнэндээ өөр орон зайг харахад амархан. Хэрэв асар том микроскопын систем байвал тэдгээр молекулаас бага ширхэгүүдээс тогтсон биетүүдийн орших хэлбэрийг харж чадна. Үзэл суртлын гэх мэт олон төрлийн саад байдаг, итгэхэд хүндрэл учруулдаг, тийм байх учиргүй гэж үздэгээс хийж зүрхэлдэггүй, утга учиргүй гэж үздэг. Тэдгээр биетийн орших үнэн бодит байдлыг харж чаддаггүй. Гэхдээ чи үүнийг харах, харахгүй ч гэсэн энэ нь өөрийн гадаад байдлаа үе үе харуулж ирсэн. Зарим хүн гэнэт хардаг. Матери хөдөлгөөнийхөө явцад янз бүрийн нөхцөл байдлаас болж гэнэт илэрч харагдаж болно. Ийм байдал үргэлж гардаг. Хүмүүс зэрэглэл агаарын давхарга дахь нэг хэлбэрийн гэрлийн хугарал гэдэг. Энэ бол зөвхөн өнөөгийн шинжлэх ухаан тайлбарлаж чадахгүй байгаа зүйлээ хаацайлж байгаа хэрэг, үүнд ямарч үндэслэл байхгүй. Үнэндээ энэ бол өөр орон зайн жинхэнэ тусгал, илрэл юм. Та нар миний ярьсан сансар ертөнцийн талаархи ухагдахууныг ойлгож чадна, тийм үү? (Алга ташив)

Энэ сансар ертөнцийн бүх матери "Жэнь, Шань, Рэн"-ээс тогтдог. Өөр өөр түвшинд "Жэнь, Шань, Рэн"- өөр өөрөөр илэрхийлэгддэг, янз бүрээр илрэх хэлбэртэй бөгөөд янз бүрийн түвшний амь бодийн амьдрах нөхцлийг бүрдүүлдэг. Энэ Фа хүний орчлонд бүх өргөн хүрээнд, тун ярвигтай хэлбэрээр илэрдэг, бясалгалын маш олон хэлбэртэй, мөн үнэнийг ухамсарлах зарчим бас маш олон. Энэ орон зайн шалгуурт сайн хүн гэдэг бол:

энэрэнгүй, шударга, эелдэг, ухаалаг, үнэнч байх гэх мэт гэхдээ зөвхөн эдгээр шинж чанараар хязгаарлагдахгүй их олон шинж чанар багтана, энэ бүгд Жэнь, Шань, Рэн-ээс үүсдэг. Эмэгтэй хүнийг бүрдүүлдэг шинж чанар бол эмэгтэйлэг зан, уян зөөлөн байдал бол эрэгтэй хүнд байвал зохих чанар бол хатуу тууштай, үнэнч гэх мэт. Энэ бүгд Фа-гаас үүсэлтэй, материйн орших хэлбэр, төрөл бас Фа-гаас үүсэлтэй. Фа бүхнийг бүтээсэн.

Цааш би бясалгалын талаар ярья. Бясалгахад чи яагаад тухайн түвшний шалгуурт заавал нийцсэний дараа тэр түвшинд хүрдэг вэ? Яагаад гэвэл түвшин болгонд өөрийн Фа оршдог, шат болгонд амь бодид болон хүрээлж буй орчинд тавигдах шаардлага байдаг. Карма-гаар дүүрсэн бие тэр орон зайн орчны шалгуурт тэнцэхгүй. Бохир бие дээд түвшний орон зайд орж яасан ч чадахгүй. Тэр дээд түвшний, тодорхой хэлбэл нүгэл үгүй түвшний биеийн байдалд нийцэх ёстой. Зөвхөн нүглээсээ салах биш бас энэ дагуу чиний биеийн микро жижиг элементүүд, сайн болох ёстой. Жинхэнэ бясалгадаггүй хүн тийм байдалд хүрч чадахгүй, хүсээд ч санаснаараа хүрч чадахгүй, зөвхөн бясалгалаар хүрнэ. Зовлон бэрхшээл туулж байж, тууштай бясалгаж байж хүрнэ, түүнээс гадна чиний амь биеийн нөгөө тал тэр түвшний шалгуурт нийцсэн байх ёстой. Чиний зүрх сэтгэл, бодол санаа, сэтгэн бодох бүх чадвар, чиний амь бодид заяасан бүхэн бас тэр түвшний шалгуурт нийцсэн байх шаардлагатай.

Мэдээж тэр орон зайд орших амь бодийн хэлбэрт нэг шалгуур байдаг, хүний байдалтайгаар тэнд очиж чадахгүй. Чи гэгээрэхэд тэр орон зайн амь бодийн хэлбэртэй байх ёстой. Улам дээш өгсөх тусам амь бодийн гадаад төрх байдал улам залуужина, сайхан болно, харин доошлох тусам улам муухай болно. Улам дээд давхаргад хүрэхэд зөвхөн гаднах төрх сайхан болоод зогсохгүй мөн бодол санаа хүртэл улам цэвэр ариун болно. Орших байдал, үг яриа, үйл хөдлөл бүгд өөрчлөгдөнө. Үг хэл нь шүлэг шиг, энэ бол тэр түвшний байдал юм. Дээшлэх тусам улам гоё болно. Иймд тэр давхаргын шалгуурт нийцэхгүй байхыг огт зөвшөөрөхгүй. Би үргэлж хэлдэг, бясалгал өөрөөс хамаарна, гон багшаас хамаарна гэж. Хэрэв чи тэр хүрэхийг хүсч байгаа давхаргын талаар мэдэхгүй бол яаж тэнд хүрэх юм? Чи яаж үүнийг хийх юм? Чамд үүнийг хийх боломж байхгүй. Би зөвхөн чиний бясалгаж байгаа зүрх сэтгэлийг чинь харна. Хэрэв чи бясалгахаар бүрэн шийдсэн бол нөгөө талыг нь Багш хийж өгнө. Чиний тууштай байж чадах эсэх, эцсийг нь үзгэл бясалгаж чадах эсэх нь туйлын чухал.

Би та нарт гон хувьсан гарах талаар тодорхой яриагүй, та нарыг үүнд анхаарлаа төвлөрүүлэхийг хүсэхгүй байна, ийм байснаар хүмүүст зууралдсан сэтгэл гарахгүй, тэдний хүслийг дэвэргэхгүй. Дээш ахих тусам хүний сэтгэл улам амгалан болдог, гэхдээ өөрийн зан чанараа (шиншин-ээ) дээшлүүлэхгүйгээр амгаланд орох арга хайвал буруу. Зарим хүн дасгал хийж байхдаа амгаланд орохыг л бодоод байдаг, мөн хүсээд л байдаг, амгаланд орох гэж хүчилсээр зууралдсан сэтгэл үүсгэдэг. Би хэлбэл, доод түвшний бясалгалд арга техник гэдэг, дээд түвшнээс харвал энэ нь санаатайгаар хүчлэх. Яагаад? Бясалгалаар зууралдсан сэтгэлээ аажмаар арилгасаар байгаад амгаланд ордог. Ихэнх хүн өөрийнхээ зууралдсан сэтгэлийг шууд хаяад хүслээрээ бүрэн амгаланд орж чадахгүй (мэдээж зарим онцгой тохиолдол байдаг, бид үүнийг энд ярихгүй). Чи ямар нэг түвшний амгаланд хүрвэл чиний бодол тэр хэмжээнд хүртэл ариуссан гэсэн үг. Миний хэлсэн "онцгой тохиолдол" гэдэг нь Дэд сүнс (Фу-юаншэнь) бясалгахыг хэлж байгаа, тэгэхэд хүн эхнээсээ зохиомол байдлаар амгаланд орж чадна. Гэхдээ энэ бол манай Дафа-гийн

бясалгах арга биш. Энэ бол үл ялих төдий асуудал биш.

Би урьд хэлж байсан, хүн өөрийн зорилгодоо хүрэхийн тулд хүнийг өөрчлөх итгүүлэхийн тулд ярихад чиний үзэл бодол хэдий утга учиртай байсан ч бусдаар түүнийг бүрэн хүлээн зөвшөөрүүлэхэд хэцүү, тэдний зүрх сэтгэлийг хөдөлгөж чадахгүй. Яагаад? Би чамд тайлбарлая, яагаад гэвэл чиний хэлсэн үгэнд бодол чинь шингэсэн байгаа. Чи энгийн хүмүүсийн дунд амьдарч байна, чамд янз бүрийн хүсэл, сэтгэл хөдлөл байгаа, чиний их олон зууралдсан сэтгэл байгаа. Тиймээс чиний үгнүүдэд их төвөгтэй эмх замбараагүй бодол холилдсон байдаг учраас чиний хэлсэн үгийг эвдэрсэн, хүчгүй болгоно. Мөн, хүн юмыг өөрийн өнцгөөс харж хэлдэг, тэр нь орчлон ертөнцийн Фа-д нийцэхгүй байж мэднэ. Тиймээс үнэний хүч дутна. Түүнчлэн хүнтэй ярихдаа буруутахгүйн тулд өөрийн хаяаг манасан зүйл оруулдаг. Тэгвэл тийм санаатай хэлсэн үгний цаад утга ариун бус, үгнүүд нь хийсвэр, үр нөлөөгүй болно. Харин чиний бодол амгалан болж чадвал, зууралдсан сэтгэл чинь улам бага болбол, үймүүлэх бодол улам багасвал чиний хэлсэн үг хүчирхэг болохыг үзнэ. Би үйлгүй байх талаар ярихдаа хөндлөнгөөс оролцох ёсгүй зүйлд яагаад битгий оролц гэж хэлсэн бэ? Учир нь чиний үг энергитэй болсон, хүчтэй үг хүнийг өөрчилж чадна. Чи хэн нэгнийг өөрчилж байгаа нь сайн зүйл мэт байсан ч тэр нь буруу зүйл хийсэн болж болно. Чиний нүд өнгөцхөн зүйлийг л хардаг учраас жинхэнэ үнэнийг мэдэхгүй, урьд өнгөрсөн нүглийн учир шалтгааныг харж чадахгүй. Чиний түвшин дээшлэх тусам бодол чинь улам ариусна, чамаас гарах бодол, чиний хэлж байгаа үгс улам ариун болно. Цааш ингэж дээшилбэл ертөнцийн тодорхой түвшний зарчимд нийцнэ, ижилсэнэ. Чиний хэлсэн үг хүний зүрхэнд шууд хүрнэ, сэтгэлийн гүнд хүрч чадна, түүний амьний бичил ертөнцөд нэвтэрч чадна, харж байна уу, энэ үг ямар хүчтэй болохыг!? Чи амгаланд орох чадвартай болбол тодорхой нэг түвшинд хүрсэн гэсэн үг.

Бясалгалаар бид тодорхой нэг түвшинд хүрэхийн тулд тэр түвшний шаардлагад нийцэх хэрэгтэй. Эс бөгөөс чи тэнд хүрч чадахгүй. Тиймээс манай бясалгалд бид хүний зууралдсан сэтгэлээсээ салах хэрэгтэй, нүглийг арилгах хэрэгтэй, Фа зарчимд нийцэх хэрэгтэй гэдэг. Тийм учраас би та бүхнийг номоо тогтмол уншиж бай, Фа сайн ойлгох хэрэгтэй гэж байнга захидаг.

Би зөвхөн энэ утга учрыг өнгөцхөн дурьдлаа, өнөөдөр бол Фа конференц. Та нарт надтай уулзах боломж тэр болгон гардаггүй, энэ боломж олдсон дээр надаас асуух асуулт их байгаа байх. Тиймээс би үлдсэн цагт та нарын асуултанд хариулъя. Гэхдээ та нар нэг зүйлийг анхаарах хэрэгтэй: Зарим хүн (мэдээж шинэ сурагчид) өндөр ихэмсэг өнгө аястай асуулт тавьдаг Багшийгаа хүндэлдэггүй. Мэдээж миний шаардлага бол Багшийг хүндэтгэх хуучин зан үйл шиг их биш, гэхдээ би та нарын Багш, би та бүхнийг дээд түвшин лүү аварч байгаа. Миний та нарт өгч байгаа зүйл бол та нар үүрд төлж баршгүй зүйлс. Тиймээс та нарын хандлага сурагч шиг байна гэдэгт итгэж байна.

За одоо асуултын цаасаа дамжуулж болно.

Асуулт: Шагжамүни, Лаози, Есүс-ын дараа хэр олон хүн Тагаата ариун гэгээрлийн хутагт хүрч чадсан бэ?

Багш: Ерөнхийд нь хэлбэл их олон байсан. Шагжамүнигийн дараа олон хүн Номыг олсон,

тэд бүгд Буддын шашинд бясалгаж үр дүнд хүрсэн. Есүс-ийн хойч үеийн шавь нар бас бясалгаж үр дүнд хүрсэн байдаг. Хятадад мэдээж их олон төрлийн Номын бясалгал байдаг. Бясалгалын арга газар зүйн байршлаас хамаардаггүй учраас эрт үед Барууны нийгэмд бас Дао-гаар бясалгадаг хүмүүс байсан, тэднээс нилээд нь гэгээрлийн хутагт хүрсэн. Тэд шашны бус замаар үр дүнд хүрсэн. Гэхдээ сүүлийн үед цөөн хүн гэгээрлийн хутагт хүрсэн, орчин үеийн нийгэмд бараг нэг ч хүн байхгүй.

Асуулт: Жуан Фалунь 2-т сарыг эртний үеийн хүн төрөлхтөн бүтээсэн гэж байдаг. Багшаа та түүнийг бүтээсэн шалтгаан, зорилго юу байсныг тайлбарлаж өгнө үү.

Багш: *(Бүгд инээлдэв)* Миний Дафа заах зорилгоос их хол асуулт байна. Чи мэдээлэл хайж байна, өөрийн төсөөлөл, бодлын хойноос хөөцөлдөж байна, тэгвэл чиний бодол цэвэр, амгалан биш болно. Чи энгийн хүний зууралдсан бодлоо орхихын оронд надаас тэдгээрийг асууж бүр Фа-тай хольж байх юм. Энэ бол яг миний та нарт санаа зовдог зүйл. Бодол санаагаа бясалгалдаа чиглүүл. Гэхдээ нэгэнт асуусан болохоор би хариулья.

Түүхэнд хэзээ ч өнөөгийн шинжлэх ухаан шиг байдал байгаагүй. Өөр өөр үеийн хүн төрөлхтөн хөгжлийн янз бүрийн хэлбэртэй байсан. Тэр үеийн хүмүүс харанхуй шөнийг их хэмжээний бэрхшээл учруулж байгааг харсан, тэгээд дэлхийг шөнө гэрэлтүүлэх сарыг бүтээсэн. Энэ бол бясалгалтай ямарч холбоогүй. Би энэ талаар ярих дургүйдээ биш, миний хэлсэн үг ямар нэгэн зүйлийг баталгаажуулдаг, миний хэлсэн нь Фа болдог учраас та нар өөрсдийн сонирхсон зүйлээ битгий асууж бай.

Асуулт: Бодлын хурд гэрлээс хурдан уу?

Багш: Энэ бол маргаангүй үнэн. Хүний бодлын хурд нилээд их. Чиний түвшин өндөр байх тусам чи өөрийн түвшнээс доод бүх орон зайд нэвтэрч чадна, чиний гон чамаас доод түвшний орон зайд ороход тэр аль ч орон зайн цаг хугацаанд баригдахгүй. Гон бол бодолд захирагдана. Чи энэ орон зайд амьдарч байгаа учраас чиний алхааны хурд, чиний машины хурд, бүх зүйл энэ цаг хугацааны орон зайд хязгаарлагддаг. Хүний бодол энэ орон зайд маш хурдан. Харин бясалгаж байгаа хүн энэ орон зайн хязгаараас давбал түүний бодол үнэхээр хурдан. Бид хэлсэн, хүний гон болон биед байгаа бүх чадварууд бодлоор удирдагддаг. Энэ нь түүний бодол гарахад түүний гон тэнд хүрдэг, тийм л их хүчтэй. Би хэлсэн, та нарын зарим их өндөрт бясалгаж хүрсэн сурагчийн чадварыг түгжихгүй бол тэнгэр газрыг хөмрүүлж мэднэ. Тиймээс хүн гэгээрлийн хутагт хүрэхээс өмнө дэлхий дээр бясалгаж байхад хязгаарлагдахгүй байхыг туйлаас зөвшөөрөхгүй. Бага зэрэг чадвар бол байж болно, энэ орон зайг энэ орон зайн Бурхдууд удирдаж байдаг учраас тэр Бурхад энэ бүгдийг хянаж байдаг болохоор чи тэнгэрийг хөмрүүлж, газрыг хөрвүүлж чадахгүй. Харин хүний чадвар их хүчтэй бол зөвшөөрөхгүй. Багш бас үүнийг хянаж байхад оролцдог.

Асуулт: Хүний энэ ертөнцөд ямар матери хамгийн хурдан бэ?

Багш: Чи шинжлэх ухааны талаар асууж байна. Чамд хариулбал чиний ямар нэгэн зүйлийн хойноос хөөцөлдөх сэтгэлийг хангана, чиний зууралдсан сэтгэлийг хөөрөгдөнө гэсэн үг. Гэхдээ чи нэгэнт асуусан болохоор хариулья.

Энэ орон зайд хүний мэдэх хурд илүү их энергитэй, гэхдээ хүмүүс үүнийг илрүүлээгүй, ашиглаж чадахгүй. Хамгийн их, хамгийн бага гэдэг бол хүний байр суурины ойлголт, хүний орон зай цаг хугацааны хэмжигдэхүүний ойлголт. Энэ орчлон ертөнцөд хүмүүсийн хэрэглэдэг том багын ойлголт байдаггүй, тиймээс ертөнцөд хамгийн хурдан юу вэ гэж асуусан нь түвшнээс хамаарна. Жишээ нь: Заримдаа их өндөрт гэгээрч хүрсэн Бурханы ярианы хэм хэмжээ их удаан, гэхдээ чиний бодлоос хурдан. Би энд одоо ярьж байна, дөнгөж сая чиний зууралдсан сэтгэлийн талаар хэлсэн үг нь тодорхой нэг орон зайд хэдэн зуун жил өнгөрсөн, ийм л их ялгаатай. Ертөнц бол гайхамшигтай уудам том. Цаг хугацааны ялгаа нь ертөнцөд нарийн төвөгтэй орон зайнуудыг бий болгосон.

Үнэндээ "Хамгийн хурдан" гэдэг нь цаг хугацаанд хязгаарлагдахгүй, гэхдээ хүн энэ үгний жинхэнэ учрыг хэзээ ч ойлгохгүй. Чиний ойлголтыг авч үзье: "Ямар хурд ертөнцөд хамгийн хурдан бэ?" энэ бүгд бол хүний бодол, хүний ойлголт. Бидний орших энэ орон зай, цаг хугацаа бас туйлын биш. Би "Жуан Фалульд" бичсэн зарим харагдах одод биднээс 150 мянган гэрлийн жилийн зайтай гэсэн. Үнэндээ би орчин үеийн хүмүүсийн ойлгох шинжлэх ухааны хэллэгээр бичсэн. Жинхэндээ тийм биш. Яагаад? Бодоод үзье: янз бүрийн орон зайд өөр өөр цаг хугацаа оршдог. Манай дэлхийн хүрээнд дэлхийн цаг хугацааны орон оршдог, бүх зүйл энэ цаг хугацааны орон зайн хүрээнд хязгаарлагддаг. Хүний бүтээсэн хиймэл дагуул атмосферийн давхаргаас гарангуут өөр цаг хугацааны оронд ордог, дэлхийн цаг хугацаанаас өөр гэдэг нь ойлгомжтой. Мөн өөр гаригуудын хажуугаар өнгөрөхөд мөн өөр цаг хугацааны оронг дамждаг. Сансрын биет том байх тусам түүний цаг хугацааны орон болон хурдны ялгаа их.

"Тэнгэрийн заадас" галактикийн системд болсон үзэгдлийг бид харахын тулд 150 мянган гэрлийн жил хүлээх хэрэгтэй. Би та бүгдэд хэлбэл чи үүнийг зөвхөн 2-3 жилийн дотор харж магадгүй. Яагаад? Гэрлийн хурд бас цаг хугацааны орон зайн хязгаарлалттай. Гэрэл өөр өөр цаг хугацааны орон зайг нэвтрэхэд түүний хурд нэг бол хурдасч, нэг бол удааширч байдаг. Манай дэлхийд хүрэхэд дэлхийн цаг хугацааны орон зайн дагуу дахиад удааширдаг. Хэрэв чи ертөнцийн цаг хугацааг дэлхийн хүн төрөлхтний танин мэдэх цаг хугацаагаар тооцоолбол хэмжиж хэзээ ч чадахгүй. Хүний үнэний ойлголт, матери, амь бодь болон орчлон ертөнцийн талаархи төсөөлөл болон бусад олон зүйлийн талаархи ойлголт буруу, хүний үүслийн хувьслын онол бас буруу.

Асуулт: Буддын системийн гэгээрэгчид ертөнцийн гэрлийг юу гэж тайлбарладаг вэ?

Багш: Зөвхөн гэрлийг харж байвал юу нь гайхамшигтай гэж?! Янз бүрийн гэрэл байдаг, тэдгээр нь янз бүрийн түвшинд өөр өөр. Мөн гэрлийн эх үүсвэр болон ямар зорилгоор гэрэлтэж байгаа нь бас өөр. Хүнийхээс дээгүүр зүйлийг хүний сэтгэхүйгээр битгий бод. Хэрэв чи бясалгахыг хүсч байвал номоо их уншиж Фа сайн сурах хэрэгтэй гэж хэлмээр байна. Чиний ухамсарлаж чадахгүй байгаа, ойлгохгүй байгаа зүйлсийг ирээдүйд Фа чамд харуулна. Бодоод үз: Биет болгон энергитэй гэж би хэлсэн, молекулууд хүртэл бас энергитэй. Хүн өөрөө молекулаас тогтсон болохоор молекулын энергийг мэдэрдэггүй. Тийм учраас мэдэрдэггүй. Энергитэй зүйлс гэрэлтэй бас эрчим хүчтэй. Довыг битгий уулын чинээ болго, ялихгүй зүйлээс битгий шуугиан дэгдээ. Дафа сурагчийн агуу буян илрэх тэр өдөр тод гэрэлтэх болно.

Асуулт: Багшийн номыг Фа түгээхийн тулд сонинд хэвлэж болох уу? Гэхдээ хүмүүс үүний агуулгыг гуйвуулах вий гэхээс болгоомжилж байна.

Багш: Гуйвуулж болзошгүй учраас тэгж хийж хэрэггүй. Яагаад? Би хэлье: Фа түгээх хамгийн сайн арга бол хамтдаа дасгалаа хийх. Бид хувь тавилантай хүмүүсийг орхигдуулахгүй байх талаар ярьж байна. Би бүх хүнд Дафа-г хүргэхийн тулд заагаагүй, тийм ойлголт огт биш. Би Дафа-тай учрах хувь тавилантай хүмүүсийг хэлж байна. Би өнөөдөр та нарт энэ талаар тодорхой ярья. Бидний Фа түгээх энгийн хэлбэр бол дасгалаа гадаа хийх. Өөр нэг хэлбэр нь: Номын дэлгүүрүүдэд Фалунь Дафа-гийн номнууд худалдаалагдаж байгаа. Миний номын бие тэр хувь тавилантай хүмүүсийг тэндээс ном авхуулна, тэд уншаад сурах гэж ирнэ. Түүнээс гадна бид дасгалаа гадаа хийж байгаа, миний Номын бие түүнийг Дафа олуулахаар тийшээ явуулна. Ямар нэгэн байдлаар түүнийг энд сурахаар ирүүлнэ, эсвэл тэр өөрөө Дафа сурагчдыг олно. Бид ингэж зохион байгуулна. Та нар энэ талаар бүр олон хүн мэдэхийг хүсч байгаа, олон арга хэрэглэж байгаа, би сурагчдын энэ сэтгэлийг харж байна. Та нарын хийж байгаа энэ бүгд бол сайн хэрэг, гэхдээ хувийн санаачлага, би тэгж хийх хэрэгтэй гэж хэлэхгүй. Би Фа түгээх дараахь хэлбэрийг үлдээсэн: Бид гадаа дасгалаа хийнэ, Фа коференц, мөн номын дэлгүүрт ном зарах. Тэдгээр урьдын хувь тавилантай хүмүүс очиж авна. Тэд уншаад хичээллэхийг хүснэ, тэгээд сурахаар биднийг өөрсдөө олж ирнэ, ийм л юм. Мэдээж сурагчид заримдаа бусдад мэдүүлэхийн тулд сонинд хэвлүүлдэг, энэ бас олон хүнд Дафа-г хүргэхэд тустай, би энэ хэлбэрийг үгүйсгэхгүй байна, мэдэх ёстой хүмүүс нь бас мэдэж авна. Гэхдээ би Фа түгээх хамгийн сайн хэлбэр бол хамтын дасгал хийх болон Фа конференц гэж хэлсэн.

Асуулт: Би Дафа түгээх нь бясалгалын салиггүй зүйл гэж үздэг, гэхдээ Багш Дафа түгээх нь гэгээрлийн үр дүнд хүрэхэд ямарч холбоогүй гэсэн.

Багш: Дафа түгээх, гэгээрлийн хутагт хүрэх гэдэг нь мэдээж хоёр өөр ойлголт. Гэхдээ нэг зүйл бий, хэрэв Дафа түгээхдээ бид үүнийг нэг ажил гэж авч үзэн хэдий хичээнгүйлэн хийгээд гэхдээ бага уншаад, мөн дасгал хийхдээ цаг гаргахгүй бол тийм ажил бол Дафа-гаас хөндийрнэ, чи бясалгалаа энэ ажилтай холбохгүй байна гэсэн үг. Чи энэ ажлыг хийхдээ их зууралдсан сэтгэлтэй, тохиолдож байгаа бэрхшээлийг чиний зан чанараас (шиньшин-ээс) болж байж магадгүй гэж бодохгүй, бясалгагчийн болон Фа зарчмын дагуу хийж байна уу, үгүй юу гэж бодохгүй, шалтгааныг өөрөөсөө хайхгүй дотогшоо харахгүй байвал, энэ бол зөвхөн энгийн хүний хийсэн ажил болно, энгийн хүн Дафа-гийн ажил хийсэн болно, бясалгагчийн шаардлага дагуу хийгээгүй болно. Бясалгалыг ажилдаа хэрэгжүүлэх хэрэгтэй. Ажил хийх явцад хүнд асуудал тулгарвал шалтгааныг өөрийн зан чанараас хайж шинжиж чаддаг байх хэрэгтэй. Хүнд бэрхшээл тохиолдвол өөрөөсөө асуу, яагаад ийм асуудал гарах болов? Би алдаа гаргасан уу, үгүй юу? Миний санаа буруу байв уу? Эсвэл өөр ямар нэгэн шалтгаанаас болов уу? Ингэж өөрөөсөө шаардах хэрэгтэй, үргэлж бясалгагчийн байр суурьнаас хандах хэрэгтэй. Өөрийгээ бясалгагч гэдгээ үргэлж санаж явбал чи бясалгагч, хийж байгаа зүйл чинь Фа-тай нийцэхгүй гэж үү? Гэгээрлийн хутагт хүрэхийн хувьд өөрийнхээ бясалгалын чанараас гэгээрлийн хутагт хүрч чадах эсэхийг харах хэрэгтэй. Өдөр бүр бясалгаж байгаа хүнийг авч үзье, гэгээрлийн хутагт хүрч чадах эсэх нь түүний шаардлагатай түвшинд хүрсэн эсэхээс шалтгаална.

Асуулт: Би өдөр бүр "Жуан Фалунь" уншдаг, миний бодлоор бол "Жу Юу Кэ-ид шидийн анги зүйл", "Бигу", "Чий хулгайлах", "Чий хураах" зэрэг гарчиггаас ерөнхийд нь ойлгоход хангалттай юм шиг санагддаг.

Багш: Би чамд хэлбэ, хэдийгээр тэдгээр зүйлийг жишээ маягаар хэрэглэсэн ч миний хэлсэн түүгээр хязгаарлагдахгүй. Миний ярьсан бол Фа зарчим! Тэдгээрийн цаад утга хэмжээлшгүй, хязгааргүй, төгсгөлгүй. Сансар ертөнц хэдийгээр агуу том ч гэсэн Фа түүнээс багагүй. Би хүний хамгийн энгийн үйлдлээр, хамгийн энгийн үгээр, хамгийн доод хүний хэлбэрээр энэ Фа-г зааж байна. Зорилго нь чамд үүний хязгааргүй, төгсгөлгүй гүн утга агуулгыг ойлгуулах, ухамсарлуулахад юм. Тиймээс үүнийг түүж алгасаж уншиж болохгүй. Чи Фа-г эхнээс нь авхуулаад дуустал юу ч орхилгүйгээр унших хэрэгтэй. Үүнийг анхаар. Алгасахгүй унших нь чиний бясалгалд тустай. Фа-д дараалал байдаг, тиймээс түүж уншиж болохгүй.

Асуулт: Сурагчдын эргэн тойронд болж байгаа бүх зүйлс Багшийн зохицуулалтаар бий болсон уу?

Багш: Эргэн тойрны байдлыг бий болгоогүй, бясалгалын явцад чамайг хүрээлэн буй бүх зүйлс бол чиний хувь тавилангийн зохицуулалт. Энэ бол чиний урьд хийсэн нүглийн үр, мөн хийсэн сайн үйлийн шагнал. Бүх зүйл чиний сайн муу талын үр дүн. Би чамайг бясалгуулахын тулд үүнийг ашигладаг. Тэдгээрийг би үүсгэсэн биш. Тиймээс саад бэрхшээл тохиолдоход чи үнэхээр нүглээ наминчилж байдаг, энэ бол эргэлзээгүй юм. Сурагчдын зүүдэндээ болон бясалгаж суухдаа харсан болгон хуурамч биш, олон зүйлийн бодит илрэл байдаг. Чи тодорхой л харж чадахгүй байгаа.

Асуулт: Та гэгээрлийн хутагт хүрэх сурагчиддаа хандан өөрийнхээ бясалгалаас ярина уу.

Багш: Чи энэ талаар гэгээрлийн хутагт хүрэхээрээ мэдэх болно. Энэ талаар би эхлээд ярих гэж байсан. Гэхдээ одоогийн байдлаас болж боломжгүй болсон. Яагаад боломжгүй болов? Яагаад гэвэл ирээдүйн хүмүүст миний талаар мэдүүлэхгүй, тийм учраас өөрийнхээ талаар хэлж үлдээмээргүй байна. Та нарын хувьд гэгээрлийн хутагт хүрээд л энэ талаар мэдэх болно. Тэр үед чи бүх хэлийг хэрэглээд ч илэрхийлж чадахгүй- чиний Багш ямар аугаа гэдгийг! (Алга ташив)

Би зөвхөн та нарын төлөө бүхнээ зориулаагүй, мөн бүх амь бодийн төлөө, надад байгаа бараг бүхнээ шавхсан. Мэдээж тэр зориулсан бүх зүйлс алга болсон гэсэн үг биш, та нарын ойлгож байгаагаар юу ч үлдээгүй гэсэн үг биш. Би ийм нэг үгийг дандаа давтдаг байсан: Би та нарыг бясалгалаар дээшилж чадах бүх зүйлийг, бясалгалаар олж авах бүх зүйлийг, бүгдийг энэ номонд оруулсан. Та нар янз бүрийн түвшинд байгаа ч гэсэн миний үгийн ямар жинтэй болохыг жинхэнэ ойлгож чадахгүй. Чи зөвхөн бясалгавал бүхнийг олж чадна. Гэхдээ та нарын олсон зүйлд миний хэр их зүйл шингэснийг мэдэх үү? (Алга ташив). Мэдээж би өөрийнхээ эдгээр зүйлийг ярихыг бодоогүй, зөвхөн та нарын төлөө миний хийсэн, Багшийнхаа та нарт өгсөн зүйлийг нандигнах хэрэгтэй гэж хэлмээр байна! Та нар зохих ёсоор сайн бясалгах хэрэгтэй, хувь тавилангаар олдсон энэ боломжоо битгий алдаарай.

Асуулт: Бид хэзээ Европын сурагчдын орчуулсан Дафа-гийн номтой болох вэ?

Багш: "Жуан Фалунь" удахгүй гарна. Энэ номын Франц орчуулга хэд хоногоос хэвлэлтэнд орно, Англи хэлний хувилбар гарсан байгаа, Герман хэл дээр хэвлэгдсэн нь номын дэлгүүрүүдэд байгаа, олон дэлгүүрүүдэд зарагдаж байгаа. Бусад хэлний орчуулгууд бас хийгдэж байна. Жишээ нь: Итали, Испани хэлээр, Орос хэлний орчуулга аль хэдийн хэвлэгдэж гарсан. Барууны орнуудын хувьд орчуулга ийм байна. Бусад хэл дээр бас хийгдэж байгаа. Миний хувьд энэ асуудал дээр үнэхээр санаа зовж байна, нөхцөл байдал бүрдээгүйгээс хойшилж байна., түүнээс гадна та нарын мэдэхгүй янз бүрийн үймүүлэл байгаа.

Асуулт: Зан чанараа бясалгах хамгийн чухал, Багш номондоо яагаад бясалгалын түвшин, ер бусын чадварын талаар бичсэн бэ?

Багш: Шинэ сурагчдын тавьсан олон асуулт байна. Номоо эхлээд унших хэрэгтэй, дараа нь асуу! Бясалгал бол Буддын чадвартай нягт холбоотой, чамд ойлгуулахын тулд энэ зүйлийн талаар хэлсэн, Фа зарчим, онолын үндсэн дээр зөвхөн ерөнхий утгыг тайлбарласан. Би сурагчдад бусдыг нь ойлгуулахын тулд нэг жишээн дээр авч ярьсан, тийм л учиртай. Би энэ талаар ярьдагч чамайг эдгээр зүйлд тэмүүлэхийг зөвшөөрөхгүй байгаа хэрэг биш, үүнийг Буддын Фа-гийн бясалгалаас салгах аргагүй. Чиний юу хүсэх, болон Фа үнэнийг ойлгох бол бүхэлдээ хоёр өөр зүйл, ер бусын чадвар бол Буддын Фа-гийн өөр нэг илрэх хэлбэр. Чи Буддын Фа-гийн ер бусын гайхамшигт чадварыг харж чадахгүй байгаа нь чи номоо хүний сэтгэлээр уншдагаас юм. Чи өөрийнхээ сэтгэлд ойр зүйлийг уншдаг, энгийн хүний сэтгэхүйгээр ойлгогдохгүй зүйлийг уншдаггүй, хүлээн авдаггүй. Чиний дээш ахидаггүй шалтгаан нь үүнд байна.

Асуулт: Яагаад ижил хүйстнийг ёс суртахуунгүй гэдэг вэ?

Багш: Та нар бодоод үз, ижил хүйстэн байх хүний явдал мөн үү? Тэнгэрээс эрэгтэй, эмэгтэй хүнийг бүтээсэн. Энэ нь ямар зорилготой вэ? Хойч үеэ үлдээхийн тулд. Тэгвэл эрэгтэй хүн эрэгтэй хүнтэй, эмэгтэй хүн эмэгтэй хүнтэй хамт байвал зөв бурууг нь хэлэхэд их бодоод байх зүйлгүй. Хэрэв хүн бага зэрэг буруутвал түүнийг алдаа хийсэн гэж үзэж болно, хэрэв том зүйл буруу хийвэл түүнд хүний ёс суртахуун байхгүй байна гэнэ, хүн байх нь түүнд таарахгүй гэсэн үг.

Би өнөөдрийн нийгэм яагаад ийм болсныг хэлье. Хүн төрөлхтнийг барьж байх ариун Фа байхгүй болсноос юм. Хүн төрөлхтний байдал хамгийн замбараагүй болсон, шашин хүнийг аварч чадахгүй болсон үед, Бурхад хүмүүсийг харж хандахаа больж орхисон энэ үед Дафа заагдсан. Фа бол бүхнээс хүчтэй. Сайн цаг үед ийм аугаа Фа заах шаардлагагүй, зөвхөн хамгийн хэцүү муу болсон үед Фа-гийн сүр хүч илэрдэг. Бас өөр шалтгаан бий.

Асуулт: Яагаад ижил хүйстнүүдийг муу хүмүүс гэдэг вэ?

Багш: Би хэлье: Өнөөдөр энэ Дафа дэлгэрээгүй байсан бол Бурхад бүхнээс түүрүүнд ижил хүйстнүүдийг устгах байсан. Тэднийг устгах нь би биш, харин Бурхад. Ижил хүйстнүүд өөрсдийгээ зөвтгөх гэж маргадаг, эртний Грекийн соёл иргэншлийн үед хүртэл ижил

хүйстнүүд байсан. Тийм, эртний Грекэд төстэй зүйл байсан. Гэхдээ чи яагаад эртний Грекийн соёл иргэншил алга болсон бэ гэдгийг мэдэх үү? Яагаад эртний Грекчүүд үгүй болсон бэ? Яагаад гэвэл тэд ийм хэмжээнд хүртэл доройтсон, тиймээс тэднийг устгах хэрэгтэй болсон.

Бурхад хүнийг бүтээхдээ хүний хэв шинж, амьдрах байдлыг тогтоож өгсөн. Хэрэв хүн энэ хүрээнээс гарвал, хэдийгээр хүний гадаад төрхтэй байсан ч хүн гэж тооцогдохгүй болно. Бурхад тэднийг цаашид оршихыг зөвшөөрөхгүй устгана. Дэлхийд яагаад дайн дажин, өвчин тахал, байгалийн гамшиг, сүйрэл болдог вэ? Эдгээр нь хүний нүглийг арилгахын тулд оршдог, яагаад гэвэл хүн нүгэлтэй. Ирээдүйд ямарч сайхан үе болсон дэлхий дээр дайн, өвчин тахал, байгалийн гамшиг, сүйрэл байсаар байх болно. Энэ бол хүмүүсийн нүглийг арилгах арга. Хэн нэгэн муу хэрэг үйлдвэл түүний нүглийг махан биеэр нь үхэл, зовлон амсуулж байж арилгана, тэгвэл тэр дахин төрөхдөө нүгэлгүй болно. Түүний амь жинхэнэ устахгүй дахин төрөл олж амьдарч болно. Гэхдээ хэт их нүгэл үйлдсэн бол түүний амь бүрэн устахад хүрнэ. Ижил хүйстнүүд Бурхнаас тогтоосон хүний хэв шинжийг зөвхөн зөрчөөд зогсоогүй хүний нийгмийн ёс суртахууны хэв хэмжээг эвдсэн, хүүхдүүдэд муугаар нөлөөлж ирээдүйн нийгмийг бузарлана. Ийм асуудал гарна. Гэхдээ тийм устгалд дороо устаад алга болно гэсэн үг биш, түүнийг давхарга давхаргаар устгана. Бидний харахад устгал их хурдан, гэхдээ түүний орших тэр цаг хугацааны орон зайд бүгд удаан явагдана, удаан үргэлжлэнэ, маш зовлонтойгоор дахин дахин устана. Энэ бол маш аймшигтай зүйл. Хүн гэгээлэг байх хэрэгтэй, хүний ёсоор зохистой амьдрах хэрэгтэй. Чөтгөрлөг талаа давамгайлүүлж юу хүссэнээ хамаагүй хийж болохгүй.

Асуулт: Би гэгээрлийн хутагт хүрэхийг хүсч байна. Миний зорилго бол Архат түвшинд хүрэх. Надтай хувь тавилангийн холбоогүй хүмүүст би туслахгүй, Дафа тараахгүй. Би буруу хийж байна уу?

Багш: Чи буруу хийж байна, энэ бол хүний өнгөцхөн бодол. Та нар миний хэнд нь ямар түвшинд хүрэхийг төлөвлөснийг, чамд хэр их тэвчих чадвар, хэр хэмжээний Дэ буян байгааг, мөн чиний суурь зүйл ямар болохыг мэдэх үү? Энэ бүгдийг би чамд их сайнаар зохицуулсан. Чи өөрөө өөртөө бясалгах замаа төлөвлөхийг хүсч байна уу? Гэхдээ үндэслэлтэй болж чадахгүй, хэн ч түүнийг хүлээн зөвшөөрөхгүй. Чи өөртөө яагаад Архат түвшинг төлөвлөв? Яагаад гэвэл чиний Дафа-г ойлгосон түвшин зөвхөн тэнд л хүрсэн, чи зууралдсан олон сэтгэлээ оршихыг хүсэхгүй байна, одоо чи зөвхөн тэр хэмжээнд Фа ойлгож байна. Ирээдүйд чиний Фа ойлголт дээшилхэд, чи Дафа-гийн номыг олон удаа давтан уншихад өөрийнхээ энэ бодлоо өөрчлөх нь дамжиггүй, ийм асуулт тавих ёсгүй байснаа ойлгоно, ичих болно. Би үүнийг чиний зөвхөн одоогийн байр суурь гэж хэлнэ, тиймээс чамайг зэмлэхгүй, гэхдээ чиний хэлсэн буруу. Үүнээс болоод чи өөртөө тавих шаардлагаа сулруулж байна, зууралдсан сэтгэлээ оршихыг хүсэхгүй байна, чамд шургуу урагшлахад хэцүү болно.

Асуулт: Би анх энэ бясалгалаар хичээллэж эхлэхдээ их хичээнгүй байсан. Гэхдээ саяхнаас гэнэт Дафа-д эргэлздэг болсон. Би дараалан алдаа хийж сорилтыг давж чадаагүй. Энэ нь бодлын нүглээс болсон уу эсвэл чөтгөрийн үймүүлэл үү?

Багш: Би яагаад та нарыг эх үндсэндээ буц, үнэнд хүр гэдэг вэ? Энэ нь жинхэнэ

өөрийнхээ байсанд буц гэсэн үг. Хүнд олон янзын зууралдсан сэтгэл байдаг, янз бүрийн үзэл бодол, сэтгэлийн хөдөлгөөн, хүсэл байдаг. Энэ бүх бодол толгойд чинь эргэлддэг, гэхдээ аль нь ч чинийх биш. Энэ үүд өргөн нээлттэй байгаа, зөвхөн чиний сэтгэл л мэднэ. Хүний сэтгэл л зөвхөн бясалгах үгүйг шийднэ, өөрийн эх үндсэндээ буцах үнэнд хүрэх бодол, хүсэл байгаагаас хамаарна. Чамд саад болж байгаа бодол болгон чиний өөрийнх биш байж болно. Зарим хүний хувьд энгийн хүмүүсийн дунд ашиг сонирхлоосоо салж чаддаггүй, өөрийн бодлоо ялгаж чаддаггүй, зарим нь тэр гарах муу бодлыг өөрийнхөө бодол гэж үздэг, бид тийм хүнийг хариуцахгүй. Яагаад? Яагаад гэвэл тэдгээр муу бодлыг өөрийнхөө бодол гэж үздэг, тиймээс бид бүхнээ тэр муу бодолд өгч болохгүй.

Асуулт: Жуан Фалунь номонд аугаа Бурхад өөрсдийн мөн чанарын дагуу ертөнцийг бүтээдэг гэж байдаг.

Багш: Би хэлье, олон хүн энэ хэсгийг уншсан (гайхширдаг). Үүнд бүх ертөнцүүдийг багтаадаг уудам сансрын биетийн олон давхаргын ертөнцүүдэд болсон үйл явдлыг хэлж байна. Энэ сансрын биет бол хязгааргүй уудам. Миний хэлсэн нь бүхэл сансрын биетийн хэмжээнд болсон үйл явдал биш. Сансрын биетийн өөр өөр түвшний аугаа гэгээрэгчид сансар ертөнцийн Дафа-гийн зарчимд өөр өөрөөр гэгээрсэн. Нэг түвшний аугаа гэгээрэгчид хүртэл өөр өөрөөр ойлгодог. Уудам сансрын биетийн янз бүрийн хэмжээний зарим ертөнцүүд муу болоход дээд түвшний ариун номонд гэгээрсэн аугаа гэгээрэгчид тэр түвшинд ертөнцийг шинээр байгуулдаг. Энэ нь тоо томшгүй олон давхаргын ертөнцүүдийг багтаасан зүйрлэшгүй уудам сансрын биетийг хэлээгүй.

Асуулт: "Цаг хугацаатай хийсэн ярилцлага" товхимолд Бурханы тухай хэлсэн. Бурхан гэж хэн бэ? Бурхад болон Будда, Дао-гийн хооронд ямар ялгаатай вэ? Анхны бурханаас ямар ялгаатай вэ?

Багш: Орчлон ертөнцөд энгийн хүний чадвараас давсан амь бодь болгон Бурхдууд. Агаарт тэр даяар орших микро бүтэцтэй асар том, тоолшгүй олон амь бодиуд бол хэлбэр дүрсгүй Бурхдууд. Ийм ойлголт гэсэн үг. Бурхадын түвшин янз бүр, бүр олон төрлийнх байдаг. Буддууд бурхад биш гэж үү? Дао нар ч гэсэн бурхад биш гэж үү? Ерөнхийд нь хэлбэл тэд цөм гэгээрэгчид. Тэдэнд зөвхөн бясалгалын ялгарах онцлог, гадаад хэлбэр, мөн тэдний үүсгэн бий болгосон үндсэн зүйлс байдаг, тиймээс заримыг нь Дао, зарим нь Будда мөн заримыг нь Бурхад гэж хэлдэг. Орчлон ертөнцийн бүх зүйлс юу ч үлдээлгүй цөм амьтай, сэтгэн бодох чадвартай. Чи тэдгээрийг Бурхад гэж үзэж болохгүй гэж үү? Аль ч орон зайн цаг хугацаа тухайн орон зайд явагдах бүх төрлийн материйн өөрчлөлтийг хязгаарладаг. Чи цаг хугацааг Бурхан гэж хэлж болохгүй гэж үү? Тэр өөрийн захирах орон зайн бүх амь бодийн бодлыг мэдэж чадна, хүсвэл ярьж чадна, хэрэгтэй бол хүн дүрст хувирч чадна. Чинийхээр энэ нь Бурхан биш гэж үү? Хүмүүс цаг хугацааг нар мандах жаргах хоорондын зүгээр нэг ойлголт гэж үздэг. Хүмүүс цаган дээр хэдэн цэг тэмдэглээд, хэдэн тоо тавиад л үүнийгээ цаг хугацаа гэдэг. Энэ бол зөвхөн энгийн хүний нийгэм дэх нар мандах жаргахыг багтаасан цаг хугацааны илрэх хэлбэр. Би та нарт хэлье, нар мандах, жаргах, дэлхий нарыг тойрох бүгд энэ орон зайн цаг хугацаанд захирагддаг, ямарч хазайлт байхгүйгээр зохицуулагдсан байдаг.

Асуулт: Би өөртөө гэгээрлийн хутагт хүрэх зорилго тавьсан. Багш Дафа заахаа больвол Багшийн номын бие намайг хамгаалах уу?

Багш: Үнэндээ би Дафа заахаа зогссон, Дафа-г системтэйгээр заах хугацаа дууссан. Би одоо зөвхөн Фа конференцэд ирсэн, тэгээд энэ боломжийг ашиглан та нарын зарим асуултанд хариулж байна. Зааварчилгаа өгөх төвийн зохион байгуулагчид намайг та нарт илүү дээгүүр зүйл ярихыг, их ярихыг үргэлж хүсдэг. Урьд Дафа заах нь миний хамгийн тэргүүн чухал зүйл байсан, одоо бол та нарын бясалгаж дээшлэх нь хамгийн чухал. Номын бие та нарыг хариуцахаа больж болох уу? Миний Номын биес та нарыг хариуцахаа болих үед та нар аль хэдийн гэгээрлийн хутагт хүрсэн байх болно.

Асуулт: Дафа-д дөнгөж орсон зарим шинэ сурагчид Багшийн 1998 оны өмнөх Хойт Америкт Фа заасан видео бичлэгийг үзэж, аудио бичлэгийг сонсох их дуртай. Тэгж байж болох уу?

Багш: Миний анх Америкт Дафа зааж байсан лекц хэвлэгдэн гарсан, энэ номыг унш, энэ нь Дафа-г ойлгоход их ач холбогдолтой. Видео бичлэгийг үзэхэд тийм нөлөө үзүүлэхгүй байж болно, яагаад гэвэл би тэр үед Дафа сонсож байсан сурагчдын тодорхой байдалд тохируулан ярьсан болохоор чамд шууд хамааралтай биш байж болно. Номны хувьд бол бүгдэд хандсан, дахин засварлагдсан. Түүнээс гадна видео бичлэгэнд миний заасан онцлог байдлыг анзаарсан байх, би нэг зүйлийн талаар ярьж, ярьж байгаад гэнэт өөр сэдэв лүү ордог. Өөр асуудлаар ярьж эхэлдэг, та нар үүнийг анзаарсан байх. Яагаад вэ? Яагаад гэвэл би ярьж байхдаа сурагчдын ойлгосныг мэдэнгүүт үргэлжлүүлж ярихаа болиод өөр асуудал руу шилждэг байсан. Ийм байдал миний видео бичлэгэн дээр олон удаа давтагддаг, тийм учраас ном унших нь үүнийг үзсэнээс олон талаар давуу. Ийм л утгатай юм. Ном, дүрст бичлэг хамт байхдаа хоорондоо саад болж болно, тиймээс Дафа-гийн ном дэлхийн олон газруудад хэвлэгдэн гармагц Дафа-г хамгаалах үүднээс бүх дүрст болон дуут бичлэгүүдийг арилгах хэрэгтэй. Үүнийг хийхээс татгалзаж байвал энэ нь хүний сэтгэл.

Асуулт: Манай эхнэр бид хоёр Дафа-гаар хичээллэдэг. Хэдэн сарын өмнө бид хоёр дараалан тун үзэсгэлэнтэй том шувуу зүүдэлсэн. Тэр шувуу миний бие рүү ороод алга болсон, манай эхнэр тэр шувууны дууг сонссон. Энэ ямар учиртай вэ?

Багш: Энэ бол зүгээр л шувуу. Чи урьд амьдралууддаа төрөл олохоор маш өндөр түвшнээс бууж ирсэн Бурхан байсан ч гэсэн магадгүй энэ насандаа хүн, дараагийн төрөлдөө магадгүй амьтан болж төрнө, хүний орчлонд ийм л байдаг. Бясалгалын эхэнд харсан зүйл бол магадгүй чиний урьдын хэлбэр, эсвэл урьд байсан газрын байдал. Энэ нь хүний, амьтны хэлбэртэй, эсвэл ийм ч тийм ч хэлбэртэй байж болно. Тэнгэрийн шувуу бол бас Бурхан.

Асуулт: Бясалгадаг хүн энергийн бэлдмэлүүдийг хэрэглэж болох уу?

Багш: Чи ном уншаагүй байна, үнэндээ чи ном уншаагүй байна. Боддоо, бясалгадаг хүний бие өвчтэй бол гон гарахгүй. Чиний бие цэвэр биш бол бясалгаж чадахгүй. Энэ нь чамайг бясалгаж эхлэхэд л чиний биеийг цэвэршүүлэх хэрэгтэй, бүрэн цэвэршсэний дараа гон гарч болно. Тиймээс бид өвчин эмчлэхгүй гэж хэлдэг. Гэхдээ би жинхэнэ сурагчийн

биеийг ариусгаж өгнө, тийм бие өвчингүй болно. Бид Буддын түвшний биетэй болохыг зорино. Чи энергийн бэлдмэлүүд хэрэглээд тийм биетэй болж чадах уу? Мэдээж болж чадахгүй. Тэгвэл түүнийг хэрэглэх ямар хэрэгтэй юм? Энэ нь ямар нэгэн амттай идмээр зүйл ч биш. Бясалгалын явцад бидний тавих зорилго бол чиний биеийг улам цэвэршүүлэх, хамгийн сайн байдалд хүргэх, тийм байдалд эм бэлдмэл хэрэглэж хүрч чадахгүй. Чи эм хэрэглэж байвал бясалгалд эргэлзэж байгаа хэрэг биш үү? Чи өөрийгээ бясалгагч гэж авч үзэхгүй байна. Тийм биш гэж үү? Чи өөрийгээ бясалгагч гэж авч үзэхгүй бол бид чамд бясалгагч гэж хандаж болох уу? Тийм биш үү? Хятадын эмчилгээний ургамлаар бэлдсэн эм, Европын эм- энэ бүгд бол эм, маргаангүй. Чиний зорилго нь эрүүл биетэй болох, манай бясалгал бол үүнээс хол давсан. Ийм ялгаатай. Тэгвэл чи энэ асуудалд яаж хандвал зохистой гэж үзэж байна?

Асуулт: Бид Хятадаас ирсэн сурагчид. Бидний өөр таван сурагчид ямар нэгэн шалтгаанаас болоод ирж чадаагүй. Энэ нь чөтгөр, муу талын их саад байв уу? эсвэл Багийн зохицуулалт уу?

Багш: Та тавыг би энд ирэг гэж бас бодоогүй. Яагаад? Би дөнгөж сая хэлсэн, миний Дафа заах бол урьд хамгийн нэн тэргүүний чухал зүйл байсан, харин өнөөдөр бол нэгдэх чухал асуудал бол та нарын бясалгах, дээшлэх. Та нарын бүх анхаарал бясалгалдаа төвлөрөх хэрэгтэй, тууштай дээшлэх хэрэгтэй, энэ бол хамгийн чухал. Чиний сэтгэл тавгүй, намайг хайна, Фа сонсох гэж хаа сайгүй миний хойноос дагана, ингэх нь чиний бясалгалд сайн зүйл болохгүй, ямар ч ашиггүй. Сингапурт Фа конференц болоход Хятадаас олон хүн ирэхийг хүссэн. Тэгэхэд би зохион байгуулах зөвлөлд хэлсэн: Та нар бүгдэд хэлэх хэрэгтэй, орон нутгийн зааварчилгаа өгөх хэсгүүдэд дамжуул, сурагчдыг хаа сайгүй дагаж яваад хэрэггүй, ямар ч ашиггүй гэж зөвлөх хэрэгтэй гэсэн. Энэ хугацаанд Номын бие та нарт бясалгалын тодорхой систем тогтоосон, харин та нар зөрчиж байна. Бясалгалын энэ үед та нарын зарим зууралдсан сэтгэл арилах ёстой байсан байж болно, энэ тал дээр дээшлэх хэрэгтэй байсан нь бүтэлгүй болсон, үүнд учир нь байгаа юм. Хэрэв та нар ямар нэгэн зүйл хийх гэхэд та нарын зууралдсан сэтгэлээс болоод бүтэхгүй байвал үүнийг буг чөтгөрийн үймүүлэл гэж битгий бод.

Асуулт: Миний нөхөр хэзээ ч дасгал хийж байгаагүй, харин нэг удаа "Жуан Фалунь" уншиж, Багийн Фа заасан видео бичлэгийг үзсэн. Түүний тэнгэрийн мэлмий нээгдсэн, мөн далдыг харах ер бусын чадвар гарсан.

Багш: Энэ бол түүний урьдчилсан хувь тавилангаас түүний төрөлхийн суурь бас их сайн байж болно, ном уншингуут түүний тэнгэрийн мэлмий нээгдсэн. Гэхдээ түүний сурах эсэх нь, энэ амаргүй нийгэмд хүн бүрт их ээдрээтэй болсон. Энд хүрэлцэн ирсэн хүн бүрт хүний орчлонд ирэхээс өмнө сэтгэлийн чинь гүнд өнөөдрийн Дафа-г олж авах билэгдлийн үрийг суулгасан. Хүний орчлонд би та нарыг олон удаа олж тэмдэг тавьсан. Энэ бүх зүйл хүчтэй нөлөөтэй. Гэхдээ энэ нь чиний энгийн хүмүүсийн дунд зууралдсан сэтгэлийг сулруулж чадахгүй, чи анх Фа олж аваад "Би үүнийг олж авахын тулд ирсэн, би хичнээн их удаан хүлээвээ!" гэж чамд санагдахгүй. Ихэнх хүнд ийм мэдрэмж төрөхгүй, тиймээс бясалгалдаа шургуу биш, тэгж ингэхийсэн байдалтай хандана. Хувь тавилан Дафа олоход хүргэсэн, гэвч тэр зууралдсан сэтгэлээ орхихгүй, янз бүрийн байдал байдаг, эцэст нь хувь тавилангийн холбоо дуусахад бүх зүйл дуусна.

Асуулт: Багш хас тэмдгийн талаар хэлэхдээ "Татагата түвшинээс хоёр дахин өндөр Буддад хоёр хас тэмдэг байдаг" гэсэн. Энд хэлсэн "Татагата-гаас хоёр дахин өндөр" гэсэн нь түүний гон баганы өндрийг хэлж байна уу?

Багш: Энд түүний шиньшин (зан чанар) түүний Вэй Дэ (Буян) -г хэлж байна, харин гон бол зөвхөн нэг хэлбэрийн илрэл. Энд гон баганыг гэж ойлгож болно, гэхдээ гэгээрлийн хутагт хүрсний дараахь гон багана гэдэг нь зайлшгүй. Өөрөөр хэлбэл гэгээрлийн хутагт хүрсний дараа гон багана нь Татагата-гийн гон баганаас хоёр дахин өндөр гэсэн үг. Бясалгалын явц дахь гон багана тооцогдохгүй, яагаад гэвэл тэр үед энэ нь тодорхойгүй, чиний бусад хэсгүүд бясалгаж дуусаагүй, энэ бол зөвхөн энерги орших нэг хэлбэр. Гэхдээ энэ нь тодорхой хэмжээгээр бясалгалын явц дахь чиний түвшин болон шиньшин-ийг харуулдаг.

Асуулт: Сингапурт болсон Фа конференцийн үед сурагчид алга ташихад Багш хариуд нь гол төлөв хоёр алгаа хавсран хөши хийж байсан. Гэхдээ урьд Фа заахдаа та гол төлөв ганц гараар хөши хийдэг байсан. Үүний нарийн учир юунд вэ?

Багш: Би сурагчиддаа ганц гарын хөши хийдэг. Гэхдээ би бүх хүний ариун сэтгэл, тэдний уйгагүй, зогсолтгүй дээшилж байгааг хараад үнэхээр баярлах үед хоёр гараар хөши хийх дуртай. Ердийн үед Багш нь сурагчиддаа ганц гараар хөши хийдэг.

Асуулт: Жуан Фалунь-ийг цээжилбэл Гэгээрлийн хутагт хүрсэн хүрээгүй ялгалгүй Дафа-г Эзэн сүнсэндээ (Жу Юаншэнь-д) үүрд хадгалж явах болно гэж ойлгосон.

Багш: Хэн Фа-г зүгээр цээжлээд гэгээрлийн хутагт хүрэхгүй байхыг бодох юм? Чи номоо яагаад цээжилж байгаа вэ? Гэгээрлийн хутагт хүрэхийн тулд биш гэж үү? Жуан Фалунь номыг цээжлэх нь чамайг дээшилхэд тусална, чиний бичил талын биес болон хамгийн гадаргуй талын давхаргын хүний бие хоёул хамт цээжилж байгаа. Гэхдээ чи яаж ч цээжилсэн гэсэн, маш сайн цээжилсэн хүн ч гэсэн мөн адил тодорхой хугацаанд цээжээр уншиж чадахгүй болно. Яагаад вэ? Чиний биеийн тэр хэсэг, цээжилсэн тал шаардлагын хэмжээнд хүрсний дараа чамаас тусгаарлагдана. Тэгэхэд чи гэнэт "Өө, би яагаад цээжээр уншиж чадахаа больчихвоо?" гэж бодно. Яагаад гэвэл тэр хэсэг тусгаарлагдсан, хүний гадаргуйн тал цээжээр бүгдийг уншиж чадахаа больсон, мартсан. Зарим хүн ихэнх хэсгийг мартдаг, зарим нь арай гайгүй, ийм байдал үнэхээр гардаг.

Та нарын олонхи нь ийм байдлыг мэдэрсэн байх, заримдаа сайн сонсдог эсвэл тэнгэрийн мэлмий чинь сайн хардаг. Хүн хэзээ сайн сонсож чаддаг вэ? Хэзээ хамгийн тод сайн харж чаддаг вэ? Хамгийн сайн бясалгаж байх үед, тусгаарлалт болоогүй байхад, шаардлагад нийцэх гэж байх үед сайн хардаг. Тэр сайн харж, тод сонсч байх үед бие нь мэдрэмтгий. Тусгаарлалт болох үед тэр байдал нь үгүй болсныг мэдэрдэг, тэгээд "Би доош уначихав уу?" гэж боддог. Яагаад бүгд тийм сайн биш болсон бэ? Чи доош унасных биш, чиний бясалгаж дууссан хэсэг тусгаарлагдаж байгаа юм. Үлдсэн хэсэг нь бясалгаж дуусаагүй тал, үргэлжлэн бясалгах хэрэгтэй. Тиймээс чи үе үе мэдрэмтгий болно, тийм л учиртай. Энэ байдал бол зөвхөн Дафа-гаар бясалгахад л гардаг.

Асуулт: Дээд түвшинд бясалгах тусам бага унтдаг болдог гэсэн үнэн үү?

Багш: Энэ нь тийм гэсэн үг биш. Ийм байдал чиний бодлын хэсгүүд өөрчлөгдөн дээшлэхтэй холбоотой, үе үеэр гардаг. Үүнд миний дөнгөж сая ярьсан зүйл холбоотой. Чиний төгс болсон хэсэг тусгаарлагдахад чиний гаднах байдал үйлдэл төгс бясалгалд хүртлээ хэвийн энгийн байдаг. Энэ бүгд чамд жирийн хүнтэй адил амьдрах боломж олгодог. Гэхдээ хүний тал улам багасна, үүний зэрэгцээ чи өөртөө өндөр шаардлага тавина, энгийн хүмүүсийн дунд чиний биеэ авч явах байдал магадгүй улам сайн болно, ийм байдаг

Асуулт: Цаг хугацаа хүлээхгүй, хөлөө давхар завилж сууж ердөө чадахгүй юм, явал дээр вэ?

Багш: Битгий яар, цаг хугацаа хүрэлцэхгүй гэж хэлээгүй. Би хэзээ ч цаг хугацаа хүрэлцэхгүй гэж хэлж байгаагүй. Хурдан дээшил гэж хэлдэг, чи зүгээр л бясалга. Гэхдээ чи өөртөө хатуу шаардлагатай байх ёстой гэдгээ л мэдэж байх хэрэгтэй, тийм л юм. Хөлөө огт завилж чаддаггүй хүн их ховор тохиолддог. Зарим Эзэн сүнс тэнгэрт хүний төрхгүй харин өөр бурхадын төрхтэй байдаг, тэд хөлөө завилдаггүй, тийм хүчин зүйл байж болно. Гэхдээ бид хэлдэг: чамд одоо хүний бие махбодь байгаа болохоор минийхээр бол та нар онцгой тохиолдлоос бусад үед хүн бүр хөлөө давхар завилж чадна. Наргиа болгож хэлэхэд: Манай энд ирэгсдээс олон хүн үнэхээр сайн бясалгаж байна, гэхдээ зарим нэг нь хөлөө давхар завилж чаддаггүй. Тэнгэрийн Бодьсадва нар тэднийг хараад амаа даран инээлдэнэ: "Энэ бясалгагчийг хардаа, хөлөө завилж чадахгүй байна".

Асуулт: Багшаа зууралдсан сэтгэл гэсэн ойлголтын талаар тайлбарлаж өгнө үү.

Багш: Хүн ямар шалтгаанаас болоод орчлон ертөнцийн үнэнийг харж чаддаггүй вэ? Яагаад энэ орон зайг төөрөлдлийн орон зай гэдэг вэ? Та нарт хэлье: Чи жирийн хүн болохоор хүний орчлонд чиний харж байгаа зүйлс, чамд баригдаж байгаа зүйлс, мөн энгийн хүмүүсийн дунд олж авсан мэдлэг энэ бүхэн чамайг хязгаарлаж байдаг, чамайг саатуулж байдаг. Чиний энэ орон зайн харьцангуй мэдлэг улам хуримтлагдахад, энэ орон зайн танин мэдэхүй чинь улам тод болж бүгд зүйлс ойлгомжтой мэт санагдах тусам өөрийгээ улам хязгаарлана. Чиний энгийн хүний бодит орон зайд мэдэрч байгаа зүйлс үнэн хэрэгтээ алдаатай, эсрэг байх нь тун болзошгүй. Тиймээс чи энгийн хүний нийгэмд танин мэдсэн зүйлээсээ салж чадахгүй бол орчлон ертөнцийн үнэн байдлыг харж чадахгүй. Зууралдсан сэтгэл гэж тухайлбал, бид хүмүүс оршин тогтнохын тулд, өөрсдийгээ хамгаалахын тулд салж чаддаггүй зүйлс, өөртөө их ашиг олж авахын төлөө салж чаддаггүй зүйлс гэж би хэлнэ. Эдгээр зууралдсан сэтгэл нь хүчирхэг түгжээтэй адил чамайг хаадаг. Чи урагшлах замдаа түгжээ бүрийг онгойлгох ёстой, хэрэв онгойлгож чадахгүй бол тэр чамайг түгжинэ, чамайг төөрөлдөлд барина, үүнээс болж чи үнэн байдлыг харж чадахгүй. Амьний эх үүсвэр, үнэнд буцах замд энэ түгжээнүүдийг онгойлгож чадахгүй бол цаана нь алхаж гарч чадахгүй, эдгээр нь саад хүлээс болно. Чиний зууралдсан бүх зүйлс тушаа болно. Бясалгах явцад тулгарах эдгээр саад бэрхшээлийг өөрийн гай зовлон гэдэг. Би эдгээрийг чамд үнэн байдлыг харуулахын тулд, чиний бодол санааг дээшлүүлэхийн тулд, чиний зууралдсан сэтгэлийн түгжээг онгойлгохын тулд ашигладаг.

Асуулт: Бид зууралдсан сэтгэлээсээ бүрэн салах гэдгийг юу гэж ойлговол зүйтэй вэ?

Багш: Энэ нь энгийн хүмүүсийн дунд салж чаддаггүй бүх зууралдсан сэтгэл, хүслээсээ сална гэсэн үг, та нарын өнөөгийн бясалгалын арга өмнөх үеийн бүх бясалгалын аргуудаас ялгаатай. Би маш олон хүн ирж суралцана гэдгийг мэднэ, тэгэхэд нийгмийн нэг хэлбэр үүснэ, ирээдүйд тийм хүмүүс улам их болно. Олон бясалгагчдаас нийгэмд их нөлөө үзүүлнэ, нийгмийн нэг шинэ хэлбэр үүснэ. Хэрэв хүн болгон бясалгаад чадвар нь илэрч, хүн болгон ер бусын зүйл хийвэл бүхэл нийгмийн нүүр царай өөрчлөгдөнө. Тэгвэл хүний нийгэм Бурхныхтай адил болно. Тийм болж чадахгүй, хүний нийгэм бол ийм л байдаг, бид энэ боломжийг ашиглан бясалгаж байгаа. Бид энэ орчныг эвдэхгүй төдийгүй бас бясалгах явцдаа энэ орчинд зохицох ёстой, эс бөгөөс чи бясалгаж чадахгүй. Өнөөдөр бид ийм хэлбэрийг хэрэглэж байгаа. Одоо 100 сая гаруй хүн Дафа-гаар бясалгаж байна. Хэрэв бүгд лам хуврагууд болбол, Христийн сүсэгтнүүд, Буддын ламууд болбол, тийм байж огт таарахгүй. Хэрэв ирээдүйд бүр олон хүн бясалгавал энэ нийгэм юу болох вэ? Хэн чамайг тэжээх юм? Тиймээс бүгд бясалгаж болохгүй. Тиймээс бид боломжийн хэрээр хүний нийгэмд зохицох хэрэгтэй. Бид бясалгахдаа энгийн хүний нийгмийн байдлыг ашигладаг, түүнд зохицох ёстой.

Хүн бүр ажилтай байх ёстой, амьдрах орчин, тэрч байтугай гэр бүлтэй байна, мөн энгийн хүний нийгэмд олон төрөл садантай байна, энэ бүх нөхцөл байдал нь нэг ёсондоо бидний энгийн хүмүүсийн нийгэмд зохицох хэлбэр юм. Энэ нь нөгөө талаар бясалгах таатай нөхцөл, бясалгалын орчинг бүрдүүлнэ, яагаад гэвэл бид энгийн хүмүүсийн дунд бясалгаж байгаа. Бид энгийн хүний нийгэмд бясалгаж байгаа болохоор, материаллаг орчинтой харьцаж байгаа учраас материаллаг зүйлс, өмч хөрөнгөтэй байна, энгийн хүний нийгэмд боломжийн дээдээр зохицоно. Гэхдээ нэг зүйл хэлэхэд, чи энгийн хүнээс ялгаатай. Чи бясалгаж байгаа болохоор чиний сэтгэл эдгээр зүйлсд зууралдахгүй. Чи их мөнгөтэй байж болно, гэр бүлтэй байж болно, баялаг эзэмшдэг, бусад олон зүйлстэй байж болно. Гэхдээ эдгээрт зууралдсан сэтгэлгүй байх ёстой. Энэ бол чиний бясалгалын хэлбэр.

Зууралдсан сэтгэлээ бүрэн орхино гэдэг нь материаллаг зүйлээсээ заавал татгалзана гэсэн үг биш. Нөгөө талаар чи материаллаг зүйлээсээ бүрэн салсан ч сэтгэлдээ үүнийг орхиж чадахгүй байвал, салж чадахгүй үргэлж бодоод байвал бясалгалдаа саад учруулна. Тэгвэл минийхээр бол үүнээсээ бүрэн салсан гэхгүй, хүчээр татгалзсан болно. Материаллаг зүйлсийг өнгөн дээрээ хөнгөн авч үзэж байгаа нь зөвхөн дүр үзүүлж байгаа хэрэг. Миний харж байгаагаар хүн бясалгалын замаар жинхэнэ дээшлэх шалтгаан нь бол хүний сэтгэл зүрх өөрчлөгдөх явдал юм. Хүний сэтгэл зүрх, бодлын төвшин шаардлагын хэмжээнд хүрэхэд тэр хүн бясалгалаар жинхэнэ дээшилдэг. Бид материаллаг зүйлийг их хөнгөн авч үзнэ. Чамд тэдгээр нь байсан, байгаагүй ялгаагүй. Гол нь чи зууралдсан сэтгэлээ орхиж чадах эсэх, дээшилж чадах, чадахгүй нь хамгийн чухал. Мөн бидний бясалгалын бүхий л явц энгийн хүмүүсийн дунд байхаар зохицуулагдсан, энэ нь чамд гонгоо бууруулахгүйгээр шургуу тууштай бясалгах боломж олгож байна. Энэ бүх талын төлөвлөлт нь өнөөдрийн бидний бясалгалын хэлбэрт зохицож байгаа. Хэдэн жилийн өмнө намайг Фа зааж эхлэхэд Бурхад үүнийг "Дээд буяны Фа" гэж хэлж байсан. Тэд бүгд үүнийг үнэхээр сайн гэж үзсэн.

Асуулт: Дафа-г дэлгэрүүлэх арга нь Европчуудад тохирч байна уу?

Багш: Чи бясалгагч хүний хувьд Дафа-г олж авсны дараа яаж өргөн дэлгэрүүлэх, олон

хүнд хүргэх гэдэг нь их сайн хүсэл. Чамайг Европт ч бай Азид ч бай Фа тараахад хувь тавилангүй хүн ирж сурахад тун хэцүү. Хувь заяаны төөрөгтэй хүн гэж хэн бэ? Хувь заяаны төөрөгт хүний талаар би дээр ярьсан. Тэгвэл тийм хүмүүсийг яаж олох вэ? Сонинд зар тавьж хувь тавилангийн төөрөгтэй хүнийг олно гэвэл бүтэхгүй. Гэхдээ манай сурагч болгонд нэг зүйл тодорхой байх ёстой, магадгүй манай сурагчид сэтгэлдээ мэдэж байгаа: Чамайг "Фалунь Гон" эсвэл "Жуан Фалунь" гэж хэлэхэд зарим хүний сэтгэлд шууд хүрнэ, эсвэл ямар нэгэн догдлол төрнө, суралцахыг хүснэ. Ийм хүн бол хувь тавилангийн ерөөлтэй байх их магадлалтай. Зарим хүн байдаг, чамайг юу ч гэж ярьсан ямарч мэдрэмжгүй. Тийм хүн бол хувь тавилангийн ерөөлгүй байх магадлал өндөр.

Дэлгэрүүлэх асуудлын тал дээр хамгийн сайн арга бол олон нийтийн газар манай сурагчид хамтдаа дасгал хийх явдал юм. Яагаад гэвэл тийм хувь тавилантай хүмүүс биднийг амархан олно, мөн манай Дафа-гийн номнууд олон орны янз бүрийн үндэстний номын дэлгүүрт байх хэрэгтэй. Надад тоолшгүй олон Номын бие байгаа, тэд нэг хараад л хэн хувь тавилангийн ерөөлтэй гэдгийг, хэн Фа олж авах ёстойг мэднэ. Номын дэлгүүрүүдэд манай ном байвал, манай сурагчид паркуудад хичээллэж байвал, Номын биес тэднийг олж энэ Фа-гийн эрэлд хөтлөнө. Хэрэв ийм орчин байхгүй бол тодорхой хүндрэл учирна. Ямарч гэсэн тэр хүн ном олж уншаад их сайн ном юм байна гэж ойлгоно. Түүнд хувь тавилангийн ерөөл байгаа учраас номыг сайн гэж мэдэрнэ, тэгээд дасгалын газрыг хайх болно. Паркт сурагчид дасгал хийдэг, тэднийг тэгж олно. Намайг энэ Дафа зааж эхэлсэн үеэс одоог хүртэл олонхи хүн ийм замаар Фа-г олсон. Үүнээс гадна олон хүн манай сурагчдаас сонсож мэдсэн. Тэд үүнийг их сайн гэж ойлгон гэр бүлийнхэндээ ирж сур гэсэн. Хэрэв тэд үүнийг үнэхээр сайн гэж үзээгүй бол гэр бүлийнхнийгээ ир гэж хуурахгүй. Тэд сайн гэдгийг мэдсэн учраас гэр бүлийнхнийгээ ирж суралц гэж хэлсэн. Дараа нь тэдний гэр бүлийнхэн үүнийг үнэхээр сайн болохыг мэдээд найз нөхөд, төрөл садандаа ирж сур гэнэ. Сурагчид өөрсдийн мэдрэмж, туршлагаасаа хуваалцахад хүмүүст хүчтэй нөлөөлдөг. Тэд гэр бүлийнхэндээ худлаа хэлэхгүй, найз нөхөддөө ч худлаа ярихгүй. Тиймээс найз нөхөд нь итгэнэ. Тэд итгэвэл ирж бас суралцана, тэд өөрсдийн дадлага туршлага олж авна. Дафа ингэж л тархдаг.

Гэхдээ бас цөөн тооны хүмүүс сурагчдын сонин, сэтгүүлд тавьсан өгүүллийг уншаад Фа олж авна. Би өчигдөр ийм замаар Фа олж авахад болно, татгалзахгүй гэсэн. Гэхдээ энэ байдалд ямар асуудал гарч болзошгүй вэ? Ингэхэд зөвхөн хамгийн сайн талын хүн ирэх биш бас муу талын хүн ч ирнэ. Тиймээс ирсэн хүмүүс өөр өөр зорилго, олон янзын бодолтой байдаг, зарим нь хэсэг хичээллэж байгаад яваад өгдөг. Тэд магадгүй гэгээлэг бус хүмүүс, Дафа олж авахыг хүсэхгүй, эсвэл тэдэнд Дафа олж авахыг зөвшөөрөхгүй. Үргэлж ийм байдаг. Сурагчид сонинд өөрсдөө өгүүлэл нийтэлж, мэдээлэл тавьж байвал бас сайн хэрэг, би үүнд татгалзахгүй, яагаад гэвэл хувь тавилантай хүмүүс ямарч байсан ирнэ, ухаалаг хүн сонин уншаад бас ирнэ, ийм учраас энэ хэлбэр бас болно. Гэхдээ гол чиглэл бол зөвхөн хоёр хэлбэр юм. Нэгд: номын дэлгүүрүүдэд ном тавих, мөн манай дасгалын газрууд байдаг учраас Номын бие тийм хүнийг тэнд аваачина. Хоёрт: Фа конференц болон сурагчид гэр бүлийнхэндээ өөрийн туршлага, сэтгэгдлээ хуваалцах. Энэ хоёр замаар хүмүүс гол төлөв ирж суралцдаг, тийм хүмүүс олонхи нь байдаг, бас тэд сайн зан чанартай хүмүүс юм. Тэгвэл бусад хэлбэрийн хувьд Баруунд ч байна уу, Дорно ч байна уу байж болно. Гэхдээ гол төлөв энэ хоёр хэлбэрийг барина. Эхний үед олон газрын хүмүүс Фалунь Дафа гэж юу болох талаар ойлголт байхгүй байсан, тийм учраас хүмүүсийг энэ

дасгалтай танилцуулахын тулд сонин сэтгүүлд өгүүлэл бичнэ, мэдээж энэ ч гэсэн бас Дафа-г дэлгэрүүлнэ, үүнд эргэлзээ байхгүй.

Асуулт: Би Европ сурагч, танд сорилт ирэхэд хүлээж авдаг уу эсвэл зүгээр өнгөрөөдөг үү?

Багш: "Танд сорилт..." гэдэг нь намайг хэлж байна уу? Тийм үү? Энэ их сайн асуулт байна, би та бүхэнд тайлбарлаж өгөхийг хүсч байна. Үүнийг тайлбарлах цаг болсон гэж үзэж байна.

Би та нарт хэлье, өнөөдөр хичнээн хүн Дафа-гаар хичээллэж байна, надад хичнээн сурагч байна, хичнээн шавь байна ялгалгүй цөм бясалгагчид. Хэн ч үлдэхгүй, та бүгд бясалгаж байна. Чи сайн бясалгаж байна уу, муу бясалгаж байна уу, идэвхтэй байна уу идэвхгүй байна уу, түвшин чинь өндөр байна уу нам байна уу та бүгд өөрсдийгээ бясалгагч гэж үзэн өөртөө хатуу шаардлагатай байх хэрэгтэй. Харин би бол энд бясалгахаар ирээгүй, та бүгд энэ ялгааг сайн ойлгох хэрэгтэй. Надад миний өөрийн гай зовлон гэж байхгүй, надад та нарт байдаг шиг бясалгах хүчин зүйлс ч байхгүй. Нэг зүйлийг хэлэхэд, би та нарыг сурагчдаа гэж үзэж байгаа, та нарт аврал үзүүлж байна гэсэн үг. Та нарыг аварч хувиргаж байгаа. Үүнээс харахад бид хоорондоо адилгүй. Та нарт тохиолдож байгаа бүх саад бэрхшээлийг бясалгал гэж үзэх хэрэгтэй, тэдгээр нь үнэхээр бясалгал. Гэхдээ надад учирдаг саад бэрхшээл бол Дафа-д учруулж байгаа саад бэрхшээл, үймүүлэл. Яагаад ингэж үзэх ёстой вэ? Энэ сансар ертөнц эхнээсээ оршсоор ирсэн. Миний хийж байгаа зүйлийн зорилго бол- Фа цэвэрлэгээ юм. Сансар ертөнцийн бүх амь энэ Фа-гаас гажуудсан, тийм учраас Фа ариусгал хийх зайлшгүй шаардлагатай. Би та нарт үргэлж хэлдэг, энэ бол хэдэн мянган жилд ч тохиох зүйл биш. Бүх сансар ертөнцийн Агуу номыг хүний орчлонд заахыг урьд Бурхдууд ч хүртэл мэдэж байгаагүй, хүний орчлон үүссэн цагаас хойш хэзээ ч болж байгаагүй.

Төгсгөлгүй урт хугацааны туршид амь бодиуд улам ариун бус болсон, бүх зүйлс гажуудаж доройтсон. Хэрэв ийм байдал удаан үргэлжилбэл хамгийн эх суурь Жэнь, Шань, Рэн хүртэл гажуудна. Тэр бол маш аймшигтай. Би Сансар ертөнцийн амь бодийг нандигнан үздэг, тиймээс анхны амь бодиудыг устгагдахаас өмнө боломжийн хэрээр аль болох олныг аврахыг хүссэн. Тийм бодол надад анх төрж би энд ирсэн. (Алга ташив) Нэгэнт би энд ирсэн болохоор би өөртэйгээ хамт хамгийн анхдагч зүйлсийг авчирсан, хамгийн гайхамшигтай зүйлс-бүх цагийн хамгийн төгс төгөлдөр зүйлс. Та нар Фалунь эргэдгийг мэднэ, та нарын харж байгаа Фалунь бол зөвхөн үүний өнгөн хэлбэр. Үүнд бас Фа тал бий, та нар харж чадахгүй. Энэ нь зогсолтгүй эргэдэг, автоматаар засдаг механизм, бүх зүйлийг хамгийн анхны дээд зэргийн байдалд буцааж оруулдаг. Микро түвшингээс гадаргүй хүртэл бүх матери, амь бодиуд үүнтэй адил эргэж хөдөлгөөнд оршдог. Би энэ бүгдийг бүтээж сэргээсэн. Түүнээс гадна энэ нь бүгдийг байнга сайжруулж төгөлдөржүүлж байдаг. Миний хувьд бясалгах асуудал байхгүй. Би энэ үйл хэргийг орчлон ертөнцийн амь бодиуд ариун бус болсноос үүссэн харгис хүчний үзүүлж байгаа саад бэрхшээлийг арилгахын тулд хийж байгаа. Мөн үүний хажуугаар хүний орчлон дахь бүх амь бодийн үүсгэсэн нүглээс бий болсон саад бэрхшээл бас их байгаа. Би та нарт Есүс-ийг яагаад цовдлуулсан, Шагжамүни яагаад нирваны замаар явах болсон, яагаад Лаози 5000 үг үлдээгээд яаран явсан учрыг мэднэ гэж хэлдэг. Жишээ нь: Орчлонд төрсөн хүн нэг амьдралаас нөгөөд дахин төрдөг. Чи хичнээн олон амьдрал туулснаа мэдэхгүй.

Гэхдээ амьдрал болгондоо чи бусдад өртэй болсон, олон муу зүйл хийсэн. Зарим нь янз бүрийн түвшнээс доош унаж ирж Дэлхий дээр төрсөн. Тэд янз бүрийн дээд орон зайд байхдаа тэнд алдаа хийж шат шатаар доош унасан. Тэд яагаад тэр дээд орон зайдаа үлдэж чадаагүй вэ? Яагаад гэвэл тэнд дахин муу зүйл хийж дахиад доош унасан, дахиад муу зүйл хийж бүр доош унасан. Тэд Тэнгэрт үйлдсэн муу хэргийнхээ төлөө Бурхдад өртэй болдог.

Хүн тэнгэрт буцаж гэвэл, Бурхад зөвшөөрөхгүй! Багшаар заалгахгүйгээр, Багшийн халамжгүйгээр чи ямарч чадвартай байсан хэзээ ч буцаж чадахгүй. Дэлхийд ирсэн бол хүнийг жинхэнэ аварч чадах Багшийн халамжгүйгээр хэзээ ч буцаж чадахгүй. Чи хүмүүсийн дунд нүглээ арилгаж үнэхээр чадсан ч Тэнгэрт тавьсан өрөө төлж чадахгүй. Есүс хүмүүсийг аврахыг хүссэн, аугаа нигүүлсэл үзүүлсэн, тиймээс энэ бүгдийг тоогоогүй. Хүмүүсийн биед байгаа нүглийн хүлээсийг тайлах хэрэгтэй болсон, гэвч энэ орчлон ертөнцөд "Алдахгүй бол олохгүй, олбол заавал алдах ёстой" гэсэн зарчим байдаг, өр тавьсан бол төлөх ёстой. Энэ бол хөдөлшгүй мөнхийн хууль. Хэрэв чи хүнийг нүглээс нь чөлөөлбөл түүний өрийг хэн төлөх юм? Тиймээс тэр тооцоо, бүх өр Есүс дээр буусан. Чи тэдний хүлээсийг тайлсан бол оронд нь төлөөсийг төлөх болно. Аврагдсан хүмүүст бүх тайлагдашгүй зангилаа, бүх өр, бүх зүйлсээ төлөх ямарч арга байгаагүй. Есүс дэлхий дээр байгаа болохоор бүх тэдгээр өр түүний биед холбогдсон. Янз бүрийн давхаргын нүглийн өр байсан, зөвхөн хүний орчлон дахь нүглийн өр байгаагүй. Эцэст нь тэр өр ямар хэмжээнд хүрсэн бэ? Тэр улам олон хүнийг аврах тусам түүний биенд улам их нүглийн өрийн зангилаа нэмэгдсэн. Түүнд үүнээс өөрийгээ чөлөөлөх ямарч арга зам байгаагүй, тийм зүйл хийх хүч ч байгаагүй. Тэр зангилаа тайлагдаагүй. Эцэст нь Есүс тэр хүмүүсийг аварсан, гэхдээ өөрийн биеэ чөлөөлж чадаагүй. Тиймээс Есүст тэдний нүглийн өрийг өөрийн биеэр төлөхөөс өөр арга байгаагүй. Их олон хүмүүсийн карма, бүх үзэн ядалт Есүс дээр буусан. "Би бүх итгэгчдийнхээ нүглийн өрийг төлье". Тэгээд тэр цовдлогдож хүнд тарчлаан зовоолтонд үхсэн. Бүх өр түүний биетэй холбоотой байсан. Махан бие нь үхэхэд бүгд тайлагдсан. Энэ махан бие бодь нь салахад Есүс чөлөөлөгдсөн. Тийм учраас Есүс цовдлогдсон, тэгээд хүмүүс Есүс хүмүүсийн төлөө өөрийгээ зориулсан гэж ярьдаг. Ийм л учиртай.

Чи олон хүн энэ Фа олж авахаар ирснийг харж байна. Ирээдүйд бүр олон хүн болно. Та нарт бясалгахад хэрэгцээтэй бүх зүйлсийг Багш хийж өгдөг гэдгийг мэдэх хэрэгтэй. Гэхдээ би тэднээс өөр, Есүс, Шагжамүни гэх мэт бүгд бага хүрээнд гэгээрэгчид. Би Сансар ертөнц дотор биш, тиймээс Сансрын биесийн янз бүрийн түвшингийн, янз бүрийн орон зайд орших төрөл бүрийн амь бодийн асуудлыг шийдвэрлэж чадна. Хүн аврах бол миний жинхэнэ зорилго биш гэж хэлсэн, гэхдээ тэд миний аврахыг хүссэн амь бодийн доторхи нэг давхаргын амь бодь. Үнэндээ надад өөрийн гэсэн гай зовлон байхгүй, би бясалгаж байгаа биш. Надтай тулгарч байгаа асуудлууд энгийн хүмүүсийн талд ховор илэрдэг, гэхдээ энэ тал дээр илэрдэг асуудал бас бий, тэдгээрийн ихэнхийг та нар мэдэхгүй. Би тэдгээр асуудлаас чөлөөлөгдөж чадна, яагаад гэвэл би үүн дотор оршдоггүй. Надад тэд нар шиг чөлөөлөгдөж чадахгүй байх асуудал байхгүй. Би чөлөөлөгдөж чадна, гэхдээ бэрхшээлийн хэмжээ энгийн ямарч амь бодийн хувьд, та нарын хувьд төсөөлөхийн аргагүй их. Би өөрийнхээ бүх зүйлсээс дээд хэмжээгээр татгалзаж болно, тийм учраас энэ бүгдийг тайлж чадна. (Алга ташив)

Би сая энэ асуудалд хариулангаа та нарын анхаарлыг бас өөр нэг зүйлд хандуулахыг

хүссэн, намайг үргэлж дагалдан явдаг сурагчид, бас ажлын үүрэгтэй яваа хүмүүс байдаг, зааварчилгаа өгөх төвийн болон бусад хариуцлага бүхий хүмүүс байдаг. Та нар нэг зүйлийг ойлгох хэрэгтэй, та нарт тохиолдож байгаа бүх зүйлс бол та нарын сорилт, та нар Багшийг төлөөлж чадахгүй. Аливаа зүйлд би оролцож байгаа болохоор миний байр суурьнаас авч үзэх хэрэгтэй. Та нар урьд энэ асуултанд анхаараагүй. Надад учруулж байгаа саад бэрхшээл бол Дафа-г сүйтгэж байгаа хэрэг. Иймээс энэ нь та нарт тулгардаг сорилтноос огт өөр. Багш бясалгадаггүй гэдэг нь эргэлзээгүй, тэгэхээр Багш сорилтонд ордоггүй. Үнэндээ энэ бол Фа болон орчлон Ертөнцийг эвдэж байгаатай адил юм. Тиймээс ийм асуудлыг адилтгаж болохгүй. Үүнийг сайн ойлгох хэрэгтэй. Би саад бэрхшээлийг шийдвэрлэхдээ үүнийг бодит чөтгөр гэж үздэг, харин та нар тэгж болохгүй! Та нарт тохиолддог бүх зүйлс та нарын бясалгалтай холбоотой. Тиймээс та нар үүнийг үргэлж бясалгал гэж авч үзэн дотроосоо шалтгааныг олох хэрэгтэй. Эдгээр нь бол огт өөр зүйлс.

Асуулт: Европын сурагчдад амгаланд ороход их хэцүү байдаг шиг санагддаг. Яагаад вэ?

Багш: Үнэндээ Азийнхны хувьд, Европынхны хувьд адилхан. Энгийн хүний нийгэмд бясалгаж байгаа хүн гүн амгаланд орж чадаж байвал түвшин нь нилээд өндөр юм. Энгийн хүний нийгэмд ажил хийж байгаа болохоор энгийн хүний олон талын асуудалтай харьцана. Чи тэнд суугаад эдгээр асуудлын талаар бодохгүй байя гэсэн ч бодолд чинь орж ирнэ, чи автоматаар тэр зүйлийн талаар бодох болно, тиймээс амгаланд орж чадахгүй. Бясалгах явцдаа бид тасралтгүй дээшилнэ, зууралдсан сэтгэлээсээ байнга салж байх болно. Чиний зууралдсан сэтгэл багасах тусам чи илүү тайван болж ирэхийг мэдэрнэ, улам бүр тайвширна. Энэ бол түвшнийг илтгэнэ. Чи эхнээсээ гүн амгаланд орно гэвэл үнэний хувь байхгүй. Үүнд туйлын онцгой тохиолдлоос бусад үед ямарч аргаар хүрч чадахгүй. Энэ нь түүний хүн тал маш сул, нөгөө тал нь их хүчтэй бол тэр хүн хагас гэгээрсэн байдалд орно. Тийм хүн бол маш онцгой, тодорхой хэмжээний гүн амгаланд хүрч чадна, түүний бурханлаг тал нь нөлөө гаргана. Үүнээс бусад тохиолдолд эхнээсээ шууд гүн амгаланд орж чадахгүй. Өөр арсытан үндэстний хувьд ялгаагүй, Европ, Азийнхны хувьд ялгаагүй.

Амгаланд орж чадахгүй байвал битгий санаа зов. Дасгал хийхэд чиний бие таатай тайван байвал олон талын бодлоо хязгаарлах гэж хичээ. Хэрэв толгойд эргэлдсэн олон бодлоо зогсоож чадахгүй бол зүгээр орхи, чи тэр бодлыг хүнийх гэж бод. "Чи бодож л бай, би чиний юу гэж бодохыг харья" гэж хэл. Энэ бол нэг хэлбэрийн арга. Үүний ашиг нь чиний өөрийн бодол биш гэдгийг ялгаж сурна. Энэ бол бас их ач холбогдолтой. Эсвэл чи хоригло, бодуулахгүй бай, тэгвэл бясалгагчийн хийдэг чадварт хүрнэ. Бие тайван байхад дараа нь хувьсал өөрчлөлтийн таатай нөхцөл бүрддэг. Хэрэв тэгж чадахгүй бол яах вэ? Та нар мэднэ, манай бясалгал хамгийн микро түвшнээс эхэлдэг, бидний микро тал амгалан. Тэр талаас эхлэн амгалан болох тусам бясалгал улам сайжирна, гадаргуй дээрхи зүйлс хязгаарлагдаж сул болж ирнэ. Гадаргуй тал, муу талын хүч суларна. Ийм уялдаатай. Та нарын зарим нь удаан бясалгаж байгаа, гэхдээ бас л муу бодлоосоо салаагүйгээ мэдэрдэг. Чи чадвал тэр бодлоо дарж болно. Хэдийгээр улам муу болж ихээр илэрч байгаа мэт санагдсан ч тэр нь үндэсгүй болсон, улам суларч байгаа.

Асуулт: Барууны сурагчид бид юуг зөв гэх вэ? Бид яаж амьдралаа авч явах нь зүйтэй вэ? Юмыг аясаар нь байлгасан нь дээр үү?

Багш: Би өөрийн бодлоо хэлье. Би өөр өөр нөхцөл байдлын үед юманд аясаар нь ханд гэж хэлж байсан. Гэхдээ би бүх зүйлийн хувьд аясаар нь бай гэж хэлээгүй. Чи ямар нэгэн компанид ажиллахад дарга чинь цалин өгнө. Хэрэв чи ажлаа хийхдээ хайхрамжгүй, ажилдаа идэвхи зүтгэл гаргахгүй тааваар аясаараа хийвэл цалин авах эрхгүй. Чи хаана ч байсан сайн хүн байх хэрэгтэй. Чамд хэлье, "Юманд аясаар нь ханд" гэдгийг хаана хэрэглэж байгаагаас шалтгаалж ярих хэрэгтэй. Бид бясалгалд бүх зүйлд жам ёсоор ханд гэдэг, гэхдээ бид муу талаа санаатайгаар дарж байх хэрэгтэй, мөн хичээнгүй бясалгах хэрэгтэй, үүнийг бас "Жам ёсоор нь хандах" гэхгүй. Үнэндээ та бүгд бас ингэж бясалгаж байна. Тэгвэл бид бясалгалын явцад өөрийгээ яаж бясалгахыг тов тодорхой ойлгосон, бид өдөр тутмын амьдралдаа хүний нийгэмд боломжийн дээд хэмжээгээр зохицоно, тиймээс энгийн хүний ажлаас өөрийнхээ бясалгалыг ялгаж салгаж байх хэрэгтэй. Энэ хоорондын заагийг барьж байх хэрэгтэй. Ажил бол ажлаараа, бясалгал бол бясалгалаараа байна. Гэхдээ онцлон хэлэхэд, чи бясалгаж байгаа болохоор ажилдаа өөрийгээ өндөр хэмжээнд шаардах хэрэгтэй, энэ нь нийгэмд, гэр бүлд болон хамтын янз бүрийн байдалд илэрдэг. Өөрөөр хэлбэл, чи хаана ч байсан сайн хүн байвал, хүмүүс чамайг сайн хүн гэнэ. Ийм учиртай. Жам ёсыг дагах гэдэг нь харьцангуй ойлголт, бидний ярьж байгаа бол урьдын ойлголттой адилгүй, юунд ч санаа битгий зов, лам шиг суугаад л бүх зүйлсийг аясаар нь байлга гэсэн үг биш. Тийм биш, огт тийм утгатай биш.

Хэрэв чи ямар нэгэн асуудалтай тулгарвал бясалгагч хүн юуны түрүүнд өөрийгээ хянах хэрэгтэй, юуг буруу хийв? гэж өөрөөсөө хайх хэрэгтэй гэж би хэлнэ. Бясалгагч хүн ийм байж чадахгүй бол урагш ахиж чадахгүй. Тиймээс ямарч саад бэрхшээлтэй учирсан хүн бүр юуны түрүүнд "Би юуг буруу хийв?" гэж өөрөөсөө асуух хэрэгтэй. Би орчлон ертөнцийн бүх зүйл эв зүйд байдаг гэж хэлдэг. Хэрэв чи алдаа хийвэл бусадтай зөрчилдөнө, эв зүйн холбоо эвдэрнэ. Эргэн тойрны чинь бүх зүйлс болохоо байсан мэт болно, хүмүүстэй харьцаа хурцдана. Энэ үед чи өөрийнхээ бурууг олох хэрэгтэй, алдаагаа зас, тэгвэл бүгд буцаад эв зүйдээ орохыг үзнэ. Бид бусадтай маргалдах хэрэггүй гэж би хэлнэ. Хэрэв чи жинхэнэ асуудалтай тулгарч хүмүүс чамд шударга бус хандвал, чи урьд амьдралууддаа хүмүүст өр тавьсан байх магадлал өндөр, тиймээс бясалгагч байхын тулд тэвч, тэгээд бүгд өнгөрнө. Энгийн хүнийхээр бол хоёр хүн хэрэлдээд салахад сэтгэлдээ хонзон санаад үлддэг, тэдний хоорондын зөрчил арилаагүй үлдсэн гэсэн үг. Цаг хугацаа өнгөрөх тусам зөрчил даамжирч хоорондоо дайсан болцгооно. Харин бид тэвчиж чадна, сэтгэлдээ хүндээр хүлээж авахгүй, алхам ухрана. Хятадад ийм үг байдаг: "Алхам ухар, чиний өмнө өргөн уудам тал нээгдэх болно, хэрэв чи зөрчилдөхийг хүсвэл тэндээ гацна, гарах гарцгүй болохыг үзнэ. Харин алхам ухарвал, энэ зууралдсан сэтгэлээ орхиж чадвал, юунд ч санаа зовохгүй бол өмнө чинь үнэхээр цэлгэр уудам тал нээгдэх болно, эерэг зураг байдлаар солигдоно, тийм байх нь зайлшгүй. Бясалгагч хүн ингэж хандах ёстой, хэрэв бид энгийн хүмүүс шиг маргалдвал, тэмцэлдвэл, тэдэн шиг зөрчилдвөл бид энгийн хүн хэвээр үлдсэн гэж би хэлнэ. Тийм биш гэж үү? Энэ бол яг тийм гэсэн үг.

Асуулт: Бид өөрсдийнхээ түвшнийг яаж мэдэх вэ?

Багш: Миний хувийн бодлоор эхний үед та нар өөрийнхээ түвшнийг мэдэхийг хүсч хэрэггүй. Хүн энэ аугаа Дафа-д уусах нь зууханд хайлсан ганд модны үртэс унахад хоромхон зуур гялсхийн алга болдог шиг. Хүн ийм аугаа Дафа-д уусахад түүний бие, сэтгэлийн нүгэл болон янз бүрийн зүйлс хоромхон зуур алга болно. Хэрэв бид тийм

байвал чи бясалгал хийгээгүйтэй адил, би шинээр амь бодь үүсэгсэнтэй адил болно, чиний бясалгал тооцогдохгүй. Тиймээс бид ингэж хийж болохгүй, өөрийгээ бясалгах хэрэгтэй, өөрийгээ өөрчлөх хэрэгтэй. Энэ Фа ер бусын аугаа. Бясалгалын явцад чи өөрийгээ бясалгагч гэж үзэн хичээллэж, номоо тогтмол уншиж байвал чи тасралтгүй ахина, дээшлэнэ. Энэ бүгдийг манай туслах арга-дасгалтай хамт хийвэл чи хурдан явцтай ахиж чадна. Энэ бол бясалгалын хамгийн хурдан хэлбэр.

Хэрэв би эхний үед чамд мэдэхийг зөвшөөрвөл чи тийм түвшинд өөрийгээ барьж чадахгүй. "Пөөх, би ямар мундаг юм бэ! Би бясалгалаар ийм өндөрт хүрчихсэн байна" гэнэ. Би чамд одоогийн чиний биений гаднах өөрчлөлтийг харуулбал боддоо, чамд долоон сэтгэл, зургаан хүсэл, бусад янз бүрийн зууралдсан сэтгэл арилаагүй байхад чи тайван байж чадах уу? Чамд хүний хүчтэй сэтгэл байхад би чамд энэ талаар хэт эрт мэдүүлж болохгүй. Яагаад гэвэл чиний бясалгалдаа тасралтгүй, тууштай дээшилхийг баталгаажуулахын тулд юм. Гэгээлэг хүн Дао сонсоод ухамсраараа эцсийн үр дүнд хүртэл бясалгана. Энэ бол хамгийн ер бусын бөгөөд хурдан арга. Үнэхээр хамгийн хурдан.

Манай зарим сурагчдад өөр нөхцөл байдал байдаг. Зарим хүний чадвар нь нээлттэй байдалд хичээллэдэг, зарим нь хагас нээлттэй байдалд хичээллэдэг бас харж чаддаг, зарим нь харьцангуй бүр тод сайн харж чаддаг, бүгдийг мэддэг. Энэ бол ховор тохиолдол. Ихэнх хүмүүс чадвар нь түгжээтэй бясалгадаг. Номондоо сайн төвлөрч уншиж бясалга, тэгвэл байнга дээшилнэ, тэнгэрийн нууц байнга тайлагдаж байх болно. Чамд зөвхөн Фа зарчимаар итгэл үнэмшил олоход хангалттай. Мэдээж өнөөгийн нийгмийн хүмүүс янз бүрийн төөрөгдөлд гүн автсан, энгийн хүний нийгмийн бодит байдал гэх мэт зүйлд их хүчтэй зууралдсан. Тэдэнд үүнээс салахад маш хэцүү. Тэд Фа болон хувийн сонирхол, зууралдсан сэтгэлийнхээ хооронд сонголт хийхдээ үргэлж хэцүүддэг. Зарим нь бүр Фа-гаас татгалзахыг өөрийн зууралдсан сэтгэлээ орхихоос илүүд үздэг болсон. Тийм зүйлийн талаар ярихад ч хэцүү, орчин үеийн нийгэм ийм байдалд хүрсэн, хүмүүс өөрсдийнхээ төрөлх мөн чанар, хүнд байвал зохих хэв хэмжээг мэдэхээ больсон.

Гэхдээ нийгэм улам муудах тусам бидэнд бясалгалын хамгийн сайн нөхцөл байдлыг бүрдүүлдэг. Хамгийн төвөгтэй орчин байх тусам агуу гэгээрэгчид олон төрдөг. Ийм л учиртай юм. Хэдэн жилийн өмнө Хятадад чийгон-ы олон багш гарч ирсэн. Энгийн хүмүүс тэдэнд мөргөдөг, "Аая, ямар гайхамшигтай ид шидтэй чийгон багш вэ!" Өвчнийг нь эмчилж өгдөг болохоор хүмүүс түүнд бэлэг сэлт, мөнгө хүртэл өгнө. Тэдний материаллаг зүйлд автах сэтгэл нь улам хүчтэй болсон, улмаар тэдний олонх нь доош унасан. Тэдэнд гон байхгүй болсон, юу ч үлдээгүй, эцэст нь тэд хэн ч биш болсон. Багш нар нь хүртэл тэднийг харж хандахаа больсон. Яагаад вэ? Яагаад гэвэл тэд анх хүнээс зайдуу газар аглагт, ууланд эсвэл хүмүүс мэддэггүй газар бясалгадаг байсан, эсвэл сүм хийдэд болон бусад шашны адил энгийн хүмүүсээс зайдуу газар, тэдний төвөгтэй сонирхлоос тасархай газар бясалгадаг байсан, энгийн хүний будагтай торхонд орохгүй хийдэг байсан. Тэд энгийн хүний эдрээтэй нийгэмд оронгуутаа бохирдож эхэлдэг. Эцэст нь тэд энгийн хүнээс ялгаагүй нэр, ашгийн хойноос хөөцөлддөг болсон, тэгээд энгийн хүмүүс болсон. Энгийн хүмүүсийн дунд тэдний бясалгалын арга үйлчлэхээ больсон. Харин бид энэ том будагны торхон дотор бясалгана, түүнд байдаг зүйлстэй харьцах болно. Хэрэв чи тэндээс сугаран гарч чадвал ер бусын биш гэж үү?! Бясалгалаар яагаад тийм өндөрт хүрч болох вэ? Хамгийн үндсэн шалтгаан нь бол энд маш бохир. Чи үүнээс гарч чадвал, өнөөдөр чамаас

зөвхөн бясалгахыг хүссэн бодол гарахад л чамайг ер бусын гэж хэлж болно. Яагаад гэвэл энэ зовлон дунд, энэ бохир орчин, нөхцөлд хүртэл ийм сэтгэл гарч байна.

Өнгөцхөн төдий зовлон юунд ч тооцогдохгүй, үнэхээр хамгийн зовлонтой нь зууралдсан сэтгэлээ орхих юм. Энэ нь махыг яснаас шулахтай адил. Ийм хэцүү байдал чамд дээд түвшинд бясалгах хамгийн таатай орчин болно. Өөрөөр хэлбэл ийм хамгийн муу орчин байдалд Дафа-гийн сүр хүч илэрдэг. Нийгмийн сайн нөхцөлд Дафа хэрэггүй, Татагата ном байхад л хангалттай, Есүс, Шагжамүни-гийн гэх мэт Ном. Өнөөгийн шашин яагаад уналтын, сүйрлийн үедээ орсон бэ? Аль нь ч хүнийг яагаад аварч чадахгүй болсон бэ? Хүмүүс Буддыг загнаж, Есүс-ийн зурган дээр дэвсэлж, дээр нь шээж зүрхэлдэг болсон. Ийм үед тэднийг Татагата номоор аврахыг хүсч байна уу? Энэ нь аль хэдийн боломжгүй болсон.

Асуулт: Би бясалгахыг сэтгэлийнхээ угаас хүсч байна. Дафа-д яаж эргэлзэхгүй болох вэ?

Багш: Би та нарт хэлсэн, хүн төрснийхээ дараа энгийн хүний нийгэмд янз бүрийн төсөөлөл өөрийн ухамсартаа суулгадаг, энгийн хүний нийгмийн хуурамч байдлаас "мэдлэг" олж авдаг, энэ нь улам төөрөгдөлд оруулдаг. Чиний ухамсарт үүссэн янз бүрийн төсөөлөл, бодол нь чамайг Фа олж авахад саад болох хүчин зүйлс болдог. Энгийн хүний байр суурьнаас ойлгосон төсөөлөл чинь чамайг Дафа-д итгэхэд эргэлзээ төрүүлсэн биш гэж үү? Магадгүй тийм шалтгаанаас болж чи эргэлзэж байгаа биш үү? Яг тийм. Өөрөөр хэлбэл чи энгийн хүний мэдлэг, энгийн хүний бодлоос үүссэн төсөөллөөр Фа-г дүгнэж байна. Энгийн хүмүүс хамгийн доод давхаргад оршдог биш үү? Тэд төөрөлтөнд байдаг биш үү? Орчлон ертөнцийн үнэнтэй харьцуулах юу байна? Юу ч байхгүй. Бидний энэ Дафа, хамгийн доод энгийн хүний байдалд, хүний хэлээр хамгийн доод хэлбэрийн илэрхийлэх байдлаар заагдсан. Тиймээс харахад Дафа их өнгөцхөн хэмжээнд заагдсан мэт. Гэхдээ чи үргэлжлүүлэн хичээллэх тусам энэ нь улам гүнзгий агуулгатай болно. Их хичээллэх тусам энэ нь хэмжихэд улам гүн, хүрэхэд тун хол болно. Нөгөө талаар энгийн хүний мэдлэгт тийм гүн мэдээлэл байхгүй. Чи энэ бүх үл итгэх, эргэлзэх байдлаа өөрийнхөө бодол гэж үзэж байгаа бол том алдаа. Тэдгээр төсөөлөл бол энгийн хүний нийгэмд төрсний дараа бий болсон. Чи үүнийг өөрийн бодол гэж байна, гэхдээ чинийх биш.

Асуулт: Миний тэнгэрийн мэлмий бясалгаж эхэлхээс өмнө нээгдсэн. Би хүний төөрөг, заяаг үзэж өгдөг ажил хийдэг. Би энэ ажлаа болих хэрэгтэй юу?

Багш: Хэрэв чи бясалгадаггүй, энгийн хүн байх хүсэлтэй бол би үүний эсрэг байхгүй. Би сурагчдад Фа зааж бясалгах боломж олгож байна. Би хүн болгоныг ирүүлж Дафа-гаар хичээллүүлэх гээгүй. Хэрэв чи бясалгаж чадна гэж бодвол хий, эс бөгөөс битгий. Ирээдүйн энгийн хүний нийгэмд төөрөг заяа үзэх, газар ус шинжих (фэншүй) болон янз бүрийн арга хэрэглэн өвчин эмчлэх гэх мэтийн зүйлс байсаар байж магадгүй. Энэ бүгд дэлхийд үеэс үед байсаар ирсэн. Бясалгагч хүний хувьд чи ирээдүйд илүү дээд түвшний зүйлийг харж чадна. Чиний үг улам их хүч, энергитэй болно. Чи хүмүүст мэрэглэж өгөхөд асуудал гарна. Орчлон дахь зүйлс заримдаа тогтворгүй, зарим зүйл тийм ч байж болно, үгүй ч байж болно. Хэрэв тэр хүн чамд итгэвэл, их итгэвэл үүнийг улам хүчтэй болгож болно, чи энергитэй, хэлсэн үг чинь тэр тогтворгүй зүйлийг бодит болгож болно,

урьдынхаар болох ёсгүй байсан зүйл болж болно. Чиний харсан бол бодит нөхцөл байдал биш, үүнд бас хувь тавилангийн шалтгаан оршдог. Гэхдээ чи хэлчихвэл тэр байдлыг баталгаажуулна. Тэгвэл чи магадгүй муу зүйл хийсэн болно. Тийм хэлбэрийн нүглийг чи өөрийн бясалгал дээрээ нэмнэ. Хариуд нь чамд саад бэрхшээл, гай зовлон учирна, тэдгээрийг чи давах хэрэгтэй болно. Гэхдээ чи өөртөө нэмж учруулсан гай зовлонг давах чадваргүй. Хэрэв чи муу зүйл хийж тэр нь их нөлөөлж том хор уршиг таривал чи үүнийг бүр давж чадахгүй, бясалгаж чадахгүй болно. Тиймээс бясалгадаг хүн үг яриагаа бясалгахыг ярьдаг. Гэвч чи тэр шаардлаганд хүрээгүй унасан. Хэрэв чи бусдад юу харснаа шууд хэлбэл тэнгэрийн нууцыг задалсанд тооцогдоно, энгийн хүмүүст хариуцлагагүй хамаагүй хэлсэн болно. Тэгж яаж болох юм? Үүнийг тэр тусмаа хийхийг зөвшөөрөхгүй.

Түүнээс гадна та нарт хэлэхэд, үзмэрчдийн ихэнх хувьд дотоод хүчин зүйлээс гадна гадны хүчин зүйлс байдаг. Тэд нөлөөлдөг, иймээс их аюултай. Амь болгонд энэ нь тун аюултай! Тийм нөхцөлд түүнд бясалгах арга байхгүй. Би энд хүмүүст зөвхөн зарчмыг хэлж байна, энгийн хүмүүст үүнийг битгий хий гэж хэлээгүй. Хэрэв чи бясалгахыг хүсвэл би чамд хариуцлагатай байх үүднээс энэ талаар хэлэх болно. Хэрэв чи хийвэл чамд гай болохоос өөр зүйл байхгүй. Чи ингэж бодож магад: "Тэгвэл би яаж амьдрах юм?" Би зөвхөн бясалгагчдад Дао зааж байна, Фа зааж байна. Чи бясалгаж чадвал бясалга. Би зөвхөн ингэж л хэлнэ. Би чамд хариуцлагатай байх ёстой. Нөгөө талаар энэ нь чамайг Дафа-гийн сурагч гэдгийг батлана, чи өөрийнхээ амьдралын хэрэгцээг хангаж чадна. Ийм л байх ёстой.

Асуулт: Би айхаас яаж ангижрах вэ?

Багш: Айх бол бас зууралдсан сэтгэл. Энэ асуулт чамд сэтгэлийн тэнхээ муу байгааг харуулж байна. Үүнийг давах хэрэгтэй. Зарим хүн хичээллэж эхлэнгүүт л шууд нойр нь хүрдэг гэж хэлдэг. Үүнийг бас сэтгэлийн тэнхээгээр ялах хэрэгтэй. Гэхдээ энэ нь ад чөтгөр биш ч гэсэн бясалгагчид ад чөтгөр шиг нөлөөлж болно. Хэрэв чи үүнийг давж чадахгүй бол энэ нь чамд нөлөөлнө.

Асуулт: Би Фалунийг миний хэвлийд эргээж байгааг хэзээ ч мэдэрч үзээгүй.

Багш: Хүн болгон мэдэрнэ гэсэн үг биш. Зарим хүн их мэдрэмтгий, энерги дөнгөж гүйхэд л "Пөөх ямар хүчтэй юм!" гэнэ. Зарим хүн хэвлийд нь газар хөдлөх чинээ зүйл болж байсан ч юу ч мэдэрдэггүй. Хүн бүрийн биеийн онцлог өөр. Хүний мэдрэх чадвараар хүний түвшний өндрийг битгий тодорхойл, мэдрэмжээр нь дүгнэж огт болохгүй.

Асуулт: Миний тэнгэрийн мэлмий хэзээ ч нээгдэхгүй юу?

Багш: Чи хүсч байна уу? Хэрэв гэгээрлийн хутагт ч хүрээд онгойхгүй бол ямар нэгэн зүйл буруу байна гэж би хэлнэ. Бясалгаад миний тэнгэрийн мэлмий нээгдэхгүй юу? гэсэн чинь юу гэсэн үг вэ? Хэрэв чи хүсээд байвал, тийм бодолтой байвал бага ч гэсэн харахыг чамд зөвшөөрөхгүй. Харах чадвартай болсон ч чи харж чадахгүй. Яагаад гэвэл тэр зууралдсан сэтгэл арилаагүй учраас юм. Тиймээс тэр зууралдсан сэтгэлийг битгий тоо, арилга. Дараа нь яахыг нь үзнэ.

Барууны сурагчид Азийнхнаас өөр, яагаад гэвэл Дорны ялангуяа Хятадын соёлын өв, уламжлал баялаг. Энэ нь зөвхөн тав, зургаан мянган жилийн түүхтэй биш, бас өмнөх үеийн соёл иргэншлээс уламжлагдсан. Тиймээс үүнд яс, эс нь хүртэл соёлын баялаг зүйлсээр дүүрэн. Харин Барууны соёл ахуй дөнгөж хоёр мянган жилийн л түүхтэй, төөрөгдөл нь амархан арилдаг. Тэдний төөрөгдөл арилангуут бараг шууд харж чадна. Хятадууд юугаар ялгаатай вэ? Хэрэв чи тэдэнд ямар учиртайг тайлбарлахад бодсоор л байна: "Тийм энэ нь зөв, гэхдээ яагаад ийм байгаа юм?" гэнэ. Чи тэдэнд яагаад ийм байгааг тайлбарлахад "Аан, тэгвэл яагаад заавал тийм байгаа юм?" гэнэ. Тиймээс чи тэдний эргэлзээг эцэст нь хүртэл тайлах хэрэгтэй, түүний дараа л бодол нь чөлөөлөгдөнө. Тиймээс Барууны олон сурагчид Фа-д суралцаж эхлэнгүүт санаандгүй хардаг болдог, ийм учиртай. Тэд энгийн хүний нийгэм дэх бага зэрэг өнгөцхөн зүйл дээр түгжигдсэн байдаг, тэднийг энгийн хүний онол хязгаарлаж байдаг. Энэ онол нь задрангуут тэднийг хязгаарлах зүйл байхгүй болно. Ийм л учиртай. Мэдээж дандаа ийм байхгүй, мэдрэмжээр танин мэдэх, ухамсраар танин мэдэх хоорондоо ялгаатай зүйлс. Хэрэв хүн Дафа-г сэтгэл зүрхэндээ шингээж чадвал, бясалгах явцдаа Дафа-г жинхэнэ ухамсарлаж чадвал, эхний үеийн мэдрэмжийн танин мэдэхүйгээс өөр. Үүний дүнд хүн Дафа-гийн ухамсрын танин мэдэхүй рүү дээшилнэ.

Асуулт: Дафа-г лам хувраг, гэлэнмаа нарт яаж дэлгэрүүлэх вэ?

Багш: Би лам хуврагуудын талаар дандаа боддог, ялангуяа өмнөх хоёр жил тэдний талаар санаа зовж байсан. Шагжамүни болон Есүс, агуу Гэгээрэгчид бясалгалыг үүсгэсэн, тэднийг уламжлан үлдсэн шавь нар нь байдаг. Тэд Буддын системийн сурагчдын дунд байдаг, би тэдний талаар үргэлж боддог. Гэхдээ Номын төгсгөлийн үеийн шашнуудад бясалгалдаа жинхэнэ дагнаж байгаа цөөхөн хүн байгаа. Би ийм нэг асуудлыг анзаарсан: Олон лам хуврагууд шашныг хамгаалдаг, Бурхад Буддыг биш. Тэдний сэтгэл бясалгалд биш, харин шашны зан үйлийг авч үлдэхэд байдаг, энэ зууралдсан сэтгэл нь тэдэнд ноцтой саад учруулж байна. Зарим хүмүүс шашнаас гадуур Буддын Ном байхгүй, зөвхөн ариун бус бясалгал байдаг гэж боддог. Энэ бол тэдэнд Дафа-г олж авахад саад болдог ноцтой шалтгаан. Гэхдээ зөв сэтгэдэг хүмүүс байдаг, бүхнийг ухамсрын үүднээс дүгнэж цэгнэж чаддаг. Тийм хүмүүс маш сайн. Тэд миний номыг уншсаны дараа энэ юу болохыг мэддэг, хүн бүрд Буддын мөн чанар оршдог. Яг цахилгааны хоёр туйлыг холбонгуут "пас" хийгээд залгагддаг шиг. Түүнд Буддын мөн чанар байхгүй бол залгагдахгүй, энэ оч үсрэхгүй, цахилгаан гүйхгүй. Тиймээс зарим хувраг, гэлэнмаа сурагчид бусдаас ялгардаг. Би тэднийг гайхамшигтай гэж хэлнэ, яагаад гэвэл энгийн хүний ахуй орчинг орхисон. Зорилго нь бол бясалгах. Харин зарим хүмүүст ариун бодол байдаггүй. Би шашны зүйлийн талаар их ярихгүй, би зөвхөн ярианы хажуугаар л дурьдлаа. Хэрэв чамд тэдний адил сүсэгтэн, найз нөхөд эсвэл хамаатан садан байдаг бол тэдэнд хэлж болно. Тэд бясалгахыг хүсвэл бясалгаг, хэрэв хүсэхгүй бол тэр л биз. Бид хүнийг хүчилж болохгүй. "Ирж бясалга, тэгэхгүй бол их харамсах болно шүү! Чи намайг дагах хэрэгтэй" гэж болохгүй. Хүний зүрх сэтгэлийг сэтгэл хөдлөлөөр өөрчилж чадахгүй, хүн өөрөө хүсвэл зүрх сэтгэл нь өөрчлөгдөж болно.

Асуулт: Сүм хийдэд тодорхой албан тушаалтай лам хуврагууд яаж жинхэнэ бясалгах вэ? Тэд энгийн нийгэмд буцаж орох хэрэгтэй юу?

Багш: Тэд энгийн нийгэмд буцаж орох шаардлагагүй. Яагаад? Миний ярьдаг нэг бясалгалдаа тууштай байх асуудал бол гол нь бидний одоо бясалгаж байгаа Фа-тай холбоотой, үүнийг бид бясалгаж байгаа. Урьд Буддын судрын үг болгоны ард Буддын дүрс байсан. Одоо судрыг сөхөхөд чи харахгүй, тэр байтугай Шагжамүни, Есүсийн нэрийн ард тэдний дүрс байхаа больсон. Энэ нь ном судрууд хүн аврах хүчгүй болсон гэсэн үг, тэдгээр нь зүгээр л цагаан цаасан дээрхи хар бэх. Цаашилбал шашны зан үйл хийх нь зүгээр л шашны хэлбэрдэл, би үүнийг энгийн ажил гэж үздэг. Үнэндээ олон лам хуврагууд тэдгээр зан үйлийг ажил гэж үздэг болсон, тэд ажил хийж цалин авч байна гэж боддог. Их газрын Хятадын хуврагууд янз бүрийн салбар хэлтсүүдэд хуваагддаг, тэндээс цалингаа авдаг. Тэдэнд бүр удирдах төв хороо хүртэл байдаг. Тэд Шагжамүнигийн анхны зүйлсийг өөрчилсөн. Хүмүүс Шагжамүнигийн тараасан, заасан Фа-г сүйтгэж байгаагаа мэддэггүй. Одоо ийм хэмжээнд хүрсэн, мэдээж Шагжамүни тэднийг хариуцахаа больсон учраас одоо байдал ийм болсон. Тиймээс би үүнийг ажил гэж үзнэ. Судар уншсан ч, шашны зан үйл хийсэн ч нөлөө байхгүй. Дафа-гаар бясалгаж байгаа бол бид ямар ч хэлбэрдэл, зан үйлд анхаарахгүй. Агуу Дао-д хэлбэр үгүй гэж хэлсэн. Энгийн хүний нийгэм дэх ямарч хэлбэр, ийм аугаа Фа-тай огт нийцэхгүй. Бид хүний сэтгэл рүү хардаг, юмыг энгийнээр зохион байгуулдаг. Хэрэв чи бясалгавал би чамайг хариуцна. Энэ харж хандах нь энгийн хүнд харагдахгүй, энгийн хүний нийгмийн ямарч хэлбэрт хязгаарлагддаггүй. Бидэнд хэлбэрдэх байдал байхгүй учраас энгийн хүний дунд хийсэн бүх зүйлийг ажил гэнэ, би үүнд ингэж л ханддаг. Хэрэв чи лам хувраг бол, шашны зан үйл хийхийг хүсвэл өөртөө хийж болно. Чи Дафа-гаар бясалгаж байгаа гэдгээ мэднэ, энэ л хангалттай. Шаргуу бясалгахдаа л гол нь анхаарах хэрэгтэй. Энэ асуудалд ингэж л хандах хэрэгтэй. Бусад шашны хүмүүсийн хувьд мөн адил.

Асуулт: Тайван ариун сэтгэл гэдэг нь бидний сонирхдоггүй бүх зууралдсан сэтгэлээсээ салахыг хэлэх үү?

Багш: Ариун амгалан сэтгэлд жинхэнэ хүрвэл тийм болно. Гэхдээ чи энгийн хүний төвшнөөс эхэлж бясалгаж байгаа, тиймээс шууд үүнд хүрэх боломжгүй, шууд ийм байдалд хүрвэл Будда болсон гэсэн үг, тэгэхээр боломжгүй. Буддын түвшинд хүрэхийн тулд бясалгалын явцыг дамжих ёстой, ухамсрын бат суурьтай байх хэрэгтэй. Чи үүнд шаргуу бясалгалын замаар, өөрийгээ тасралтгүй дээшлүүлж байж аажмаар жамаараа хүрнэ, чамайг гэнэт тэр түвшинд хүргэнэ гэвэл чи магадгүй зүрхшээгээд бясалгахгүй болно. Яагаад гэвэл чи дөнгөж энгийн хүний түвшнээс эхэлж байгаа учраас чиний ухамсар тийм өндөрт хүрээгүй. Үүнд чи аажмаар жамаараа хүрнэ. Чи бясалгаад, номоо уншаад байвал үүнд хүрч чадна. Фа зарчим чиний бүх төвөгтэй асуудлыг шийдэж өгч чадна. Хүчээр шахах хэрэггүй, хүчээр шахах бол нэг ёсны албадлага. Чи өөрийгээ бясалгагч гэж үзэж байвал л болоо. Хүн бүр сэтгэлээ бясалгадаг, муу зүйл хийхгүйг хичээ. Энэ бол албадлагаар хийж байгаа зүйл биш. Үүнийг өөрийнхөө төрөлх мөн чанарт ойртох гэдэг.

Асуулт: Хүндэт Багшаа, та шинжлэх ухааныг шашин гэсэн, гэтэл би эрдэм шинжилгээний ажлаа сайн хийх хэрэгтэй. Энэ нь надад үргэлж зөрчилдсөн асуудал болох юм.

Багш: Би шинжлэх ухаан бол шашин гэж хэлсэн. Энэ талаар би их дэлгэрэнгүй ярьсан. Яагаад шашин болдог, өргөн хүрээтэй шашин болсон бэ? Яагаад гэвэл энэ нь буянд ач

холбогдол өгдөггүй, Бурхдын оршдогийг хүлээн зөвшөөрдөггүй. Бурхдын оршихуйг харж чадахгүй учраас хүн муу зүйл хийвэл гэсгээн шийтгэгдэнэ, сайн үйл хийвэл ивээл буян хүртэнэ гэдгийг хүлээн зөвшөөрдөггүй. Хэрэв хэн нэгэн сайн үйл хийвэл аз жаргал хүртэнэ, муу үйл хийвэл шийтгэл хүлээнэ, Бурхад оршдог гэвэл түүнийг шинжлэх ухааны онолоор эсэргүүцнэ, дайрч давшилна. Ариун номын шашин луу хүртэл дайрна, хүн төрөлхтний ёс суртахууныг сүйтгэнэ. Ёс суртахууны хязгаарлалтгүй хүн ямарч муу үйл хийхээс буцахгүй. Энэ тал дээр дүгнэвэл шинжлэх ухаан шударга уу эсвэл харгис уу? Харгис нөлөө үзүүлж байна гэхгүй гэж үү? Одоогийн хүмүүсийн ёс суртахуун яагаад ингэж доошоо их унаж байна вэ? Яагаад гэвэл хүмүүст ариун итгэл үнэмшил байхгүй, ялангуяа Барууныханд. Үнэндээ та бүхэн шашинд жинхэнэ итгэдэггүй харин шинжлэх ухаанд итгэдэг. Чи сэтгэл рүүгээ хараад үз, шинжлэх ухаанд бүхнээс илүү итгэдэг. Та нарт бусад бүх зүйл хоёрдогч, харин шинжлэх ухаан бол хамгийн чухал. Би үүнийг онцлон хэлж байна, яагаад гэвэл энэ нь та нарын бясалгалд саад болж байна.

Урьд Римийн католик сүм, хүн сармагчингаас хувьслын дүнд үүссэн гэдгийг хүлээн зөвшөөрдөггүй байсан, Бурхан хүнийг шавраар бүтээсэн гэж үздэг байсан. Харин одоо Римийн сүм, хүн сармагчингаас хувьслын үр дүнд үүссэн гэж нээлттэй хүлээн зөвшөөрсөн. Үүгээр өөрийн бурхнаа үгүйсгэсэн. Шинжлэх ухаан ийм л их хүчтэй, одоогийн бүх хүмүүс үүнд итгэдэг. Би хүн төрөлхтний их бага ямарч асуудлыг тодорхой тайлбарлаж өгч болно. Би хүн төрөлхтний хөгжилтэй холбоотой эртний болон одоогийн бүх зүйлийг тодорхой тайлбарлаж өгч болно. Гэхдээ энэ бүгд энгийн хүний хэрэгт хамаатай учраас би үүнд анхаарлаа хандуулдаггүй. Би та нарын бясалгалтай холбоотой зүйлийг л ярьдаг. Шинжлэх ухааны матери, орчлон ертөнцийн талаар болон амьтай холбоотой бараг бүх үндсэн танин мэдэхүй нь алдаатай. Австралийн дээр гарсан цоорхой болон Антарктидийн дээрхи озоны давхаргад гарсан цоорхойг үйлдвэрийн хорт утаа, хөргөлтөнд ашигладаг фреон болон бусад ялгарч байгаа хийнүүдээс болж озоны давхарга цоорох шалтгаан болсон гэж өнөөгийн шинжлэх ухаан тайлбарладаг. Би хэлбэл үнэндээ энэ орчлон ертөнцийн бүх зүйлс амьтай, та бүхэн хийн төлөвт орших агуу том биетийг харахгүй, тэдгээрийн давхарга тоолшгүй олон. Энэ бүгд амьтай, бүгд Бурхдууд. Орчин үеийн шинжлэх ухааны бүтээн байгуулсан үйлдвэрлэл, хүн төрөлхтний орших орчинг ноцтой сүйтгэж байна, энэ бол туйлын үнэн. Гэхдээ энэ цоорхой бол утаа, хийнээс болж үүсээгүй, хүмүүс Бурхдыг сүйтгэж чадахгүй. Яагаад энэ цоорхой аж үйлдвэрлэл их хөгжсөн Европын дээр гараагүй вэ? Яагаад Антарктидын дээр, хүн байдаггүй газарт гарсан бэ? Бурхад дэлхий дээр ялгарсан хорт утаа, хий маш их болсныг хараад тэд өөрсдөө цонх онгойлгож тэр хорт утаа хийг гаргаад дараа нь хаасан. Энэ нь одоогийн шинжлэх ухааны тайлбарладаг шиг огт биш.

Одоогийн хүн төрөлхтний хөгжил нь шинжлэх ухаан бүх салбаруудыг удирддаг болсон энэ үед орсон. Тиймээс одоогийн хүн төрөлхтөн үүнээс салж чадахгүй, энэ нь хүн төрөлхтний хөгжлийн бодит илрэл болсон. Үүнтэй нийцэхгүй бол байрнаасаа хөдөлж чадахгүй. Бид энгийн хүмүүсийн нийгэмд боломжийн дээд хэмжээгээр зохицон явдаг болохоор чи өөрийнхээ эрдэм шинжилгээний ажлыг зохих ёсоор нь хийх хэрэгтэй. Энэ бол чиний буруу биш. Үүнээс зөвхөн нэг хүн, нэг үндэстэн, эсвэл нэг улс орон салах асуудал биш. Энэ нь ажил учраас чи өөрийнхээ үүргийг гүйцэтгэ, ажлаа хий. Ийм ёстой. Зөвхөн үүнийг чи шинжлэх ухааны төлөө хийж байна гэж битгий бод. Хүн төрөлхтний бараг бүх зүйл үүний төлөө оршиж байна. Үүнээс болж чи бүх зүйлээ хийхээ больж

болохгүй. Бясалгагч хүний хувьд та нар энэ зарчмыг л ойлгоосой гэж би хүсч байна. Би та нарыг хүний нийгмийн салшгүй болсон энэ бодит байдлаас хөндийр гэж хэлээгүй, би та нарыг хийдэг ажлаа боль гэж хэлээгүй.

Би шинжлэх ухаан бол шашин, боловсронгуй шашин гэж хэлсэн. Энэ нь та нарыг эхлээд материаллаг талаас нь танихад дагуулна, дараа нь оюун санаагаараа итгэхэд хүргэнэ. Нөгөө талаар жинхэнэ шашин бол чамд эхлээд зарчмыг ойлгуулна, оюун санаандаа үнэхээр ойлгоно. Чиний ойлголт хийсвэр сэтгэхүйгээс бодит байдалд хувирна, чи яваандаа үүнийг үнэхээр материаллаг талаас нь ойлгож эхэлнэ, тэгээд гэгээрлийн хутагт хүрч тэнгэрийн орондоо буцна. Ийм л явцтай. Шинжлэх ухаанд бол бүгд эсрэгээр, энэ нь эхлээд материаллаг тал руу хүний оюун санааг дагуулдаг, харин шашин бол оюун санааны танин мэдэхүйгээр материаллаг өөрчлөлтөнд хүргэдэг. Би энэ зарчмыг та нарт ойлгуулахын тулд ярьж байна, яагаад гэвэл шинжлэх ухаан аль хэдийн нийгмийн бодит зүйл болсон. Би хүн төрөлхтний оршихуйд хамааралтай болсон шинжлэх ухааны эсрэг яриагүй, зөвхөн одоогийн оршиж байгаа шинжлэх ухааны үнэн байдлыг ярьж байна.

Асуулт: Багшаа, нинжин сэтгэлийн учир холбогдлын талаар ярьж өгч болох уу?

Багш: Чи нинжин сэтгэлийн талаар асуулаа, би чиний бодлыг засч өгөх хэрэгтэй. Нинжин сэтгэл гэж юу болохыг хэлье. Хэрэв хүн энгийн хүний нийгэмд сайхан амьдарч, гай зовлон, бэрхшээлгүй байвал, өдөр болгон тааламжтай, санаа зовох юмгүй, хангалттай мөнгөтэй, хэрэгтэй бүх зүйл нь байвал Бурхан түүнд нинжин сэтгэлээр хандаж байна гэж бодно, түүнд их эелдэг хандана. Би чамд хэлье, Бурхан тийм байдаггүй. Хэрэв үнэхээр тэгж ханддаг бол хүмүүст маш муугаар хандаж байна гэсэн үг. Яагаад гэвэл хүний бүх зарчим эсрэгээр. Хүн амьдралдаа нийгэмтэй харьцана, тэгэхээр нүгэл хураана гэдгийг бүгд мэднэ. Есүс, хүн нүгэлтэй гэж хэлсэн. Нүгэлтэй болохоор энгийн хүний энэ орон зайд унаж ирсэн. Мөн энэ орон зайд амьдралаас амьдралд нүгэл хураасан, гэмт хэрэг үйлдсэн. Хэрэв чи сайхан амьдрахыг хүсвэл өөрийнхээ нүглийг наминчлахыг хүсэхгүй байгаатай адил биш үү? Хэрэв нүглээ наминчлахгүй бол энэ амьдралдаа үйлдсэн бүх нүгэл, үйлийн үрийнхээ хариуд дараагийн амьдралдаа хүний биеийг олж төрөхгүй, магадгүй бүр ч муу болж болно. Хэрэв чи улам их нүгэл үйлдвэл там руу унахаас өөр зам байхгүй, бүр доош унавал чамайг бүрэн устгал хүлээнэ. Тэгвэл хэл дээ, энэ зарчмын үүднээс харвал Бурхан чамд яаж хандвал зохистой вэ? Бурхны ямар хандлага чамд хамгийн дээр вэ? Үүнд гол учир нь байгаа юм.

Би жинхэнэ нинжин сэтгэлийг (Сибэй) юу гэж үздэг вэ? Хэрэв хүн үнэхээр сайн бол, энэ насандаа ад чөтгөрийн зүгээс их зовлон бэрхшээлтэй тулгарна. Энэ зовлон бэрхшээлийг туулах зорилго нь бол өөрийн нүглийн өрийг төлөх, энэ насандаа хүний биеийг олж төрсөн боломжоо алдалгүй өөрийнхээ нүглийг аль болох хурдан төлөх явдал юм. Бүх нүглээ төлсний дараа хүн Тэнгэрийн оронд очиж болно, тэнд үүрд жаргалтай байх болно. Тийм учраас тэр хүн энгийн хүмүүсийн дунд зовлон туулна. Тэгвэл боддоо жинхэнэ нинжин сэтгэл гэж юу вэ? Буддын үзэл бодол хүнийхээс огт өөр. Энгийн хүмүүс Будда, Бурхдууд тэдэнд энгийн хүний жаргал эдлүүлбэл нинжин сэтгэл үзүүлж байна гэж боддог. Хэрэв аз жаргалгүй бол Тэнгэрт гомдол мэдүүлнэ: «Аая, Бурхан яагаад надад туслахгүй байна вэ? Би азгүй хүн юм!» Энэ бол яг Бурхан чамд тусалж байна гэсэн үг, чамд нүглээ арилгахад тусалж байна, хэзээ ч төрөх үхэх байдаггүй, доош унахгүй тийм

оронд буцаахад тусалж байна. Энэ ямар сайн хэрэг вэ? Энэ бол жинхэнэ нинжин сэтгэл. Чи бясалгаж байна. Би яагаад чиний бүх зовлонг арилгадаггүй вэ? Та нар зовлон бэрхшээл туулах хэрэггүй, би та бүхнийг зүгээр дээшлүүлж болох уу? Энэ нь ямар нинжин сэтгэл болох юм! Тэгж болохгүй! Та нар үлдсэн нүглийн өрөө өөрсдөө төлөх ёстой. Бушуухан төл, бушуухан төл, зөвхөн тэгвэл би чамайг эрт аварч чадна. Тийм учиртай биш гэж үү? Би нинжин сэтгэлийн талаар өөр өнцгөөс ярьж байна, нинжин сэтгэл юу вэ гэдгийг хэлж байна. Би Дафа-г та нарт зааж байна, энгийн хүмүүст заагаагүй. Үүнийг та бүхэн үүрд санах хэрэгтэй. Энгийн хүмүүс үргэлж төөрөгдөлд байдаг. Тэдэнд энэ зарчмыг мэдэхийг зөвшөөрөхгүй. Хүн бол хүн, харин та нар бол бясалгагчид. Бясалгагчид энгийн хүнээс үргэлж ялгагддаг.

Нэг зүйлийг та нарт хэлж болно. Бурхад бүгдийг ажиглаж байдаг болохоор орчлон дээрх бүх зүйлс санамсаргүй биш. Энэ орон зайд Бурхдууд бий, дахин төрөл олохыг хариуцсан Бурхан, нийгмийн тогтвортой байдал хариуцсан, нийгмийн системийн тогтолцоог хариуцсан, дэлхийн тогтвортой байдлыг хариуцсан, агаар болон түүний янз бүрийн найрлагыг хариуцсан гэх мэт Бурхад байдаг. Янз бүрийн гэгээрэгчдийн хийж байгаа үйлдлийг хянаж байдаг Бурхад ч бий. Энэ орон зайд хамгийн олон төрлийн Бурхад байдаг. Тэдгээр Бурхад энэ бүхнийг хариуцахгүй байж болох уу? Хүний нийгэмд аливаа зүйлс хүний хүссэнээр болж болох уу? Энэ бол огт боломжгүй.

Асуулт: Дээд түвшний оршихууд харилцан дэмжих, харилцан эсэргүүцэх зарчмын хоёр матери Жэнь, Шань, Рэн-д ойр уу?

Багш: Тэгж ойлгож болохгүй. Бүх Сансар ертөнц Жэнь, Шань, Рэн-ээс бүтдэг. Би ингэж хэлье: Орчлон ертөнцийн энэ хоёр материйг Жэнь, Шань, Рэн үүсгэсэн. Хэрэв энэ орчлон ертөнцөд зөвхөн эерэг тал оршвол амьдрал уйтгартай болно, аз жаргал гэж байхгүй, зовлон зүдгүүр гэж байхгүй бол бүгд ямарч сонирхолгүй амьдарна. Зовлон зүдгүүр, бэрхшээл гэж байгаа учраас аз жаргалыг мэдэрнэ, нандигнахыг мэднэ. Тийм болохоор амьдрал сонирхолтой. Орчлон ертөнцөд эерэг тал байхад бас сөрөг тал байхаар зохицуулагдсан, энэ нь амь бодийн нүглийг арилгаж чадна.

Асуулт: Дафа-г хамгаалах тухай асуудал яригдахад миний цөс хөөрөх юм. Багшаа ийм байдал зөв үү?

Багш: Энэ зөв биш, зөв биш. Юу ч болж байсан үүнд анхаараарай! Би дөнгөж сая дурьдлаа, асуудал болгонд эерэг тал, бас сөрөг тал байдаг. Сөрөг тал доод түвшинд буухад харгис тал болдог, эерэг тал доод түвшинд буухад эелдэг тал болдог. Тиймээс би та бүхэнд хэлж байна, энгийн хүний нийгэмд тийм зүйл хийж хэрхэвч болохгүй, тийм зүйлийг энгийн хүмүүс л хийдэг. Бид эелдэг талаар хандах ёстой. Шагжамүни хэлсэн: "Бүх амь бодид Буддын мөн чанар оршдог". Үнэн хэрэгтээ би хэлбэл, амь бодь болгонд ад чөтгөрийн мөн чанар бас оршдог. Өөрөөр хэлбэл чөтгөрийн мөн чанар, Буддын чанар нэг амь бодид зэрэг оршдог. Хүн уур хилэнгийн үед, ухаанаа алдсан байдалд ад чөтгөрийн шинж илэрдэг, хүн ухаалаг, эелдэг, энэрэнгүй байхад Буддын шинж давамгайлдаг. Энэ хоёр шинж чанар янз бүрийн байдалд илэрч болно, тиймээс бид эелдэг талаас үргэлж хандах хэрэгтэй. Саяхан телевизээр бидний тухай үнэн бус мэдээлэл нэвтрүүлсэн. Бид энэ асуудлаар телевизийн газар очиж ярихад бүгд эелдэг, ухаалаг байсан. Тэр үед тэнд бас

олон хүмүүс очсон. Гэхдээ олон хүн байлаа гээд муу юм болох албагүй. Хүмүүсийн хэрэглэдэг зан байдал, арга барил нь сайн, муу байж болно. Тэд үнэхээр сэтгэлээсээ үнэнийг тайлбарласан, улс төрийн асуудал хөндөөгүй, нийгмийн өмч хөрөнгө сүйтгээгүй, хэв журам зөрчөөгүй. Хүн болгон бясалгагчийн байр суурьнаас бидний үнэнийг ойлгуулсан. Телевизийн ажилтнуудын сэтгэл их хөдөлсөн, урьд нь ийм хүмүүсийг харж байгаагүй. Хүний нийгэмд яагаад хүчирхийлэл байдаг вэ? Энгийн хүмүүс ямар нэгэн зүйлийг хамгаалах, ямар нэгэн үнэнийг хэлэхийг хүсвэл эсэргүүцлийн жагсаал цуглаан зохион байгуулдаг. Тэд хүчирхийлэл хэрэглэдэг, хашгирдаг, бүр зэр зэвсэг хүртэл хэрэглэдэг. Яагаад гэвэл хүмүүс ад чөтгөрийн талаа харуулдаг, тэд бол энгийн хүмүүс. Харин бид бясалгагчид, зөвхөн сайн талаа гаргана, муу талаа харуулахгүй байх хэрэгтэй. Энгийн хүмүүс сайн, муу хоёр талаа хэрэглэдэг, учирлах, хүчирхийлэх хоёуланг хэрэглэдэг. Тэд маргалдаад ялагдвал хараана зүхэнэ. Энгийн хүн сайн, муу хоёр талтай.

Асуулт: Багш орчлон ертөнцийн цэвэрлэгээний үед зарим харь гаригийнхан дэлхий рүү зутсан гэж хэлсэн. Тэгвэл тэдний орших хэлбэр ямар вэ? Шүглэсэн сүнс хэлбэрээр үү, эсвэл өөр хэлбэрээр байдаг уу?

Багш: Би эхлээд харь гаригийнхан гэж ямар учиртайг нь ярья. Та нар дэлхий бол ертөнцөд амьдрал оршдог ганц гариг биш, мөн дэлхий зөвхөн энэ удаа оршиж байгаа биш гэдгийг мэднэ. Би энэ дэлхийн байршил дээр урьд олон дэлхийнүүд оршиж байсан гэж хэлмээр байна. Тэдгээр дэлхийнүүд устсан, зарим нь дэлбэрсэн. Тэгж олон удаа устсан, тоо нь нилээд их. Дэлхийн сүүлчийн үе болоход орших амь бодиуд хамгийн муудсан, бүх бодисууд нь хамгийн ихээр бохирдсон, тэгээд оршин тогтнох аргагүй болдог. Энэ дэлхий бүхэлдээ карма-нүглийн бөмбөрцөг болоход устдаг. Үндсэн шалтгаан нь бол амь бодиуд дахин төрөл олохдоо шороо, чулуу, ургамал, матери болж болно. Ямарч зүйл болж төрсөн бүгд нүглээ хамт авч явдаг. Хаа сайгүй карма, тэгэхээр дэлхийн бөмбөрцөг нүглийн бөмбөрцөг болдог учраас үүнийг устгах хэрэгтэй. Гэтэл дэлхий дээр харьцангуй сайн хүмүүс бас байсан. Гэхдээ тэд цөөн, тун цөөхөн байсан. Тиймээс тэднийг Гурамсан ертөнц доторхи өөр гариг луу шилжүүлсэн. Дэлхий хэдэн удаа солигдсоныг тоолох аргагүй. Тэр болгонд, хүмүүс үлдэж байсан. Яваандаа тэдгээр үлдсэн амь бодиуд олширсон. Бурхад тэр үе болгонд хүмүүсийг янз бүрийн төрхтэйгээр бүтээдэг байсан, хоорондоо их ялгаатай, мөн зарим нь өөр гаригууд дээр бүтээгдсэн. Тэдгээр нь бол харь гаригийнхан юм. Тэд түүхэнд тийм нэг тэмдэглэл шиг түүхийн хуудас болон үлдсэн, ийм л бага зэрэг үүрэг гүйцэтгэсэн. Сүүлчийн үеийн дэлхийгээс үлдэгсэд өөр гариглуу технологоо авч очсон, тиймээс тэдний хөгжлийн эхлэл цэг харьцангуй өндөр байсан. Урт хугацааны туршид тэдний хуримтлуулсан сансар ертөнцийн талаархи мэдлэг одоогийн дэлхийн хүмүүсийнхээс хол давсан. Тэдний бие бас өөр орон зайд орж чадна, өөр орон зайн нөхцөлд зохицож чаддаг, тийм түвшинд хүрсэн. Тэдний хэрэглэдэг нааш цааш нисдэг хөлөг нь хүмүүсийн хэлдгээр нисдэг таваг нь өөр орон зайд орж чаддаг, цаг хугацааны өөр орон зайд нисч чаддаг. Хэрэв тэд хурдан цаг хугацааны орон зайд нисвэл хэсэгхэн хугацаанд их хол нисч чадна, тиймээс тэр хурдыг хүн төсөөлөх аргагүй. Тийм нисдэг биетийн хэрэглэдэг түлш одоогийн шинжлэх ухааны илрүүлж чадах бодис биш, техникийн онолоор тайлбарлаж чадахгүй.

Урт хугацааны турш тэдгээр харь гаригийнхан зогсолтгүй хөгжсөөр, зогсолтгүй хувирсаар. Энэ орчлон ертөнцөд тэдний дунд хэвийн бус нийгмийн харьцаа үүссэн.

Шунал, хүслийн улмаас тэнд үнэхээр оддын дайн маягийн үйл явдал гарсан. Энэ нь хүн төрөлхтөнд хараахан заналхийгээгүй байна, яагаад гэвэл хүн төрөлхтөн тэдэнд аюул учруулах чадваргүй, тийм чадвартай байсан бол тэд хүн төрөлхтөн лүү аль хэдийн довтлох байсан. Гэхдээ харь гаригийнхан хүн төрөлхтөн лүү халдаагүй ч гэсэн хүний бие махбодь хамгийн боловсронгуй бүтэцтэй гэдгийг мэднэ, тиймээс тэдний анхаарлыг татсан, тэд хүний биетэй болохыг хүсдэг. Харь гаригийнхан шинжлэх ухааныг хүн төрөлхтний бүх салбарт нэвтрүүлсэн, хүмүүсийг шинжлэх ухаанд бат бөх итгэдэг болохыг шахдаг, хараат байлгахыг хүсдэг. Хүний сэтгэн бодох, орших хэлбэр тэднийхтэй адил болоход тэд хүний сүнсний оронд орно, тэгээд хүн тэд нар болно. Тийм замаар эцэст нь хүн төрөлхтөнийг солино.

Энэ бол урт түүхтэй. Барууны орнуудад анх аж үйлдвэрийн хувьсал гарсан үеэс тэд бүх салбарт ирсэн байсан. Тэд түүнээс ч өмнө ирсэн, гэхдээ тэр үед хүмүүсийг удирддаггүй байсан. Цагаан арьстны нийгэм, техникийн нийгмийн шатанд шилжин ороход тэд бүх чиглэлээр орж ирэх болсон. Энэ дэлхийг эзлэн авахын тулд тэд бүрэн бэлдсэн, системтэй төлөвлөгөө зохиосон, хүмүүст шинжлэх ухааныг үүсгэсэн, энэ шинжлэх ухааныг харь гаригийнхан үүсгэн байгуулсан юм. Тэд хүнийг ижилсүүлэх, бодол санааг нь машин шиг нэг хэвийн болтол энгийн болгох, мэдлэгийг нь ижилсүүлж сүүлд хүмүүсийг удирдан солиход амар болгох зорилготой. Тэд хэдэн үндэстнийг сонгон авч өөрсдийн хэтийн зорилгоо биелүүлэхэд ашиглах, хүн төрөлхтнийг удирдах тэргүүлэгч болгосон. Япон бол технологийг манлайлагч, АНУ дэлхий дээрхи бүх эртний соёлоос таслагч тэргүүлэгч, үүнээс хамгийн эртний өв соёлтой, хамгийн түгжигдмэл улс орон хүртэл зайлж чадаагүй. Бүх дэлхий АНУ-ын шинэ соёл ахуйд автсан. Эхний шатанд Англи бол хүнд үйлдвэрийн тэргүүлэгч байсан, Испанийг хүн төрөлхтний үндэс угсааг холиход тэргүүлэгч болгосон. Яагаад гэвэл Бурхдаас хөндийрүүлэх, харь гаригийнхан арьс үндэстнийг хооронд нь холих замаар хүний үндэс угсааг таслах, одоогийн хүмүүсийн эрлийзжүүлж гаргаж авсан ургамал шиг болгох. Өмнөд болон Төв Америкийн хүмүүс, Мексикчүүд, Зүүн өмнөд Азийн зарим хүмүүсийн арьс үндэс холилдсон. Гэвч юуг ч Бурхдын нүднээс нууж чадахгүй. Харь гаригийнхан хүн төрөлхтнийг удирдах хангалттай бэлтгэл хийсэн.

Компютер хэрэглэж чаддаг хүн бүрт дугаар тавьсан. Мэдээж манай сурагчдад тийм асуудал байхгүй. Чамайг дөнгөж Фа олж авахад тэдний удирдлаганд байдаг чиний биений давхаргыг би аль хэдийн цэвэрлэсэн. Тэд өөрсдийн биений нэг давхаргыг хүний биед үүсгэсэн. Энэ бол маш аюултай! Бага ангийн сургуулиас их сургууль хүртэл бүх хүн харь гаригийнхны авчирсан шинжлэх ухааныг сурдаг. Мөн хүн төрөлхтний одоо хэрэглэдэг бүх зүйлс бол энэ хаа сайгүй дэлгэрсэн шинжлэх ухааны бүтээгдэхүүнүүд. Яагаад хүмүүст онгод орж компьютер зохион бүтээж, технологи ийм асар хурдацтай хөгжиж байна вэ? Энэ нь харь гаригийнхны хүн төрөлхтнийг удирдахын тулд суулгасан тэр давхаргын нөлөөгөөр явагдаж байгаа юм. Орчин үед компьютер их хурдан хөгжиж байна, гэхдээ энэ бол хүн төрөлхтний техник биш. Хэрэв энэ байдлаар цааш үргэлжилбэл хүн төрөлхтөн харь гаригийнхнаар солигдоно. Гэхдээ та бүхэн боддоо, харь гаригийнхан бол зөвхөн Гурамсан ертөнцийн хүрэн дотор оршдог амь бодь. Тэд ийм зүйл хийж зүрхэлж байгаа өөр нэг шалтгаан бий. Яагаад гэвэл орчлон ертөнцийн зарчим хазайсан, Бурхад үүнийг хариуцахаа больсон. Энэ нь дээд түвшний амь бодьтой холбоотой. Энэ асуудлыг өөрчлөхийн тулд дээд түвшнээс эхлэх хэрэгтэй, яагаад гэвэл тэдний бодол нь: Хүн муудсан, ёс суртхуунаа алдсан, тиймээс хэрэв солигдвол солигдог, хүн тэртэй тэргүй

устгагдах болсон гэж үздэг. Бурхад хүнд нигүүлсэнгүй ханддаг, яагаад гэвэл Тагагата, Бодьсадва нар хүмүүст хамгийн ойр, тэд Буддын хамгийн доод түвшнийх. Энэ түвшний Будда-гаас олон түвшин дээгүүр Будда, Тагагата Будда-г хараад энгийн хүнтэй адил үздэг. Тэгвэл тэдний хувьд хүн юу вэ? Юу ч биш. Муудсаныг нь хараад устгаад шинээр бүтээнэ. Тэдний ойлголт бол ийм л байдаг. Тэдний нигүүлсэнгүй сэтгэл хүнд биш, харин Буддуудад. Бүр өндөр түвшний агуу Гэгээрэгчид хүнийг хараад огт анзаарч үзэхгүй, микро организмаас ч дорд үзнэ. Та нар ерөнхий ойлголтыг авав уу? Зарим хүн ингэж хэлдэг: "Багшаа та биднийг ийм тийм замаар аврах хэрэгтэй". Би ингэж хариулдаг: "Чи, Будда чамайг аврахгүй бол сэтгэл нь тавгүйрхдэг гэж бодож байна уу? Асуудал үүнд биш". Будда зөвхөн нигүүлсэнгүй сэтгэлийн үүднээс хүнийг авардаг. Харин хүмүүс өөрсдийгээ тодорхой байдлаар аврагдах сонголт хийхийг хүсдэг, тодорхой аргаар бясалгахыг хүсдэг. Тэд юу ярьж байгаагаа мэддэггүй.

Харь гаригийнхний байдал ийм учиртай. Дээгүүр тэднийг цэвэрлэж эхлэхэд зугтаж энд ирцгээсэн. Тэд сүүлийн жилүүдэд олноороо ирсэн. Гэхдээ тэд миний хийж байгаа үйл хэргийг мэдэхгүй, энэ нь бас системтэй эртнээс төлөвлөгдсөн. Тэд хаашаа ч зугтсан тэдэнд явах газар байхгүй. Тэд үйлдсэн муу хэргийнхээ төлөө шийтгэл хүлээх ёстой. Энэ бол гарцаагүй. Орчлон ертөнцийн хууль бол аль ч амь бодийн хувьд шударга, тиймээс хийсэн бүх муу хэргийнхээ төлөө нүглээ наминчлах ёстой. Эцсийн эцэст тэдний амьдрал яаж шийдэгдэх вэ гэвэл, ирээдүйд харь гаригийнхан огт оршихгүй болно. Хэрэв харь гаригийнхны дунд үнэхээр сайн нэгэн байвал тэдгээр нь өөр амь бодь болон төрж, муу амь бодиуд нь устана. Тиймээс аль ч амь бодийн хувьд түүний хийж байгаа үйлээс нь хамаарч түүний ирээдүйд очих, байх газар шийдэгдэнэ, бүх хүний хувьд мөн адил. Хүн юу хийж байгаагаас түүний байр суурь тодорхойлогдоно.

Одоо ихэнх тохиолдолд, харь гаригийнхан амиа аврахын тулд энд ирцгээсэн. Эцэст нь тэдэнд зугтах газар байхгүй болно гэж мэдсэн, зарим нь тэгээд дэлхийн суурьшигчтай гэр бүл болсон. Мэдээж энэ нь хууль ёсны гэрлэлт биш, хэн ч тэдэнтэй гэрлэхгүй. Тэд хойч үеэ үлдээхийн тулд тосгоны ямар нэгэн эмэгтэйг булааж авч суусан. Зарим нь энгийн хүмүүсийн дунд нуугддаг. Гэхдээ тэд яаж нуугдсан ч нэмэргүй. Микро түвшнээс агуу гон ирж байна. Ган, төмөр, мод, хүний бие, ус, чулуу, агаар, ургамал, амьтан юу ч байсан бүх зүйлийн микро түвшнээс гон гадаргуу руу ирж байна. Тэгвэл тэд хаашаа зугтах юм хэл дээ? Гон хаа сайгүй оршдог, гадаргуй луу хурдалж байна. Тэд хаана ч нуугдаж, хоргодож чадахгүй болсноо харсан. Тэгвэл тэд яаж орших вэ? Тэд ерөнхийдээ биенд шүглэсэн сүнс хэлбэрээр оршдоггүй. Зарим нь хүний дүрд хувирсан, тэднийг гудамжаар явж байхад хүн ялгахгүй. Зарим нь нуугдсан газраасаа гарч ирдэггүй. Тэдний тоо одоо цөөн болсон, тун бага. Урьд тэд нуугдаж чаддаг байсан, тэд нисдэг тавгаараа хөөрч өөр орон зай руу орж чаддаг байсан. Гэтэл одоо бусад орон зайнууд бүгд цэвэрлэгдсэн. Агуу гон энд давшин ирж байна, тэд нуугдаж чадахгүй болсон. Тэд зөвхөн энэ орон зайн аль нэг агуйд эсвэл далайн ёроолд нуугдаж чадна. Тэгсэн ч тэнд нуугдах аргагүй болсон. Тэдэнд ийм асуудал тулгараад байна. Бүх амь бодиуд энэ тал дээр өөрийн байр сууриа тавьж байна.

Асуулт: Энгийн хүний шинжлэх ухаан буруу, тэгвэл бид энгийн хүний мэдлэг олж авахгүйгээр бясалгаж болох уу?

Багш: Нөгөө талаар бид бас шинжлэх ухаанд суралцангаа эрдэм мэдлэгээ дээшлүүлж

болно. Би Фа зааж тайлбарлахдаа хүмүүст ойлгуулахын тулд орчин үеийн хүний төсөөллийг хэрэглэдэг. Мэдлэг хүний танин мэдэхүйг нээж өгч чадна, энэ нь Фа олж авахад тустай. Хэрэв хүний боловсрол доогуур бол миний хэрэглэдэг орчин үеийн нэр томъёог ойлгоход хэцүү болно. Гэхдээ энэ мэдлэггүйгээр хүн ойлгож чадахгүй гэсэн үг биш. Хэрэв орчин үеийн шинжлэх ухааны соёл байгаагүй байсан бол би хүмүүст ойлгуулахын тулд Дафа-г өнөөдрийн хэлбэрээр биш эртний хэлээр заах байсан. Нийгэм ийм хэлбэртэй болсон болохоор энгийн хүний энэ нийгэмд нийцүүлж хийхэд асуудалгүй. Одоо үед зөвхөн ингэж хийнэ. Бясалгагч хүний хувьд чи том хүн байна уу, хүүхэд байна уу хаана ч гэсэн өөрийнхээ үйл хэргийг сайн хийх хэрэгтэй, чи сургуульд сурдаг бол хичээлээ сайн хийх хэрэгтэй, хэрэв чи ажил хийдэг бол ажлаа сайн гүйцэтгэх хэрэгтэй. Хэрэв ямар нэгэн онцгой хэлбэр бий болговол үүнийг даган та нарын бясалгалын хэлбэрт өөрчлөлт гарч болзошгүй, чиний амьдрал, бясалгалд хүндрэл учирна. Та нар үүнийг ойлгох хэрэгтэй, харь гаригийнхан хэдийгээр өөрсдийн зорилгыг биелүүлэхийн тулд хүн төрөлхтөнд өөрийн шинжлэх ухааныг авчирсан боловч Бурхад нөгөө талаар бүгдийг удирдаж байдаг, мөн үүнийг ашигладаг.

Асуулт: Бид бясалгалдаа ихэнх цагаа зарцуулж энгийн хүний нийгмийн ажилд бага цаг зарцуулах нь дээр үү?

Багш: Энэ нь тийм гэсэн үг биш. Чи өөрийнхээ ажлыг энгийн хүний ажлын цагтаа сайн хийх хэрэгтэй, чи ямарч завгүй байсан чамд дасгалаа хийх номоо унших цаг олдоно гэж бодож байна. Ийм л юм. Хичээнгүй шаргуу сурагч бол ажлын бус цагтаа бясалгалдаа илүү цаг зарцуулна гэж бодож байна.

Асуулт: Бид бясалгахын тулд ямар нэгэн хэцүү орчин санаатайгаар хайх хэрэгтэй юу?

Багш: Хэрэггүй. Чи үргэлж юмыг өөрийн хүслээр хийхийг бодож, бясалгалын замыг өөрөө өөрчлөх гэж зүтгэж болохгүй. Энэ тэрийг хийх гэсэн өөрийн хүслийн дагуу битгий яв, чиний замыг би зохицуулна. Хэрэв чи бясалгахыг хүсч байвал ийм л зам бий. Чи хийх ёстой зүйлээ л хий. Хятадад зарим хүн бясалгаж эхлэнгүүтээ өөрийн гадаад байдалдаа анхаарал тавихаа больдог. Хүн яаж аятайхан цэвэр хувцаслах ёстой, тийм бай. Харин тэд навсайсан хувцастай, өрвийсэн үстэй явдаг, үүнээсээ ч ичдэггүй. Тийм байж огт болохгүй. Одоо бол эрт үед Жан Санфэний (Тайчи үндэслэгч) Дао-д бясалгаж байсан үетэй адилгүй. Та нар энгийн хүний нийгэмд бясалгаж байна. Наад зах нь чи хүн шиг гайгүй харагдаж байх хэрэгтэй. Бясалгагчид энгийн хүнээс дээгүүр, тиймээс улам илүү байх хэрэгтэй, бүх талаараа илүү байх хэрэгтэй. Фалуны Гон бясалгаж эхлэнгүүтээ бүхнийг умартан бүх зүйлдээ анхаарахгүй болж болохгүй, хайш яйш хувцаслаж бохир явж болохгүй. Ийм байж хэрхэвч таарахгүй. Ийм байвал чи тодорхой хэмжээгээр Дафа-гийн нэр хүндийг гутаана. Тийм биш гэж үү? Тиймээс энэ конференцэд би бүх хүнд хэллээ, цэвэр хувцасласан байх хэрэгтэй гэж зохион байгуулагчдад бас хэлсэн. Гадны хүмүүст бид муугаар дүгнэгдвэл хэрхэвч болохгүй, тийм үү? Сүүлийн жилүүдэд Хятадын эдийн засаг муугүй байгаа. Тэгэхээр гайгүй костюм авч өмсөхөд асуудалгүй. Би чамайг үнэтэй хувцас авч өмс гэж хэлээгүй, гэхдээ чи наад зах нь гадаад үзэмжиндээ анхаарах хэрэгтэй, цэвэр хувцаслах хэрэгтэй. Бид энгийн хүмүүсийн дунд бясалгаж байгаа гэдгээ санаж явах хэрэгтэй. Энэ нь хэцүү асуудал биш. Бясалгахын хувьд бид өөрсөддөө бясалгалын орчин бүрдүүлэх гэж төлөвлөх хэрэггүй.

Асуулт: 4 настай нэг хүүхдийн тэнгэрийн мэлмий нээлттэй, тэр Фалунь болон Багшийн нэр гэрэлтэж байхыг харж чаддаг. Гэхдээ заримдаа их гэжүүд, том хүмүүс түүнд бууж өгөхгүй бол уйлна, чарлана. Энэ нь надад их дарамттай байдаг.

Багш: "Энэ нь надад их дарамттай байдаг"...Чи өөрөө ингэж бичлээ. Чамд их хэцүү, их дарамттай гэдэг нь чиний сэтгэлийг шаналуулдаг. Хүүхэд чамайг дээшилхэд тусалж байгаа хэрэг биш үү?

Асуулт: 2 настай нэг хүүхэд, Фалунь хараад "Фалунь" гэж баяртай хэлдэг. Тэр охин Багшийн зургийг хараад "Багш" гэж хэлдэг. Тэр шалан дээр сууж алгаа "хөши" барилд хавсран бариад "дасгал хий" гэж хэлдэг. Заримдаа Багшийн аудио бичлэгийг сонсохдоо "Багшийг сонс" гэж хэлдэг.

Багш: Тэгвэл энэ хүүхэд үнэхээр онцгой, тэр дөнгөж хоёрхон настай. Ийм хүүхдүүд Фа олохоор ирсэн байж болно. Манай 4, 5 настай 6 настай жижиг шавь нар, бяцхан үе залгамжлагчдын дунд сайн бясалгагчид олон бий. Тэд үнэхээр гайхамшигтай. Тэдний зарим нь нилээд хүчтэй ер бусын чадвартай. Тэд нар олон байдаг. Дээд Бурхдууд ирээдүйд ямар гэр бүл Фа олж авахыг тодорхой хардаг, "За тэр гэр бүл Фа олж авна" тэгээд тэд тийм гэр бүлд төрөхөөр зохицуулдаг, яагаад гэвэл тэд тэр айлд Фа олж авч болно.

Асуулт: Эмнэлэгт бусад газрыг бодвол карма их байдаг уу?

Багш: Эмнэлэг, хүний өвчнийг эмчилдэг газруудад өвчний чий арай их байдаг. Гэхдээ чи бясалгагч, айх хэрэг юу байна? Манай бясалгагч нарт нөлөөлөхгүй, муу юм болж чадахгүй.

Асуулт: Эмнэлэгт хүний биед задлан хийхэд Дафа сурагчид муу нөлөөтэй юу?

Багш: Хэрэв энэ нь чиний ажил бол хий. Тэдгээр хүмүүс үхсэн учраас асуудалгүй. Бид бясалгахдаа энгийн хүний нийгэмд аль болохуйц дээд хэмжээгээр зохицохыг шаарддаг. Чи одоо бясалгаж байгаа гээд энгийн хүний нийгмийн хэв маягийг өөрчилж болохгүй, тэгж болохгүй.

Асуулт: Хэрэв хүнийг ил үгээр биш дотроо, санаандаа загнаж зүхвэл "Дэ" буянаа алдах уу?

Багш: "Би сайн бясалгаж байна, миний зан байдал их дажгүй" гэж ярьдаг хүн байдаг. Гэвч түүний зууралдсан сэтгэл огт арилаагүй. Үүнийг бясалгал гэх үү? Энэ нь хуурамч биш гэж үү? Тиймээс зөвхөн үндсээрээ өөрчлөгдвөл жинхэнэ өөрчлөлт болно. Бүх гадна талын байдал бол зөвхөн дүр эсгэлт. Чиний сэтгэл өөрчлөгдсөн үү, үгүй юу гэдэг л жинхэнэ бодит байдал. Хэрэв чи дотроо занаж зүхвэл мэдээж чиний сэтгэл өөрчлөгдөөгүй гэсэн үг. Буянаа алдсан уу, үгүй юу гэдэг бол бага хэрэг. Дафа-г энгийн хүний буяныг хадгалахын тулд заадаггүй.

Асуулт: Зарим сурагчид хортой амьтдаас болон иймэрхүү зүйлээс айдаг. Ийм зууралдсан сэтгэлийг арилгахгүйгээр төгс бясалгалд хүрч чадах уу?

Багш: Энэ бол хоёр өөр зүйл. Айдсаа зүгээр л арилга, тэгээд бүгд сайн болно. Та нарын ихэнх нь айхгүй биз, харин тэдгээрт дургүй, муухай гэж үздэг. Энэ нь хүн ялгас харгаад муухай гэдэг шиг биш, тэдгээрийг хүн бодохоороо хорон муу гэж мэдэрдэг. Эдгээр амьтад ирээдүйн дэлхийд, орчлон ертөнцөд оршихгүй. Би хэлбэл, орчлон ертөнцийн эхний үед ийм хорт, муу амьтад байгаагүй. Яагаад тэдгээр нь бий болсон бэ? Яагаад гэвэл амь бодийн карма улам их болсон, амь бодиуд улам муу болсон, орчлон ертөнц улам ариун бус болсон. Тиймээс олон муу зүйлс үүссэн, тэдгээр нь аажмаар улам хортой болсон. Тэгж хувьсаж гарсан.

Асуулт: "Ухамсар" гэдэг товхимолд" байдаг "хоёр хоёроороо, хойно хойноосоо цувран ирэх" гэдэг хэллэгийг юу гэж ойлгож болох вэ?

Багш: Энэ бол эртний Хятадын хэллэг. Эртний Хятад хэллэгэнд юмыг тодорхой хэлдэг, мөн гүн утга агуулгатай. Энэ бол хамгийн шилдэг бичгийн хэл. Эрт урьд үүнийг тэнгэрийн үгс, тэнгэрийн захидал гэдэг байсан. Одоогийн хүмүүсийн ёс суртахуун туйлын ихээр доройтсон, тиймээс орчин үеийн Хятад хэл хэрэглэж байна. Хоёр хоёроороо, хойно хойноосоо цувран ирэх гэдгийг тайлбарлавал: Хүмүүс хоёр гурваараа ирцгээх гэсэн утгатай. Нэг хэсэг нь бусдад хэлдэг: "Энэ ном их сайн, хоёул хамт явж бясалгая". Нөгөө хүнд үнэхээр сайн гэж санагдсан, тэгээд бас ирсэн. Дараа нь тэр хүн гэрийнхэндээ ярина, бясалгалд дагуулна. Тэгээд тэр хүмүүс хоёулаа, гурвуулаа ирнэ. Хэрэв орчин үеийн хятад хэл ашиглавал өчнөөн үг хэрэглэх болно. Харин Хоёр хоёроороо, хойно хойноосоо цувран ирэх гэхэд дөрвөн л ханз орж байна. Ийм л утгатай. "цувран" гэдэг үг нь тэд өөр өөр хугацаанд нэг нэгнийхээ араас ирэхийг хэлсэн утгатай. Энэ цувран гэдэг үгийг тайлбарлахад бас олон үг хэрэгтэй.

Асуулт: Ном сонин, сэтгүүл зардаг Дафа-гийн сурагч Дафа-гийн номыг бөөний үнээр аваад ширхэгийн үнээр зарж болох уу?

Багш: Саяхан би нэг асуудлын талаар бодсон. Одоо Хятадад олон хүн ажлын байраа алдсан, ажилгүй болсон. Тэдний зарим цөөн тооны хүмүүс нь манай сурагчид, тэгээд би ингэж бодсон. Хэрэв тэд нарт Фалунь Дафа-гийн ном зарахыг зөвшөөрвөл яах вэ? Тэгвэл тэдний амьжиргааны асуудлыг шийдвэрлээд зогсохгүй бас сурагчдад Фалунь Дафа-гийн ном худалдан авахад амар болно. Зарим сурагчид ингэж хийсэн. Сүүлд би энэ талаар гүн бодож үзэхэд ямар нэгэн зүйл болохгүй санагдсан. Юу нь болохгүй байв? Боддоо Дафа биднийг аварч чадна. Тийм ариун Дафа, харин бид үүнийг мөнгө олоход ашиглаж байна. Тэгвэл бид өөрсдийгээ ямар байр сууринд тавьж байна, Дафа-г ямар байр сууринд тавьж байна вэ? Тэгж хийж хэрхэвч болохгүй. Тиймээс би тэдэнд зөвшөөрөөгүй. Харин энгийн хүнд бол яагаад болдог вэ? Яагаад гэвэл би Дафа дэлгэрүүлэхийн тулд энгийн хүний нийгмийг ашиглаж байна. Энгийн хүний нийгэм бол хамгийн доод түвшин дэх Фа-гийн илрэл, тиймээс нийгэмд янз бүрийн мэргэжил байдаг. Энд алдаа байхгүй. Манай номны цаана гүн агуулга байхгүй байсан бол цагаан цаасан дээр хар бэхээр бичсэн зүгээр л нэг энгийн ном байх байсан. Үүний цаана гүн агуулга байдаг болохоор Фа-гийн нөлөө үйлчилдэг. Хэрэв үүнийг энгийн хүний нийгэмд номын дэлгүүр, номын худалдаачид хийвэл асуудалгүй, энгийн хүний нийгмийн хуульд нийцэж байна. Харин манай сурагчдын хувьд үнэхээр тийм асуудал гарна. Бид Фа-г мөнгө олохын төлөө ашиглавал энэ номыг худалдан авах ихэнх хүмүүс нь манай сурагчид, тэгвэл бид энэ мөнгийг яаж

зарцуулах юм?

Хэрэв та нар өөрсдийн номын дэлгүүртэй, тэгээд энэ боломжийг ашиглан Дафа-гийн номнуудыг зарах гэвэл, та нарын номын дэлгүүр зөвхөн Дафа-гийн номыг зарахын тулд байгуулагдаагүй, урьд нь байгуулагдсан бол би үүнд тагталзахгүй. Гэхдээ та нарын Фа ойлголт тасралтгүй гүнзгийрэхэд чи өөрөөр хандана гэдэгт би итгэж байна.

Асуулт: Багштай ирж уулзахын төлөө гэр бүлтэйгээ муудалцсан, бүхнийг үл хайхарсан. Энэ нь зөв үү, буруу юу?

Багш: Хэрэв чи эх газрын Хятадаас ирсэн бол энд ирэхийг зөвшөөрөөгүй байж болно, эсвэл миний Номын бие чиний сэтгэлийг бясалгал дээр чинь төвлөрүүлэхийн тулд чамайг энд ирэхийг хүсээгүй. Эх газрын Хятадаас өөр газраас ирсэн бол чамд өөр шалтгаан байсан байж таарна. Чиний хэр тууштайг сорьсон байж болно, ямар ч шалтгаан байж болно, чи өөрөө шалтгааныг ухамсарла.

Асуулт: Би цагаа сайн ашиглаж бясалгахыг хэрэгтэй гэдгийг мэднэ, гэхдээ би бас хүүхэдтэй болохыг хүсч байна. Энэ нь зууралдсан сэтгэлд тооцогдох уу?

Багш: Би хэлсэн, бид энгийн хүний нийгэмд боломжийн дээд хэмжээгээр зохицон амьдарч бясалгах хэрэгтэй гэсэн. Одоо хэдэн арван сая залуу сурагчид бясалгаж байна. Хэн нь ч гэр бүл болохгүй, үр хүүхэдтэй болохгүй байвал энгийн хүний нийгмийн байдлыг эвдэж байгаа хэрэг биш үү? Энгийн хүний нийгэмд бясалгах наад захын байдалд нийцэхгүй байна гэж би хэлнэ. Тэгвэл зарим хүн хэлнэ, "Энэ амьдралдаа гэрлэхийг хүсэхгүй, би шийдсэн" гэвэл би бас үүний эсрэг биш. Чи ингэж бясалгаж болно. Чиний амьдралд болон бусад тал дээр чамд нэмэлт хүндрэл, асуудал учруулахгүй бол би юу ч гэж хэлэхгүй. Хүний орчлон дахь хэрэгт чи шийдвэрээ өөрөө гаргаж хийнэ. Хэрвээ чи хүүхэдтэй болох нь бясалгалд нөлөөлнө гэж хэлбэл би үүнийг шалтгаан гэж үзэхгүй. Тийм байхгүй.

Асуулт: Гэгээрлийн хутагт хүрэх ямар хэлбэрүүд байдаг вэ? Бүгд өөрийн биеэ аваад явах уу?

Багш: Энэ талаар би аль хэдийн ярьсан. Зөвхөн Фалунь диваажинд очих хүн биеэ авч явна. Би өөр газар очих хүний хувьд хэлбэл, та нарын их олонхи нь Дафа олж авахаар янз бүрийн түвшингээс, давхаргаас ирсэн. Хэрвээ чи энэ биетэйгээ буцаж очвол дээр байгаа Будда, Бурхдад ямар нэгэн хачин зүйл авчирсан харагдана. Тэнд ийм зүйл огт байдаггүй, тиймээс хэрэггүй. Хэрэв чи энэ зүйлийг авч очвол тэдний бясалгалын цогц зүйлсийг эвдэнэ. Санаж яв, чи хаанаас ч ирсэн байлаа гэсэн би чиний анхны зүйлийг шинэ, хамгийн ариун Фа-тай зөвхөн ижилсүүлсэн. Чиний бясалгалын гадаргуйн зүйлсийн хувьд би хүрээгүй, тиймээс чи эхний ирсэн газраа буцна гэдгийг баталж байна. Өөрөөр хэлбэл хэрэв чи Будда байсан бол Будда болно, Дао байсан бол Дао болно, хэрэв чи Бурхан байсан бол Бурхан болно. Чиний төрх байдал урьд байсан бүх зүйлс чинь өөрчлөгдөхгүй. Урьд гэгээрлийн хутагт хүрч чадаагүй хэн нэгэн энэ удаагийн бясалгалаар хүрэх боломжтой, тэгээд чиний очвол зохих газар луу явуулахаар зохицуулагдана.

Асуулт: Дасгал хийж байхад надад ямар нэгэн хөгжим дандаа сонсогдох юм, манай Дафа хөгжим биш. Өөр орон зайнаас үймүүлж байна уу гэж санаа зовох юм.

Багш: Өөр орон зайн хөгжим манай бясалгалын хөгжмөөс ялгаатай. Гэхдээ өөр орон зайд үнэхээр гайхамшигтай хөгжим байдаг. Чи сонссон бол сонсоо л биз битгий тоо, энэ хөгжим өөр орон зайнаас. Санаа зоволтгүй, хөгжим өөрөө бясалгалыг төлөөлдөггүй. Чи Дафа-д бясалгаж байхад дасгалаа хөгжмийн аясаар хийдэг. Энэ нь чиний амгаланд орж чадахгүй байх үед бодолд чинь орж ирдэг арван мянган бодлыг нэг бодлоор солих зорилготой юм. Өөрөөр хэлбэл чи дасгалын хөгжим сонсч байхдаа чиний бодол хаа сайгүй үймрэхгүй, зөвхөн хөгжим сонсоно. Энэ нь чамд дасгал хийхэд тустай. Гэхдээ дасгал хийхдээ зөвхөн манай хөгжмийг сонсох хэрэгтэй.

Асуулт: Би өөртөө давж чадашгүй үймүүлийг хагас жил мэдэрч байна. Энэ нь үгэнд, төсөөлөлд илэрдэг.

Багш: Хэрэв чи жинхэнэ бясалгагч бол анх ямарч зорилготойгоор Дафа-д орж бясалгасан байсан тэр бүгдийг орхих хэрэгтэй, юуны ч талаар бүү санаа зов. Чи ямар нэгэн хэрэг бүтээхийн тулд бясалгалд орж ирээгүй гэж ойлгох хэрэгтэй. Би Дафа-г хүн аврахын тулд, бясалгалаар буцаахын тулд зааж байна, энгийн хүний биений байдлыг янзалж өгөхийн тулд биш. Энэ бол ноцтой асуудал, хүн өөрийгөө бясалгалд зориулахаар шийдсэн байх хэрэгтэй. Тийм нөхцөлд түүний ямарч асуудлыг шийдэж өгч болно. Харин зөвхөн энгийн хүний ямар нэгэн асуудлыг шийдэхийн тулд ирсэн бол бид чамд хийж өгч чадахгүй. Нэг үгээр хэлбэл, Дафа бол бясалгахын тулд. Жишээ нь: Хэн нэгэн, Фалунь Дафа бол өвчин эдгээхийн тулд биш гэдгийг мэддэгч гэсэн ингэж бодно: "Тэгвэл би өвчин эдгээхийн төлөө хийхгүй. Энэ бол өвчин эдгээхийн тулд биш, би өвчин эмчлэх талаар ярихгүй, би өвчнөө эдгээх талаар асуухгүй". Гэхдээ цаанаа бодно: Хэрэв би хичээллэвэл Багш миний өвчнийг зайлшгүй арилгаж өгнө. Харж байгаа биз, тэр дотроо хичээллэх юм бол Багш миний өвчнийг эдгээж өгөх нь дамжиггүй гэж бодож байна. Түүний сэтгэлийн гүнд тэр бодол нь нуугдсан хэвээр. Тэр намайг түүний өвчнийг арилгаж өгөхийг хүссэн хэвээр байна гэдэг нь өөрийнхээ өвчинд зууралдсан сэтгэл нь салаагүй байна гэсэн үг. Хэрэв энэ сэтгэлээсээ бүр мөсөн салсан бол энэ талаар огт санаа зовохгүй, бодохгүй. Тэгвэл юу болох нь харагдана. Үгээр илэрхийлбэл: "Юуг ч хүсэхгүйгээр бүгдийг жамаараа олно". Энэ бол аль ч бясалгалын аргад ажиглагддаг байдал. Энгийн хүний нийгэмд аль ч зүйлийг хүн өөрийн оролдлого хүчилснээр, хүссэнээр олж болно гэдэг. Гэвч өөр орон зайн зарчимд бол бүгд эсрэгээр, хэрэв чи ямар нэгэн зүйл олох гэж улайран хүсвэл, ийм зууралдсан сэтгэлээс хийвэл юу ч олж авч чадахгүй, энэ бодлоосоо улам татгалзах тусам, энэ зүйлд бага анхаарах тусам түүнийг олж авах магадлал өндөр. Үүнийг "Юуг ч хүсэхгүйгээр бүгдийг жамаараа олох" гэдэг.

Асуулт: Багш Сингапурын Фа конференц дээр их гарын мутар айлдахад зарим хүнд гайхалтай сайхан мэдрэмж төрсөн, зарим хүний сэтгэл шимширч харамсал мэдэрч нулимс унагасан. Энэ нь бясалгалын түвшинтэй холбоотой юу?

Багш: Их ойрхон хэллээ, үндсэндээ бараг тийм. Хүн бүрийн мэдрэмж, ойлголт өөр.

Асуулт: Бясалгалаар төгс гэгээрэлд хүрэхийн тулд хүн болгон хувиа хичээх, биеэ тоох

зангүй болсон түвшинд хүрэх ёстой. Тэгвэл төгс гэгээрэлд яагаад олон түвшин байдаг вэ?

Багш: Үүнийг ингэж авч үзье. Хүн өөрийгээ ангижруулж чадсанаар Архат түвшний анхны бүтээлийн оронд хүрэхэд бас төгс бясалгалд хүрсэнд тооцогдоно. Үүнд хүрэхэд бүх амь бодийг аврах гэж бодохгүй, бусдын талаар санаа зовох зүйлгүй, өөрийнхээ зорилго дагуу шаргуу бясалгахад тэр түвшинд хүрэхэд хангалттай. Энэ бол Архат түвшин, анхны бүтээлийн орон. Хэрэв чи Бодьсадва бүтээлийн түвшний бүтээлийн оронд хүрье гэвэл, ядаж Бодьсадва-гийн хамгийн доод шатанд хүрэхийг хүсвэл бясалгалын явцдаа агуу нинжин сэтгэл гаргах хэрэгтэй, агуу нинжин сэтгэл үзүүлэх хэрэгтэй. Өөрийгээ ангижруулахын сацуу чи бас бусдад ангижрахад туслах хэрэгтэй. Үүнд хүрч чадах, чадахгүй ч гэсэн чамд ийм хүсэл төрнө. Чиний нүдэнд бүх амь бодь үнэхээр зовлонтой байгаа нь харагдана, тэгээд нулимс унагана. Энэ бүгд бол зүгээр тайлбар биш, харин бодит үнэн. Чамайг гэхдээ албадахгүй, мэдээж бясалгалын үед дандаа ийм байхгүй, гэхдээ гардаг. Харин чи Буддын түвшинд гэгээрвэл чиний нинжин сэтгэл өөрчлөгдөнө, чи бүх амь бодийг хараад Бодьсадва шиг нулимс унагахгүй, гэхдээ чамд нигүүлсэнгүй сэтгэл гарна. Чи амь бодийн урьдчилан тогтсон буян нүглийн зүй тогтлыг тодорхой ойлгох болно, бүгдийг илүү билиг оюунаар харах болно. Харин Татагата Буддын түвшнээс олон дахин өндөрт хүрсэн Будда бол эргэж хараад бодно: "Энэ юуны нигүүлсэн сэтгэл вэ?" Тэр, Буддын энгийн хүнд гаргасан сэтгэлийг бас зууралдсан сэтгэл гэж үзнэ. Тэр зөвхөн өөрийнхээ түвшнээс доогуурхи Бурхдад, Будда-д, Буддын орны бүх амь бодид нигүүлсэнгүй сэтгэл гаргана. Гэхдээ хүмүүст нигүүлсэнгүй сэтгэл гаргахгүй. Энэ нь түүнийг нинжин биш гэсэн үг биш, зүгээр л түүний түвшин хэт өндөр. Түүний хувьд энэ доор байгаа амь бодь бол юу ч биш, микро организмаас ч дор. Тэр, энэ чадваргүй хүмүүсийг огт хэрэгцээгүй амь бодиуд гэж үздэг. Үүнээс бүр дээд түвшний Будда хараад хэлнэ: "Аан, эдгээр Татагата Будда нар бас энгийн хүнтэй адил, энэ хүмүүс тэр доор юу хийж байгаа юм бэ?" Тэр, хүнийг харвал түүний нүдэнд хүн харагдах уу? Хүн бол юу ч биш, тэд яг маш микро организмын адил шороо ухаад л. Хэрэв үүнээс бүр дээд түвшний Будда, түүнээс ч дээдийн дээд түвшний Будда юу гэж бодох вэ? Чи тэр байдалд хүрэхийг хүсвэл тэр түвшинд хүртэл бясалгах хэрэгтэй. Би хамгийн энгийн байдлын талаар ярилаа. Гэхдээ энэ нь зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй.

Хүмүүст жинхэнэ Фа мэдэхийг зөвшөөрөхгүй, яагаад гэвэл та нарт бас л хүний сэтгэлгээ байгаа, янз бүрийн амь бодид янз бүрийн орших хэлбэр байдаг. Үүнээс гадна энэ талын бодит бие үргэлж өөрчлөгдөж байдаг. Хэрэв Буддын бие атомаас тогтсон бол тэдгээрээс бүр дээд Буддын, Бурхдуудын бие нейтронтой тэнцэх жижиг хэсгээс, түүнээс дээд түвшнийх нь нейтрино эсвэл кваркаас тогтсон байж болно. Хүн зөвхөн эдгээр микро ширхэгт элементийг мэднэ. Хэрэв үүнээс микро, бүр түүнээс ч микро материас тогтсон бол яахав? Тэдний энерги илүү хүчтэй нь мэдээж, материйн ширхэг жижиг болох тусам түүний нягтрал их. Тиймээс улам нимгэн гялалзсан харагдана. Бид хүний арьсан дээрхи хөлсний нүхийг харж чадна, харин Бурхны бие дээр хөлсний нүх байхгүй. Хүний давхаргаас нэг давхарга дээгүүрх Гурамсан ертөнц доторхи амь бодийн, Гурамсан ертөнцийн өөр өөр давхаргын тэнгэрийн оршигчдын биеийг харахад хүний нүдэнд их гөлгөр, булбарай сайхан харагддаг. Энэ нь тэдний биеийн ширхэгүүд нь дэлхийн хүнийхээс илүү жижиг, нягт учраас юм. Өөрөөр хэлбэл амь бодийн түвшин дээшлэх тусам гадаргуйн хэлбэр нь сайжирна, үүний урьдчилсан нөхцөл нь түвшин ахих юм. Янз бүрийн түвшинд төгс гэгээрэлд хүрч болно. Бясалгалаар ямарч түвшинд хүрсэн, түүнээс доод

түвшний бүх зүйлс чамд оньсого мэт байхаа болино, бүгд чиний нүдний өмнө ил харагдана, бүх үнэнийг харж чадна. Гэхдээ чиний түвшнээс дээгүүрхи зүйлс чамд үргэлж оньсого болж үлдэнэ, чи түүнийг хэзээ ч мэдэж чадахгүй. Чи хаана хүрнэ, тэр бол чиний бүтээлийн орон, чи тэр хэмжээний гэгээрэлд хүрсэн. Чи хэр их зориулна, бясалгалдаа хэр дээшилнэ тэр хэмжээгээр олж авна.

Асуулт: Би бясалгал бол нарийн асуудал гэдгийг ойлгоно, гэхдээ нөгөө талаар зовлонтой байсан ч сэтгэлдээ баяр баясгалантай бясалгахад буруу юм байна уу?

Багш: Буруу юм байхгүй. Хэрэв бясалгах явцад үргэлж сэтгэл өөдрөг, баяртай байж чадвал, ямарч бэрхшээл тохиолдсон ч ийм байдалтай байж чадвал би чамайг ёстой мундаг гэж хэлнэ. Хүн бүр чамайг бахдана, яагаад гэвэл ийм байх их хэцүү. Ямарч бэрхшээл зовлонгийн өмнө сэтгэлээ төвшин барьж, сэтгэл өөдрөг байх их хэцүү. Гэхдээ бид бэрхшээл зовлон байхгүй байсан ч, сорилт байхгүй үед ч үргэлж баяр баясгалантай, нинжин сэтгэлтэй байж чадвал энэ нь бясалгагч хүний жирийн үед барьж байх ёстой хамгийн сайн шинж.

Асуулт: Бясалгагч хүн гэр бүл болоод бэлгийн харьцаатай байж болох уу?

Багш: Бид энгийн хүний орчинд бясалгаж байгаа, мэрэгжлийн лам хувраг биш, тиймээс энгийн хүний байдалд зохицон амьдрах хэрэгтэй гэж ярьдаг. Бид энгийн хүний орчинд материаллаг сонирхлыг чухалд үздэггүй. Яагаад? Яагаад гэвэл бясалгадаг хүн сэтгэлээ өөрчилж байна. Хэрэв сэтгэл өөрчлөгдөхгүй бол бүгд хуурамч байна. Чи гаднаа надад юу ч байхгүй гэнэ, гэхдээ дотоод сэтгэлдээ салж чадахгүй тэр зууралдсан сэтгэл байсаар байна гэсэн үг, тэгвэл ийм байж таарахгүй. Миний сэтгэлд тийм зууралдсан сэтгэл үнэхээр байхгүй, би энэ бүгдийг хүний байдал, амьдралыг тэтгэх зүйл гэж үздэг гэвэл би чамайг муугүй байна гэж хэлнэ. Чи бясалгалдаа дээд гүн түвшинд хүрвэл мэдээж энэ бүх зүйлийг орхих хэрэгтэй. Чиний одоогийн байдлыг алдаа гэж үзэж болохгүй. Би энэ талаар "Жуан Фалунь" номонд тодорхой хэлсэн.

Чи бясалгах явцдаа яагаад тийм байж болох вэ? Яагаад гэвэл миний өнөөдөр зааж байгаа номын үүд, манай Дафа энгийн хүний хэцүү орчинд дэлгэрүүлэхээр зохицуулсан, дээд түвшний хүмүүсийг зөвхөн ингэж л буцахыг зөвшөөрнө. Энгийн хүний нийгмийн байдал хангалттай хэцүү биш бол дээд түвшнээс ирсэн та нарт ийм их гай зовлон, саад бэрхшээл байхгүй, хэзээ ч буцаж чадахгүй байх байсан. Дафа бол агуу, энгийн хүний нийгэмд дэлгэрсэн болохоор манай Дафа та бүхэнд энгийн хүний нийгэмд амьдрах тааламжтай нөхцөл олгосон. Микро давхаргаас, чиний амийг бүрдүүлсэн анхдагч хэсгүүдээс эхлэн чиний биеийг өөрчлөнө, модны жилийн цагираг гадагш тэлэхтэй адил. Чи зөвхөн бясалгана гэвэл, тэр шалгуурт хүрнэ гэвэл дорхноо энэ цагираг шиг тэлсээр гадаргуйд хүрэхэд, нэг үгээр хэлбэл модны холтост хүрэхэд бүгд өөрчлөгдөнө, тэр үед чи төгс бясалгалд хүрнэ. Энэ өөрчлөлт модны холтост хүрээгүй байхад, хамгийн гадаргуйн бодит биеийн, хамгийн гадаргуйн давхаргад хүрээгүй байхад чиний гадаргуйн материаллаг биед энгийн хүний бодол байсаар байх болно. Тэгэхэд чамд энгийн хүний янз бүрийн хүсэл гарах нь мэдээж, бэлгийн харьцааны хувьд янз бүрийн зууралдсан сэтгэл, энгийн хүний сэтгэл байна. Тэдгээр нь чамд байна, гэхдээ энгийн хүнд байдаг шиг тийм хүчтэй биш. Үүнийг чамайг энгийн хүний орчинд бясалгах явцад зохицуулахын тулд

зориуд үлдээсэн. Гэхдээ бясалгаж дууссан тал энгийн хүний гадаргуйн биений хэрэгт оролцохгүй, тэр тал бясалгаж дуусах шаардлага хангамагц тусгаарлагдана.

Ингэж тусгаарлахын ач холбогдол юу вэ? Энэ хүний гадаргуйн тал энгийн хүмүүсийн дунд ямарч зүйл хийсэн бясалгаж дууссан тал тэнд суугаад огт хөдлөхгүй, ямарч бодол, сэтгэхүйн үйл ажиллагаа байхгүй. Тэр бие хөдлөхгүй, юунд ч оролцохгүй. Хүний зүйл хийж байхад бурханлаг тал нь түүнийг хийхгүйг батлана. Тэр хүний бясалгаж дуусаагүй тал нь хийж байгаа. Энэ байдал чамайг өөрийгээ зөвхөн дээшлүүлэх байдалд, доош унахгүй байдалд байх боломжоор хангана. Хэрэв бид эхнээсээ гадаргуйн давхаргаас гүн рүү хувирах явцыг сонгосон бол, ингэж энгийн хүний нийгэмд хийвэл чи тэр орчинд бясалгаж чадахгүй нь лавтай. Чиний энгийн хүний дунд хийсэн болгон Бурхан хийсэнтэй адил болно, хувирсан бие чинь бурхны биетэй адил болно. Бурхан энгийн хүний ажил хийсэн болно, тэгвэл чамд бясалгах ямарч арга байхгүй. Бурхан энгийн хүмүүсийн зүйлийг хийж болох уу? Бурханд энгийн хүний сэтгэл оршихыг огт зөвшөөрөхгүй. Тиймээс бид эсрэг зүгт чиний амины эх үүсвэрийг өөрчилж, энэ нь үргэлжлэн тэлсээр гадаргуйн давхарга луу ирнэ, дэлгэрнэ. Чамайг төгс бясалгалд хүрэхийн өмнө чиний гадаргуйд энгийн хүний амьдралын шинж бас л байсаар байж болно, зөвхөн үүнд улам хөндий болсоор эцэст нь сэтгэлдээ ойр хүлээж авахаа болино, бүхнийг орхиж чадна, тэр үед чи төгс бясалгалд хүрэхэд их ойртсон байх болно. Тэлэлт чиний гадаргуйд бүрэн хүрэхэд чи төгс гэгээрэлд хүрэх тэр агшинд бүх зүйл хэвийн байна, газарт чичиргээ гарахгүй. Урьд бясалгалаар төгс гэгээрэлд хүрэхэд газар хөдлөлт болдог байсан. Хүн төгс гэгээрэлд хүрэхэд уул нурах, далайн шуурга үүсэх, их хэмжээнд газар хөдлөлт болох дагалддаг байсан. Гэхдээ манай бясалгалаар төгс гэгээрэлд хүрэхэд газар хөдлөлт болохгүй, яагаад гэвэл энгийн хүний нийгэмд саад болохгүйгээр олон хүн бясалгахад тохиромжтой. Хэрэв энэ олон хүн төгс гэгээрэлд хүрэхэд би хэлбэл дэлхий даахгүй. Бид бясалгалыг энгийн хүний нийгэмд нийцэхээр бүх талаар төлөвлөж, зохицуулсан гэсэн үг.

Чиний гадаргуй тал бясалгаж дуусах байдалд хүрээгүй байхад чи өөртөө энгийн хүний сэтгэл байхгүй болсон гэвэл би итгэхгүй, чи өөрийгээ хүчилж албадлагаар барьж байна. Чи өөртөө хатуу шаардлагатай биеэ авч явж болно, бясалгагч хүн ийм байх хэрэгтэй. Үүний зэрэгцээ бид энгийн хүний нийгмийн хэлбэрт боломжийн дээд хэмжээгээр зохицож байх хэрэгтэй. Миний сая хэлсэн бол зөвхөн бэлгийн харьцаан дээр биш, үүгээр хязгаарлагдахгүй. Гэр бүлийн амьдралд энэ нь тийм амар зүйл биш, тийм байх ёстой гэсэн үг биш. Тийм биш. Энэ асуудал дээр та нар өөртөө хамгийн тохиромжтой байдлыг сонгон авч чадна. Чамд ямар байдал нь дээр байна түүгээрээ бол. Хэрэв чамд энгийн хүний бодол, тийм хүсэл их хүчтэй байвал, чи эхнэртэй болохыг хүссэн хэвээр бол, өөртөө сүйт бүсгүй эсвэл сүйт хархүү олохыг их хүсч байвал, ямар нэгэн хүүхэн эсвэл залуу чиний сэтгэлийг булааж байвал, чамд энэ хүсэл байсаар байвал, тийм байвал чи бясалгалдаа тухайн түвшинд хүрээгүй байна гэсэн үг. Тэгвэл чи тэгж хандаж болно. Өнөөдөр гэнэт бүхнээс татгалзаж чадна, тийм байж чадна гэж битгий хэл, тэгвэл чи өнөөдөр дорхноо Будда болчихно гэсэн үг. Хэрэв тэгдэг бол чи өнөөдөр бясалгах хэрэггүй болчихно-чи аль хэдийн Будда. Бясалгалд бага багаар ахидаг, энэ нь аажим явцтай. Би тэгж хэлсэн ч чи "Оо, Багш төгс бясалгалд хүрэхээс өмнө энгийн хүний 7 мэдрэмж, 6 хүсэх сэтгэл миний гадаргуйн давхаргад байна гэж хэлсэн. Тэгэхээр би тийм зүйл хийж болно". Тэгж болохгүй! Энэ бүгд чамд байгаа ч гэсэн би хэлсэн, чи энгийн хүний нийгмийн байдалд дээд хэмжээгээр зохицох хэрэгтэй, хэрэв чи өөрийгээ бясалгагч хүний

байр суурьнаас хатуу шаардахгүй бол бясалгахгүй байгаатай адил. Ийм диалектикийн холбоотой.

Асуулт: Европын сурагчид чөлөөт цагаа Фа сонсоход зориулахыг эрмэлздэг, гэхдээ орчуулгын дуут бичлэг хараахан гараагүй. Өөрийн дуугаар бичлэг хийж Жуан Фалунийг сонсож болох уу?

Багш: Үүнээс үр дүн сайн гарахгүй. Яагаад вэ? Яагаад гэвэл Фа заасан миний дуу хоолойнд хүч оршино. Чи бясалгаж байгаа, чи төгс гэгээрэлд хүртэл чиний үгэнд энгийн хүний янз бүрийн мэдээлэл шингэсэн, чи түүнийг гаргаж буцаагаад өөрөө сонсоход олон дахин холилдож бохирдсон зүйл шингээж авна. Ном уншвал өөр хэрэг. Одоо бид синхрон орчуулга хийж байгаа, хурдан явцтай байгаа, удахгүй бэлэн болно, энэ асуудал удахгүй шийдэгдэнэ. Тэгсэн ч гэсэн би энэ зарчмыг хэлж өгье. Чиний уншсан үгэнд энгийн хүний янз бүрийн бодол санаа шингэсэн байдаг. Фа өөрийнхээ үүргийг гүйцэтгэх ёстой, хэрэв чи зөвхөн гадаргуйн зарчмыг сонсвол юу ч ойлгохгүй. Чиний амаараа уншсан бол чиний түвшин дэх ойлголт, чи дахин дахин сонссон ч чиний ойлголт тэр түвшнээс ахихгүй. Синхрон орчуулга бол өөр хэрэг, үүнд миний дуу сонсогдож байгаа, миний дуу бүдэг, орчуулгын дуу чанга ч гэсэн үнэн хэрэгтээ би ярьж байгаа, тэр орчуулж байгаа. Сурагчид намайг ойлгоно, бас миний заасан Фа-гаар дамжуулж байгаа бүгдийг хүлээж авна. Ийм л учиртай.

Асуулт: Би гурван удаа 3-5 насны охин харсан. Намайг хагас унтаа байхад тэр миний дэрэн дээр үсэрч инээнэ. Тэр Фалуны-аас гарч ирдэг бясалгасан нярай хүүхэд үү? (инхай).

Багш: Энэ бүгд ерөнхийдээ сайн хэрэг, гэхдээ дандаа тийм гэсэн үг биш. Энэ хүүхдүүд их бяцхан. Бидний урьд үеийн түүх их нарийн, тиймээс үүнд анхаараад хэрэггүй. Чи урьд үеэс магадгүй авчирсан байж болно, эсвэл өөр учиртай байж болно. Охин л бол охин, сайн хэрэг байж болно. Битгий анхаар, бясалгалдаа л анхаарлаа төвлөрүүл.

Би чамд ойлгомжгүй тайлбарласан бололтой, зарим нь сонсоод бас ойлгосонгүй. Би жишээ хэлье, энэ тохиолдолтой холбоотой байх албагүй. Та нарын зарим нь дээрээс бууж ирээд дахин төрсөн, тэдний урьд насны хүүхдүүд дагаж байдаг, гэхдээ тэд төрөөгүй, зөвхөн нөгөө талд дагаж байдаг. Бас зарим хүмүүс байдаг, тэдний урьд амьдралд хүүхдүүд байсан. Тэр энэ амьдралд дахин төрсөн, харин түүний урьд насны хүүхэд энэ насанд нь төрөөгүй. Гэхдээ хүүхдэд их зөн совинтой, тэгээд хүүхэд түүнийг дагаж явдаг. Ийм тохиолдол бас байж болно. Янз бүрийн нөхцөл байдал байдаг. Чи ариун Фа олж авсан болохоор хэрэв тэр хүүхэд чамтай учир ерөөлийн холбоотой бол бид энэ бүгдийг чиний төлөө зохицуулж өгнө. Энэ бүгдийг чамд тааламжтай байдлаар зохицуулна, чи үүнд санаа зовох хэрэггүй.

Асуулт: Би бодоод, бодоод асуулт олж чадсангүй, энэ нь миний бясалгал тийм сайн биш...

Багш: Манай зарим хуучин сурагчид байдаг, тэд сайн бясалгаж байгаа, гэхдээ надтай уулзахаар нэг ч үг хэлж чаддаггүй. Би тэдэнд хүчлээд ч нэг ч үг хэлж чадахгүй байгаа нь эвгүй байдгийг мэдэж байна. Надтай уулзахаас өмнө тэдэнд олон асуулт байдаг, тэд надаас асуухыг хүсдэг боловч намайг харахаараа асууж чаддаггүй. Яагаад ийм байдаг вэ

гэдгийг тайлбарлая. Та нар зөвхөн бясалгаж байгаа, чамд надтай уулзахад ийм байдал гардаг. Та нарт үг олохгүй. Надтай уулзахаар чамд хэлэх үг байдаггүйн учир нь бол чи тогтмол бясалгахад чиний ойлгосон, бясалгасан тал чамаас тусгаарлагддаг, бүрэн бясалгаж дуусаад чамаас салдаг. Тэр нь бүрэн бясалгаж амжаагүй талаас тусгаарлагдсан. Бүрэн бясалгаж чадаагүй талд үргэлж ямар нэгэн зүйл ойлгомжгүй байдаг, тиймээс асуулт байдаг, асуухыг хүсдэг. Гэхдээ надтай уулзахад Багшийгаа хараад чиний бясалгасан тал сэргэдэг. Хэрэв тэр сэргэсэн бол чиний энгийн хүний тал түүгээр удирдагддаг. Та нар энд сууж байхад яагаад муу бодол байдаггүй, тайван амгалан байдлыг мэдэрдэг вэ? Яагаад гэвэл бясалгасан тал сэргэсэн, тэгээд бүх биеийг удирддаг. Хэрэв бясалгасан тал шаардлага хангахгүй бол бясалгаж дууссан гэх үү? Тэр бүхнийг мэднэ гэсэн үг. Бясалгаж дуусаагүй тал л мэдэхгүй. Өөрөөр хэлбэл чамд асуух сэтгэл төрөхгүй бол, асуух зүйл байхгүй бол, бүгд ойлгомжтой тодорхой гэсэн үг. Надаас дөнгөж салахад тэр дахиад юунд ч оролцохгүй болно, хөдөлгөөнгүй болно. Чиний бясалгал дуусаагүй талд дахиад ойлгомжгүй болно. "Би сая Багшаас яагаад асуусангүй вэ!" гэдэг. Тийм байдаггүй гэж үү? Үнэхээр тийм л байдаг!

Би та нарт хэлье, Номоо сайн унших хэрэгтэй, Номоо их унш, Номоо их унш, Номоо заавал их унш. Энэ бол Орчлон ертөнцийн Фа. Энгийн хүний нийгэмд эрт дээр үеэс одоог хүртэл тархсан аль ч бясалгалын ном Татагата түвшний буюу түүнээс доод түвшнийх. Энэ агуу Фа Сансар ертөнцийн янз бүрийн амь бодид зориулан өөр өөр амьдрах орчин бүтээсэн. Энэ бол Аугаа Фа- Сансар орчлонг бүхэлд нь бүтээсэн. Энэ нь чи зөвхөн тэдгээр түвшинд хүрэхээс өмнө дээд түвшний зүйлийг харж чадахгүй. Гэхдээ үүнд Гэгээрлийн хутагт хүрэх, төгс гэгээрэлд хүрэхийн тулд мэдвэл зохих бүх зүйлс бий. Тиймээс чи номоо сайн унш, олон удаа давтан унш. Манай хуучин сурагчид хэрэв асуух асуулт гарвал номоо уншихад хариултыг олж авна гэдгийг мэдээж мэднэ. Сүүлд чи шинэ түвшинд хүрэхэд шинэ дээд түвшний асуулт гарч ирнэ. Тэр үед чи номоо дахиад уншвал чамд дахиад л хариулт өгнө. Энэ замаар чи үргэлжлүүлэн бясалгаж тогтмол дээшилнэ. Чамд асуулт гарахад энэ Фа хариулна. Чи өөртөө өдөр тутмын амьдралдаа хатуу шаардлагатай хандаж тогтмол дээшилбэл чи тууштай шаргуу урагшлана.

Асуулт: Алдар нэр, хувийн ашиг хонжооны үндэс нь хувиа хичээх үзэл үү?

Багш: Хувийн ашиг сонирхол, нэр алдар хөөцөлдөх нь хоёул хувиа хичээх үзэл. Сэтгэл хөдлөл (чин) талаар би урьд Дафа тайлбарлаж байхдаа үүнийг хүний орчлон даяар болон Гурамсан ертөнцийн хүрээнд тархсан байдаг гэж хэлсэн. Гурамсан ертөнц доторхи ямарч амь бодь үүнээс зайлж чадахгүй, бүгд энэ нөлөөн дор оршдог. Хүн бол сэтгэлийн хөдөлгөөн дунд амьдардаг. Үүнд их автах тусам түүний хүч чамд улам хүчтэй нөлөөлнө. Ялангуяа хүмүүс хайртай хүнээ алдахад, эсвэл залуучууд дурлал нь бүтэлгүй болоход энэ талаар улам их бодох тусам сэтгэл хөдлөл нь улам хүчтэй болдог. Сэтгэл хөдлөл Гурамсан ертөнц дотор оршдог, бясалгагч хүн үүнээс салах хэрэгтэй. Чи энэ сэтгэл хөдлөлийг давж гарч цааш явах хэрэгтэй. Хувийн ашиг сонирхол, алдар нэрийн талаар бол хүмүүс үүнийг их үнэ цэнэтэйд тооцдог. Эдгээр нь үнэндээ бас сэтгэл хөдлөлөөс үүсдэг. Чи алдар цуутай болбол үүний дүнд ирэх аз жаргал, амжилтанд баярлахгүй гэж үү? Чи үнэхээр баярлана. Хүн сэтгэлээ хангахын тулд алдар цуу, хувийн ашиг сонирхлыг хүсдэггүй гэж үү? Хүн сэтгэл ханамж авбал баяртай байхгүй гэж үү? Чиний баяртай байх нь сэтгэл хөдлөл биш үү? Алдар цуу, баяр баясгалан, нэр хүндийг авчрана, энэ нь сэтгэл хөдлөл биш үү? Чи

хувийн ашиг сонирхол дээр сэтгэл чинь ханавал баярлахгүй гэж үү? Энэ бол бас сэтгэл хөдлөл. Тиймээс хүн бол энэ сэтгэл хөдлөлийн төлөө байдаг. Энгийн хүмүүсийн дунд чи баяртай байсан ч үгүй ч, ямар нэгэн зүйлийн эсрэг байсан ч үгүй ч, эсвэл тодорхой нэг байдалд хүрэхийг хүсч байсан ч үгүй ч, чиний юуг сайн муу гэж үздэг, юу хийхийг хүсдэг юу хийхийг хүсдэггүй энэ бүгд бол сэтгэл хөдлөл. Би хүн бол зөвхөн сэтгэл хөдлөлийн төлөө амьдардаг гэж хэлсэн. Хүний нийгэмд сэтгэл хөдлөл байхгүй байж болох уу? Хэрэв хүний нийгэмд сэтгэл хөдлөл байхгүй бол хүн үнэхээр амьдрах сонирхолгүй болно. Хүн ингэж л амьдрах ёстой.

Хувиа хичээхийн талаар би саяхан энэ зарчмыг хэллээ, та нар сэтгэл хангалуун алга ташсан. Би ирээдүйн орчлон ертөнц устахгүй гэж хэлэхэд та бүхэн баяртай байсан. Яагаад тийм болохыг мэдэх үү? Зарим хүн ингэж хэлдэг: "Хүн өөрийнхээ төлөө байхгүй бол Газар Тэнгэр ч өршөөхгүй". Зарим хүн үүнийг мөрдөх лозунгоо болгосон. Та нар энэ хувиа хичээх нь үнэндээ их өндөр түвшинд хүртэл нэвтэрснийг мэдэхгүй. Урьд бясалгагчид: "Би үүнийг, түүнийг хийдэг", "Би ийм тийм зүйл хийх дуртай", "Би ийм, тийм юмтай болохыг хүсч байна", "Би бясалгаж байна, Будда болохыг хүсч байна", "Би ийм тийм амжилтанд хүрмээр байна" гэж хэлдэг байсан. Үнэндээ энэ бүгд бол хувиа хичээх талын зүйлс. Би та бүгдийг ариун Фа, ариун гэгээрлийн үндсэн дээр цэвэр хувиа хичээгээгүй, жинхэнэ төгс гэгээрэлд хүрэхийг хүсч байна. Зөвхөн тэгвэл үхэшгүй мөнхийг олж авна. Тиймээс би та нарт хэлье, ямарч зүйл хийсэн эхлээд бусдыг бодож бай. Зарим хүн хэн нэгэн түүнд мөнгө өгвөл баярладаг. Хүн чамд мөнгө өгөхөд чи түүнд хүндрэл учруулаагүй биз гэж боддог уу? Тэдэнд санхүүгийн хүндрэл юмуу ямар нэгэн бэрхшээл учрахгүй байгаа гэж боддог уу? Зөвхөн хүмүүс түүнд юм өгч л байвал тэр баяртай, гэхдээ тэр бусдыг боддоггүй. Заримдаа хүн өөрт нь ямарч хэцүү байсан чамайг баяртай байлгахын тулд, чиний санаанд нийцүүлсэн зүйлс ярихаас өөр аргагүй байдаг, чи тэднийг ойлгодоггүй. Янз бүрийн нөхцөл байдал гардаг. Тиймээс өнөөдрөөс эхлэн бясалгахдаа, хийж байгаа бүх зүйлдээ эхлээд бусдыг бодож байх хэрэгтэй.

Асуулт: Жуан Фалунь-2 номонд далай дотор амьдардаг хүмүүс, олон янзын хүмүүс байдаг гэсэн.

Багш: Тийм, зарим нь бидний энэ орон зайд амьдардаг, зарим нь энэ орон зайд амьдардаггүй. Хүмүүс зөвхөн далайд амьдардаггүй, мөн бидэнтэй ижил давхаргын бусад орон зайнуудад өөр хүмүүс бас амьдардаг, яг та нартай төстэй, мөн та нартай төсгүй хүмүүс ч бий. Тэднийг хүн гэж хэлж болно, эсвэл хүн гэхгүй байсан ч болно. Тэдэнд зарим сэтгэл хөдлөл байдаг, гэхдээ бэлгийн дур хүсэл байдаггүй. Тиймээс биеийн доод хэсэг нь ямар нэгэн эд материалын хэлбэртэй, дээд бие нь хүний хэлбэртэй. Тэд чөлөөтэй хөвж чадна, эргэн тойрондоо нисч чадна. Далайн ихэнх хүмүүс дэлхий дээр өөр өөр үеүүдэд амьдарч байсан хүний төрөлд багтдаг. Тэдний зарим нь далайн ёроолд амьдардаг хүмүүс. Зарим нь гадаад байдлаараа хүнээс бараг ялгаагүй. Зарим нь дээд бие нь хүн шиг, доод бие нь загас шиг, зарим нь яг үүний эсрэгээр байдаг. Эх газрын хавтгайн доогуур бас өмнөх үеийн хүмүүс амьдардаг, урьд өмнө устсан хүмүүс, тэд дээш гарч болохгүй, яагаад гэвэл энэ хүний орчлонгоос, дэлхийгээс устгагдсан. Ийм байдлаар тэдний зарим их нүгэлгүй, олон муу зүйл үйлдээгүй хэсэг нь газар луу орсон. Тэд бол ийм л учиртай, тэндээ амьдардаг гарч ирдэггүй. Тэдний тоо тийм их биш. Тэд гол төлөв хүнээс бага зэрэг илүү чадвартай, хүн шиг төөрөлдсөн биш. За ийм зүйлүүдийг битгий их сонирх, битгий их

сониуч бай. Та нарын бясалгалд их ач холбогдол байхгүй.

Асуулт: Ирээдүйд Японы Дафа номын шинэ орчуулагдсан хувилбар албан ёсоор гарахад бид алдаатай орчуулагдсан хуучин номоо яах вэ?

Багш: Тэнд алдаа гарсан гэж битгий бод, зүгээр л сайн орчуулагдаагүй, яг тохирсон зөв үгийг олоогүй гэж хэлж болно. Тэгвэл яахав? Энэ орчуулгын номыг зүгээр л байгаагаар нь үлдээчих. Хятад хэлнээс гадаад хэлэнд орчуулсан ямарч ном эх номноос жоохон ч хазайхгүй байна гэж байхгүй. Хэдэн төрлийн орчуулга байсан нь дээр гэж би хэлсэн. Хүмүүс уншсаны дараа "Өө, ийм утгатай юм байна, өө бас тийм утгатай юм байна...утга нь ийм гэсэн үг юм байна" гэж ойлгоно. Та нар надаас асууж байгаа бол энэ нь үнэн хэрэгтээ бас тодорхой ач холбогдолтой. Зүгээр л үлдээчих.

Асуулт: Хулчгар зан зууралдсан сэтгэл үү, эсвэл сэтгэл санааны хэрэг үү?

Багш: Хулчгар байдаг учир нь, энэ орчлон ертөнцөд хулчгар гэсэн ухагдахуун байдаг, энэ нь чамайг аймтгай болгоно. Чи айх тусам энэ нь улам нөлөө үзүүлнэ. Чи үүнийг сэтгэлийн хүчээр ялах хэрэгтэй, энэ бол сэтгэлийн тэнхээний асуудал. Бясалгалаар үүнд бас заавал хүрэх ёстой.

Асуулт: Дасгал хийж байхад надад бясалгал, Фа түгээхтэй холбоотой асуудлууд болон Багшийн хэлсэн зүйлс үе үе бодогдоод байдаг. Энэ нь зүгээр үү?

Багш: Энэ бол нэг хэсэг хугацааны байдал, ирээдүйд ийм асуудал байхгүй болно.

Асуулт: Хэрэв хэн нэгэн миний нэрийн өмнөөс амь хөнөөвөл тэр бүх карма миний биед хуримтлагдах уу?

Багш: Хэрэв чи тийм ажил хийдэг бол... би ийм талын асуудлаар ярихыг хүсэхгүй байна. Би энэ талаар хоёр нийтлэл бичсэн, тэнд энэ асуудлыг тайлбарласан, гэхдээ зарим хүн ухамсарлахгүй байна. Би ингэж хэлье: чи урьд амьдралууддаа хичнээн амь хороосноо мэдэх үү? Хүн бүр их олныг хөнөөсөн. Энэ дээд Фа дэлгэрээгүй бол та нар энэ насандаа бясалгаж чадахгүй байсан, яагаад гэвэл амьдрал болгондоо тэдгээр амь бодид тавьсан өрөө төлөх ёстой, Буддын шашинд нэг насандаа бясалгаад үр дүнд хүрч чадахгүй гэдэг. Тэд амь бодийг албал амиараа төлөх ёстой болдгийг бас харсан. Гэхдээ өнөөдөр бид чамд төгс бясалгалд хүрэх боломж олгож байна, нүглээ наминчлах хугацаа бага байна, тэгвэл та нарын хөнөөсөн амь бодийг яахав? Чи тэдгээр амь бодид учруулсан хэсэг нүглээ зовж төлнө, түүнээс гаднах чиний ихэнх нүглийг би чиний өмнөөс арилгана, үлдсэн нүглийг та нар өөрсдөө төлөх ёстой, энэ сорилтыг давж чадахаа харуулах ёстой. Үүний хажуугаар та нарын хөнөөсөн амь бодийн зарим нь та нарын бүтээлийн оронд хүрч байгуулсан тэнгэрийн орны ирээдүйн амь бодиуд болно, тийм байдлаар энэ хэрэг сайнаар эргэнэ. Хэрэв алагдсан амь бодь үүнийг мэдсэн бол: "Аая, би Буддын оронд очино" тэд хүзүүгээ сунгаад чамаар алуулах гэнэ, чиний гарт хөнөөгдөх гэж баяртай ирнэ. Мэдээж тэдэнд бүтээлийн орон байхгүй. Тэд өөр тэнгэрийн орны амь бодь болохоор очино, чиний Буддын оронд очиж жирийн оршин суугч болохоор юмуу эсвэл цэцэг, амьтан, шувуу болохоор очино. Янз бүрийн амь бодийн хувьд өөр өөрөөр зохицуулагдана.

Би үүнийг хэлсэн ч зарим хүн эсрэгээр ойлгож магад: "Аан, тэгвэл би амь хөнөөж болохнээ". Хэрэв чи Гэгээрлийн хутагт хүрч чадахгүй бол хороосон амь бодиудынхаа өрийг хэзээ ч төлж чадахгүй, тэглээ ч гэсэн чи өрөө төлөх болно. Тэр нь ямар их нүгэл байх вэ? Өөрөөр хэлбэл чиний өрөө төлөх явц маш зовлонтой байх болно, дуусашгүй. Тиймээс энэ нь үнэхээр аюултай асуудал. Өчигдөр нэг сурагч асуусан: "Багш там-ын талаар яриагүй". Энэ талаар та нарт хэлэхийг хүсэхгүй гэж би хариулсан. Манай орчин ийм ариун, энд тийм аймшигтай зүйлийн талаар ярих гэж үү?! Мэдээж надад бол аймшигтай биш, гэхдээ зарим хүнд үнэхээр аймаар. Чамд сая шууд хариулаагүй ч гэсэн би ойлгомжтой тайлбарласан байх гэж бодож байна.

Хятадад нэг сурагч байсан, анагаахын салбарт докторын зэрэг хамгаалах гэж байсан, тэгээд анатомын туршилт хийх хэрэгтэй болсон. Тэр нэг туршилт хийж дуусаад докторын зэргээ авах байсан. Тэр бүх шалгалтандаа тэнцсэн, гэхдээ 1000 эсвэл 500 хулганд туршилтын задлан хийж докторын зэргээ хамгаалах ёстой байсан. Тэр Багшдаа үүнийг хийж чадахгүйгээ хэлсэн: "Би одоо Фалунь Дафа-гаар хичээллэж байгаа, амь хороовол нүгэл хураана гэж мэднэ". Тэгээд тэр төслийн удирдагчдаа хэлсэн: "Би амьд амьтан алж чадахгүй, би эрдмийн зэргээсээ татгалзсан нь дээр" гэж хэлсэн. Бүгдээрээ үүн дээр бодоцгооё. Хэрэв хүн амьдрал үхлийн сорилтыг давж чадахгүй бол Төгс гэгээрэлд хүрч чадахгүй. Гэхдээ асуудал үүнд биш, чи үүнтэй төстэй зүйлийг туулж гарах болно, тэгээд үхэл амьдралын асуудлыг орхисонд тооцогдоно гэсэн үг биш. Энэ бол зөвхөн нэг хэлбэр. Би үүнд их ач холбогдол өгдөггүй, зөвхөн чиний сэтгэлийг хардаг, чамайг үнэхээр тийм байж чадахыг харна. Бодоод үз, хүмүүс энэ ертөнцөд зөвхөн алдар нэр, ашиг хонжооны төлөө амьдардаг. Хэрэв тэр докторын зэргээ авсан бол сайн ажил олж болох байсан, түүний өмнө их боломж нээгдэх байсан. Түүний цалин өсөх байсан нь дамжиггүй, энэ бүгд ойлгомжтой. Тэр жирийн хүнээс илүү цалин авах байсан, хүн үүний төлөө амьдардаг биш гэж үү? Харин тэр үүнээс татгалзсан. Тэгвэл боддоо, тэр үүнээс татгалзаж зүрхэлсэн. Тэр залуу хүн үүнээс татгалзаж чадсан, юуг ч орхиж чадна гэсэн хэрэг биш үү? Үхэл амьдралаас татгалзаж чадсан хэрэг биш үү? Хүмүүс үүний төлөө амьдардаггүй гэж үү? Тийм зүйл хийж чаддаг хүний бясалгалын түвшин үнэндээ тэр л өндөрт байна. Тийм хүмүүсийн хувьд ийм нөхцөл байдлыг хэлбэл: Чи сэтгэл хөдлөлөөс салж чадаж байгаа болохоор, алдар нэр, ашиг хонжоог орхиж чадаж байна. Тэгвэл яагаад амь бодийг алах айдаснаасаа салж чадахгүй байна вэ?! Энэ сүүлчийн зууралдсан сэтгэлээсээ салсан хэрэг биш үү? Ийм л утгатай. Хэрэв чи энэ шатанд хүрээгүй байж, үхэл амьдралын сорилтыг давж чадахгүй байж, энэ бүгдээс салж чадахгүй байж ингэж хийж чадвал өөр хэрэг. Тэгвэл чи хөнөөсөн бүх амь бодийнхоо өрийг өөрөө төлөх ёстой, төгсгөлгүй төлөх явцтай-ийм л аймшигтай. Би Фа зарчим болон энэ хуулийг үгчлэн хэллээ, яаж хийх нь өөрөөс чинь хамаарна. Фа зарчим бол амь бодийг алж болохгүй гэж сургадаг, бясалгаж байвал амь алж болохгүй. Гэхдээ дээд түвшний Дафа бүхнийг багтаадаг, Фа Буддын түвшний зарчмыг харуулдаг. Би хэлсэн, чи бүтээлийн оронд хүрсний дараа чиний хөнөөсөн зарим амь бодь чиний ирээдүйн тэнгэрийн орны амь бодиуд болно, хэрэв чи Бүтээлийн оронд хүрч чадахгүй бол бүгд дуусна! Чи бүх өрөө өөрөө төлөх болно, ийм тогтолцоотой. Тиймээс би дээд түвшний Фа-г тайлбарлахыг хүсдэггүй, яагаад гэвэл намайг үнэнийг илчилсний дараа ч хүмүүс миний ярьсан зарчмыг үнэхээр ухамсарладаггүй.

Фа, мэдээж энгийн хүмүүсийн зарчмаас дээгүүр. Чи бүх номыг сөхөөд үз, эртний одоогийн, Хятадын, Гадаадын болон бусад судраас олж чадахгүй. Тиймээс хүн бүр

сонсохыг хүсдэг. Гэхдээ үүнийг мэдлэг гэж битгий авч үз, би энд та нарын мэдлэг олж авах гэсэн зууралдсан сэтгэлийн төлөө байгаа биш. Би чамайг аврахын тулд энэ Фа-г зааж байна.

Асуулт: Хүндэт Багшаа, та "бид" гэдэг үгийг дандаа хэрэглэх юм. Бид үүнийг юу гэж ойлгож болох вэ?

Багш: Би эх газрын Хятадын орчин үеийн үг хэрэглэж байна. Би та бүхнийг Дафа-гийн элемент, нэгж гэж үздэг, тиймээс та нарыг "бид" гэж хэлдэг. Ингэж хэлбэл та нар өөрсдийгээ жинхэнэ бясалгагчийн байр сууринд тавих болов уу. Тийм л утгатай.

Асуулт: Ямар үед хүнийг сэтгэл мэдрэлийн өвчтэй гэх вэ?

Багш: Сэтгэл мэдрэлийн өвчин гэдэг нь хүн өөрийгөө удирдаж чадахгүй болтлоо сул болохыг хэлнэ. Тийм хүн бэрхшээлтэй тулгарахаар юу ч хийхийг хүсдэггүй, түүний эзэн бодол (Жу-иши) унтаж байгаатай адил болдог, юунд ч анхаарахаа болино, биеэ эзэнгүй сул орхичихдог. Энэ үед тэр хүнд хүмүүсийн хэлдгээр сэтгэл мэдрэлийн өвчний байдал гардаг. Яагаад? Түүний Эзэн бодол биеэ удирдахгүй болоход, өөрийн бодлогогүй болоход янз бүрийн нүглээс үүссэн бодол, төрсний дараа олж авсан янз бүрийн үзэл бодол нь түүний бие, ам, нүд, түүний бүх зүйлийг удирдана. Тэгэхээр тэр утга учиргүй юм ярина, ямарч хэвийн бус, солиотой байдал гаргана, энгийн хүний хэвийн байдлаа алдана, хүмүүс ийм хүнийг сэтгэл мэдрэлийн өвчтэй гэнэ. Би сэтгэл мэдрэлийн өвчнийг өвчин биш гэж хэлсэн, яагаад гэвэл түүнд ямарч өвчин, бие махбодийн эмгэг байхгүй, зөвхөн хүний эзэн сүнс хэт сул, зарим хүний эзэн сүнс төрөлхийн сул дорой байдаг. Түүний бие үргэлж бусдаар удирдагдаж байдаг, үргэлж өөрийгээ бусдын эрхшээлд өгч байдаг. Өөр орон зайнаас ирэх мэдээлэл, үймүүлэл нэмэгдэхэд тийм хүн юу ч хийнэ. Түүний тархи бэлэн машин, хэн ч удирдаж болно. Хэрэв чи удирдахгүй бол, түүнээс татгалзвал бусдууд удирдах болно, тэгэхэд тэр хүн хэвийн байдлаа алдана. Тиймээс хүний сэтгэлийн тэнхээ хүчтэй байх ёстой, хатуу байх ёстой!

Асуулт: Бясалгалаар төгс гэгээрэлд хүрэхэд бие нь өөрчлөгддөггүй, мөнхийн нярай хүүхэд (Юанинь) гардаггүй хүн байдаг уу?

Багш: Би аль хэдийн хэлсэн, манай Дафа-гийн олон сурагчид янз бүрийн түвшнээс ирсэн, тиймээс янз бүрийн байдал байж болно. Чи өөрийнхээ байдалд анхаарал хандуулж хэрэггүй. Чи бясалгах юм бол чиний санаанд хамгийн илүү нийцэх тийм байдалд хүрэх боломжтой гэдгийг би баталж байна. Энэ бол бүх хүнд хамаарна. Миний та бүхэнд хамгийн сайныг өгч байгаа нь энэ орчлон ертөнцөд бүтээгдсэн хамгийн сайн нь биш гэж үү? (Алга ташиг)

Асуулт: Би Жуан Фалунь номыг уншиж байхдаа Будда, Бумба эсвэл Бурхадын надад өгч байгаа ямар нэгэн дохио санааг ховор мэдэрдэг. Гэхдээ би амьдрал дээр бясалгахад Фа зарчмыг ойлгож авдаг.

Багш: Чи өөрөө ухамсарлах чадвартай учраас чамд санаа өгөх шаардлагагүй. Чи тэгж чадсанаар Дао-г өөрөө ухамсарлаж байна, энэ бол их сайн. Зарим хүн ухамсарлаж эр

чаддаггүй, гэхдээ бид тэдэнд ирээдүй байна гэж хардаг. Тэгвэл яах вэ? Тэгвэл бид түүнд далд санаа өгдөг.

Асуулт: Сүүлийн үед сэтгэлээр их унаж байна, сайн бодол гарахгүй сэтгэл санаа их үймрээд байх юм, би үнэхээр доош унасан уу?

Багш: Чи өөртөө анхаарал сулархаар карма чам руу хайр найргүй довтолно. Хэрэв чиний тал хүчтэй байвал үүнийг барьж болно. Чи түүнийг тогтоон барьж удирдлагандаа авч чадвал би чамайг муугуй байна, жинхэнэ бясалгагч гэнэ. Тэгвэл би чамайг хариуцна, тэдгээр зүйлийг чамд арилгаж өгнө. Ингэж л хийнэ. Чи өөрийгээ удирдаж чадахгүй байж болохгүй. Чи ингэж хэлж магад, "Оо, би үүнийг дарж байвал Багш надад арилгаж өгнө. Тэгвэл би үүнийг дарж байя". Ингэвэл би урьд өвчтэй хүний бодлын талаар хэлсэн шиг болно, чи надаар карма-гаа арилгуулахын тулд хичээллэх юм бол юу ч бүтэхгүй! Чи юунд ч зууралдсан сэтгэлтэй байж болохгүй. Чамд зөв ариун бодол байх хэрэгтэй.

Асуулт: Паркад нийтээрээ дасгал хийж байхад дасгалын хөдөлгөөнийг заасан Багшийн видео бичлэгийг үзүүлж болох уу?

Багш: Хэрэв нөхцөл байдал боломжтой бол болно. Дүрс бичлэг үзүүлэхэд орон нутгийн засаг захиргаанаас хориглоогүй газарт бол болно.

Асуулт: Би жил гаруй бясалгаж байна. Би бясалгах тусам улам эмзэг болоод байх шиг, яльгүй жоохон зууралдсан сэтгэл хүртэл намайг зовоох юм.

Багш: Чи их мэдрэмтгий болсон, муу бясалгаж байна гэж айсан байж магадгүй. Тийм сэтгэлээ орхих хэрэгтэй, чөлөөтэй өөдрөг бясалга. Нөгөө талаар өөртөө хатуу шаардлагатай байх хэрэгтэй. Та нарын хэн ч гэсэн бясалгалын явцад алдаа гаргаж болно, тулгарах сорилтонд унаж болно. Хэрэв чи сорилт болгоныг амархан даваад байвал би чиний Багшийн хувьд чамд сайн төлөвлөөгүй гэсэн үг. Тиймээс сорилт болгон давахад хэцүү. Чи нэг бол давна, эсвэл унана, чи нэг бол сайн давна эсвэл муу давна. Гэхдээ чи сорилтыг муу давбал сэтгэл чинь таагүй болно, өөрийгээ муу бясалгаж байна гэж ухамсарлан гүн харамсана. Сайн бясалгаж дараагийн удаа давна гэж сэтгэлдээ хичээнэ. Дараагийн удаа чи ийм байдалд сорилтыг давж чадах эсэхээ үзнэ, өөрийгээ үргэлж ингэж сорино-энэ бол бясалгал. Хэрэв чи сорилт болгоныг амжилттай даваад байвал чамд бясалгах хэрэггүй байхсан. Хэрэв ямарч сорилт чамайг зогсоож чадахгүй бол чамд төгс гэгээрэл ирнэ. Гэхдээ асуудлыг эсрэг талаас авч үзье. Хэрэв чи: "Сорилтыг сайн муу давах нь хамаагүй бясалгаж байвал л болно гэж Багш хэлсэн гээд өөртөө тавих шаардлагыг сулруулбал сорилтыг муу давсан ч түүнийг тоохгүй, анхаарч үзэхгүй байвал чи бясалгаагүйтэй адил. Ийм уялдаатай. Чи өөртөө хатуу шаардлага тавихгүй байж огт таарахгүй.

Асуулт: Төгс бясалгал гэж юу вэ? Энэ нь энгийн хүний үхэлтэй адил уу эсвэл Багш зохицуулдаг уу?

Багш: Төгс бясалгалд олон хэлбэр байдаг. Бүгд мэднэ, Будда Шагжамүни хүний зууралдсан сэтгэлийг дээд хэмжээгээр орхиулахын тулд нирваалсан. Түүний номонд

хүний биенээсээ хүртэл татгалздаг, энэ номоор бясалгасан хүн хүний биед уягдахгүй тэгэж л бясалгадаг. Түвдийн ламын шашинд гэрэлт хувирал хэмээх ёс байдаг. Энэ нь төгс бясалгалд хүрч байгаа хүн сууж байгаад, хэрэв түүний бие бүрэн хувирч дууссан бол төгс бясалгалд хүрэнгүүт бие нь хоромхон зуур улаан гэрлийн бөөгнөрөл болж хувирна. Түүний сүнс Буддын бясалгасан биеийг авч одно. Буддын бясалгасан биед хүний ертөнцийн бодис оршдоггүй учраас хүмүүс түүнийг харж чадахгүй, зөвхөн гэрэл нь харагддаг, дээш хөөрч байгаа гэрлийн хэлбэр л харагдана. Тийм сайн бясалгаж чадаагүй хүний бие бүхэлдээ гэрлийн бөөгнөрөл болон хувирч чадахгүй. Тиймээс түүний бие гэрэлт хувиралд ороход бие нь хоромхон зуур агшиж гуравны нэгэн метр өндөртэй болно. Бүтэн хүн нэг фүүт хэмжээтэй болж агшина. Тэр хүнтэй яг адилхан хэлбэртэй мөн биеийн харьцаа нь хэвээр үлдэх болно, гэхдээ нэг фүүт өндөртэй болж багасна. Тэр хангалттай бясалгаж чадаагүй учраас гэрэлт хувиралтанд бүрэн орж чадахгүй.

Мөн өөр нэг хэлбэр байдаг. Хятадад Дао-гийн бясалгалаар төгс гэгээрэлд хүрэхэд "цогцос ангижрах" гэдэг хэлбэр байдаг. Цогцос ангижрах гэж юу вэ? Эртний Хятадад олон хүн аугаа Дао-д бясалгадаг байсан. Аугаа Дао бясалгалын шаардлага бол хүн бясалгалын төгс үр дүнд хүрээд биеэ аваад явдаг, бие нь энгийн хүний бие биш болно, дээд энергийн бодисоос бүрдсэн бие болон бүрэн хувирч түүний Дао бие болдог. Тэдний цогцос ангижрах хэлбэр гэдэг нь: Тэр хүн бясалгалын төгсгөлд хүрээд бие нь бүрэн бясалгаж дууссанаа мэддэг. Тэр яаж хүний орчлонгоос явах вэ? Ихэнх Дао бясалгагчид төгс бясалгалд хүрснийхээ дараа хүний орчлонд биелүүлж амжаагүй хүслээ гүйцэлдүүлдэг. Буддын бясалгалд өөр хэрэг, төгс бясалгалд хүрэх замдаа бүгдийг шийддэг.

Цогцос ангижрах гэдэг нь явсны дараа хүмүүс түүнийг хайхгүй байлгахад зориулагдсан юм. Энэ нь хуурамч үхлийн хэлбэрт явагдана, энэ үед тэр тэнгэрт гарч эсвэл газар луу орж чаддаг болно. Явахынхаа өмнө гэрийнхэндээ хэлнэ: "Бясалгалын эцэст хүрээд явах цаг боллоо. Би бясалгаж дууслаа. Би удахгүй явна, надад авс бэлдээрэй". Түүний тооцоолсон өдөр болоход тэр орондоо хэвтээд амьсгал хураана. Гэрийнхэн нь түүнийг үхсэнийг хараад авсанд хийж оршуулна. Үнэндээ тэр ер бусын чадвар ашиглан нүд хуурна. Тэр өдөр гэрийнхнийх нь харсан нь түүний жинхэнэ бие биш. Харин юу байсан бэ? Тэр ямар нэгэн биетийг дохиод л хувиргадаг, ямар нэгэн гутал, хогны шүүр, модон саваа юмуу сэлэм гэх мэтийг өөрийн хэлбэртэй адилхан болгож хувиргана. Энэ биет ярьж чадна. Тэр гэрийнхэндээ хэлнэ, "Би хэвтээд удахгүй үхнэ. Намайг авсанд хийгээд л болоо" гэж хэлнэ. Үнэндээ тэр бол нэг мод, шүүр эсвэл магадгүй нэг шаахай хэвтэж байдаг. Жинхэнэ хүн аль хэдийн холын хол явчихсан. Гэрийнхэн нь түүнийг оршуулна. Түүнийг оршуулсны дараа хоёр цаг болоод л тэр биет өөрийн хэлбэртээ буцаж хувирдаг, гутал эсвэл ямар нэгэн хулсан саваа эсвэл модны тайрдас болдог. Үүнийг цогцос ангижрах гэдэг. Холоос ирсэн ямар нэгэн хүн хэлдэг, "Аая, би их хол газар танай гэрийн тэр (нас барсан) хүнийг харсан. Би тэнд наймаа хийж байхдаа түүнтэй бүр ярьсан гэнэ. Гэрийнхэн нь хэлнэ: "Ийм байх учиргүй, тэр аль хэдийн нас барсан". Тэр хүн хэлсэн, "Би түүнийг харсан, тэр үхээгүй. Би үнэхээр түүнийг харсан, түүнтэй бүр ярьсан, бид хамтдаа хоол идсэн" гэж хэлсэн. Энэ нь их гайхалтай. Тэр үнэхээр үхсэн биш үү? Гэрийнхэн нь түүнийг Дао-гаар бясалгадаг байсныг мэднэ, "шарилыг нь ухаж үзье" гэсэн. Авсыг нь нээхэд дотор нь зөвхөн өрөөсөн нэг шаахай байсан.

Дао бясалгалд өөр нэг хэлбэр байдаг. "Гэгээн цагаан өдөр хөөрөх". Гэгээн цагаан

өдрөөр хөөрөх хэлбэр нь бие нь бүрэн хувирч дууссан тохиолдолд, хүний орчлонд хийх зүйлээ төгс гэгээрэлд хүрэхээс өмнө дуусгасан тохиолдолд хэрэглэдэг. Энд түүнд хийх юу ч үлдээгүй тул явах цаг болсон. Энэ цагийг "Тэнгэрийн үүд нээгдэх буюу Гурамсан ертөнцийн үүд нээгдэх" гэдэг. Дараа нь зарим тохиолдолд Тэнгэрийн бурхан түүнийг угтаж авдаг, эсвэл луу юмуу тогоруу гэх мэт дээр суугаад нисдэг, эсвэл түүнийг тэнгэрийн сүйх тэрэг ирж авна. Иймэрхүү зүйл эрт үед их байсан. Гэгээн цагаан өдөр хөөрөх гэдгийн нэг хэлбэр. Манай сурагчдаас Фалунь диваажинд буцах ёстой хүнд би "Гэгээн цагаан өдөр хөөрөх" хэлбэр хэрэглэхээр төлөвлөсөн. Зарим бясалгалд бие хэрэггүй байдаг Хэрэв түүнд бие өгвөл түүний орчлонгийн бүх зүйлийг замбараагүй болгоно. Жишээ нь: Шагжамүни-гийн бясалгалын нирваан юм. Хэрэв түүнд бие өгвөл үүнийг нирваалах гэж хэлэхгүй. Тэгвэл түүний бясалгалын бүхэл системийг бусниулсан болохгүй гэж үү? Түүний бүх диваажин орчлон "Сахил, Төвлөрөх, Билгүүн ухаан" (Сийла, Самади, Мати) гэсэн элементээс тогтдог, тиймээс бие хэрэггүй. Манай олон хүн энгийн хүний бодлоор төсөөлдөг: "Гэгээн цагаан өдрөөр нисвэл ямар сайхан бэ! Намайг хөөрөхийг хүмүүс хараг". Чи гэгээрэгчийн хэргийг энгийн хүний сэтгэлээр бодож байна, үүнийг туйлаас зөвшөөрөхгүй. Өөрөөр хэлбэл Төгс гэгээрэлд хүрэх үед үүний тулд мэдээж нэг хэлбэр байх болно. Гэвч энэ удаа их олон хүн Төгс гэгээрэлд хүрэх болно, би та нарт хэлье, үүнд итгэдэггүй хүмүүст би гүн сургамж үлдээнэ. Тиймээс ирээдүйд миний сурагчид Төгс гэгээрэлд хүрэхэд маш нүд булаам үзэгдэл болно, үүнийг хүн төрөлхтөн хэзээ ч мартахгүй. (*Алга ташив*) Та нарт ярьсан зүйлийн хувьд бүх зууралдсан сэтгэлээсээ салах хэрэгтэй, энэ талаар санаа зовох хэрэггүй. Зүгээр л бясалга. Хэрэв чи бясалгаж чадахгүй бол бүх зүйл талаар болно.

Асуулт: Жуан Фалунь номын үг бүрийн ард Будда, Дао, Бурхад байдаг гэж үнэн үү?

Багш: Тийм, үнэн. Тиймээс би хэлдэг, та бүгд номоо унш. Номоо унших үед зарим хүн ямар нэгэн зүйлийг ойлгодог. "Аан, би ойлголоо" энэ мөчид түүний бие гэнэт чичэрхийлж халуун урсгал мэдэрдэг. Энэ нь яльгүй мэдрэмж төдий боловч тэр үед биенд маш их өөрчлөлт болдог, нөгөө талд бүгд энд тэндгүй оволзож байдаг. Тэр нь чи дахиад нэг түвшин ахиж байгаа хэрэг, биенд өөр түвшингийн өөр хэлбэрийн өөрчлөлт гарч байна. Та нар мэднэ, Хятадын зарим сүм дуганд Буддын баримлын толгой дээр дөрвөн толгой байдаг, түүн дээр бас гурван толгой давхар байдаг, дахиад нэг толгой гурван толгой дээр ургасан байдаг. Энэ бол Буддын Фа-гийн өөр өөр түвшингийн илрэл. Энэ нь өөр түвшинд биенд их өөрчлөлт гардгийг хэлж байна. Энэ нь зөвхөн сүрлэг хүчтэй харагдаад зогсохгүй бас ариун, сүр жавхлантай, ер бусын гайхамшигтай. Тиймээс чамд харахыг зөвшөөрөхгүй байх шалтгаан бий. Чамд энгийн хүний бодол байгаа болохоор үүнийг энгийн хүний бодлоор ойлгоно, хэвийн бус бодлогогүй байдал гаргаж болно. Бидэнд ийм байдал гаргаж болохгүй.

Асуулт: Хүнтэй гар барих, мөн биеэр хүрэлцэхэд карма дамжих уу?

Багш: Хэрэв чи жинхэнэ бясалгагч бол ямарч мэдрэмтгий байсан ямарч муу юм болохгүй. Чи бясалгаж байгаа, чиний биед гон бий. Гон-оос доогуурхи зүйлээс айх хэрэг байна уу? Та нарын хооронд түвшний хувьд маш том зааг бий, тиймээс айх хэрэггүй.

Хүмүүс хоорондоо гар барих, биенд хүрэх, энгийн хүний гар барилт үнэхээр карма дамжуулах үүрэг гүйцэтгэж болно, наад зах нь бохирдож халдвар авч болно. Энэ бол эргэлзээгүй. Одоо хүн болгон нэг нэгэнтэйгээ гар барьдаг болсон. Гар барих нь барууны цагаан арьстнуудаас тархсан. Урьд дорныхон гар барьдаггүй байсан, тэд уулзахдаа нэг алгаар нөгөө зангидсан гараа атгадаг байсан. Энэ нь их сайн зүйл байсан. Эмэгтэй хүн ингэж барихгүй, тэгвэл муухай харагдана. Харин тэр барилыг баруун ташаандаа хийдэг байсан, энэ үед ташаагаа бага зэрэг эргүүлж өвдгөөр яльгүй нугалсан янзтай байна. Баруунд гар барилт Рэнайсансын дараа үүссэн, түүнээс өмнө гар барилт тэдэнд бас байгаагүй, өөр янзаар мэндчилэх хэв маяг байсан, зарим нь ингэж, зарим нь тэгж гэх мэт өөр янз бүрийн хэлбэрүүд байсан. Гар барилтыг сүүлд хэрэглэдэг болсон. Бид (хэши) хоёр алгаа хавсардаг биш үү? Энэ бол Буддын системийн хэлбэр.

Асуулт: Би жил гаруй бясалгаж байна, хүмүүс надад бараг бэрхшээл үзүүлэхгүй юм. Цаашид ийм байсаар байвал би яаж зууралдсан сэтгэлээсээ салах вэ?

Багш: Энэ нь тийм биш. Хүн бүрийн нөхцөл байдал өөр. Зарим нь ийм янзаар, зарим нь өөр байдлаар байж болно. Олон янзын хүчин зүйлс бий. Тийм зүйлст битгий зууралд. Жинхэнэ хүнд бэрхшээл тулгарвал чамд давахад хэцүү санагдана, хэцүү бэрхшээл байхгүй үед чи үүнийг хүснэ. Юм болгон учиртай. Зарим хүнд үнэхээр бэрхшээл зовлон байдаггүй. Энэ бол бас үнэн.

Асуулт: Манай дасгалын газар арав гаруй хүн хичээллэдэг. Тэдний ихэнхийн царайны өнгө байдал нь тааруу. Бид сайн бясалгахгүй байгаагийн хэрэг үү?

Багш: Цөөн тооны дасгалын газрын байдал үнэхээр муу, сурагчид хоорондоо хов жив ярина, янз бүрийн байдлаар юмыг хүлээж авна. Зарим хүн миний заасан Фа-тай ямарч холбоогүй зүйлийг ярина, бусад сурагчдад түүнийгээ энэ бол ингэж хэлсэн, тэгсэн үг гээд л ойлголтыг нь үймүүлнэ. Түүнээс гадна номонд тайлбар дүгнэлт өгнө, энэ хэсэг нь ийм, тэр хэсэг нь тийм гээд л үнэлэлт дүгнэлт өгдөг. Хүн Фа-г авч хэлэлцэх нь зүй зохистой юу? Наад зах нь чамд хүний бодол байгаа, тиймээс буруу хандана. Та нар Дафа-гийн дагуу хамтдаа уншиж, суралцаж, дасгалаа хийх хэрэгтэй. Фа уншихдаа ихэнх цагаа зориул, өөрсдийн дадлага туршлага хуваалцах талаар бага ярь. Эсвэл дасгал хийж дууссаны дараа хамтдаа ярилцаж болно. Энэ бүгд бас болно. Та нар бясалгал хийх Фа унших цагаа хоорондоо сэтгэгдлээ хуваалцах гэж ярьж өнгөрвөл сайн биш гэж хэлнэ. Зарим хүний ярьдаг зүйлст янз бүрийн хувиа хичээсэн бодол, сэтгэл, Фа-тай ямарч холбоогүй зүйлс байдаг. Ийм тохиолдолд чи сурагчдыг буруу замаар дагуулна, тэрч байтугай дэмий мөрөөдөлд автуулна. Хүн болгонд энгийн хүний бодол байдаг. Манай хуучин, шинэ сурагчид үгийн гаднах утгаас дээгүүр зарчим зүйлсийн талаар ярихыг зөвшөөрөхгүй. Чиний ярьж байгаа бол үгийн өнгөн утга, зарчим, энгийн хүмүүсийн дунд Тэнгэрийн Фа ярьж болохгүй. Би зарим хүн яагаад ингэж буруугаар ойлгодгийг мэдэхгүй, тэдэнд яагаад тийм замбараагүй бодол санаа төрдөг байна. Тиймээс та нар үүнд анхаар!

Асуулт: Гарын хөдөлгөөн (инь) гэдгийг яаж тайлбарлах вэ? Яагаад (жэинь) гарын барилыг хийх шаардлагатай вэ?

Багш: Буддууд үүнийг "инь" гэдэггүй. Энэ бол Буддын Фа- сүр хүчийг илэрхийлэх хэлбэр.

Энэ үг эртний Энэтхэг хэлнээс өөрчлөхгүйгээр шууд хэлсэн, "инь" гэж уншигддаг. Жэинь-гарын мутар барил, да-шоу-инь гарын их мутар барил, сяо-шоу-инь гарын бага мутар барил гэдэг нь бас Фа-гийн илэрхийлэх өөр нэг сүрлэг хэлбэр, Фа- хэл.

Асуулт: Би бясалгаад бараг жил болж байна, гэхдээ би Фалунь-ийг хэзээ ч хараагүй.

Багш: Үүнийг ингэж авч үзье. Чиний биед ямарч өөрчлөлт гарсангүй, Фа-гийн өгч байгаа зүйл чамд ямарч мэдрэмж үзүүлэхгүй байна гэвэл эсвэл энгийн хүний хүрээнээс хальсан зүйлийг ойлгож ухамсарлаж чадахгүй байна гэвэл чи бясалгал хийдэггүй л биш бол бусад тохиолдолд би итгэхгүй гэж хэлнэ. Хэрэв чи ямар нэгэн зүйлийг харахыг хүсвэл, тэр нь илэрхийг хүсвэл, энгийн хүн лүү харж байгаа мэт тод харахыг хүсвэл, үүнийг бодитоор илэрхийг хүсвэл энэ нь бүтэхгүй гэж бодож байна. Үүний шалтгаан нь бол: Хүн болгоны өөрийн нөхцөл, түүний энгийн хүний дунд төсөөлөх байдал, ирээдүйд төгс гэгээрэлд хүрэх байдал ч өөр, хүн болгон дахь хандлага ч өөр байдаг. Үүнийг гүйцэтгэхийн тулд би ямарч зүйлийг нэг нөхцөл, хэлбэрээр огт хийхгүй. Чи Фалунь харахыг хүсч байна, гэхдээ энэ зууралдсан сэтгэлээсээ салаагүй нөхцөлд харж чадахгүй.

Асуулт: Дээд түвшний Буддын хувьд хүн бол юу ч биш, Багшаа та яагаад биднийг авархаар ирсэн бэ, хэлж өгнө үү?

Багш: Сансар ертөнцийн Фа, Сансар ертөнцийн маш олон түвшингүүдэд орших амь бодиудад зориулж өөр өөр түвшний амьдрах орчлонг бүтээсэн. Тийм орших нөхцөлд амьдрах амь бодиуд байх ёстой. Энгийн хүмүүс орчлон ертөнцийн Фа-гийн бүтээсэн янз бүрийн түвшний хамгийн доод түвшинд оршдог. Тиймээс би өөрийн зүгээс Фа болон Орчлон ертөнцийг бүхэлд нь авч үзэх ёстой гэж үздэг. Би тодорхой тайлбарласан уу? (*Алга ташив*) Миний байр суурьнаас бол би амьдралыг эерэг, сөрөг талаас нь хардаг, та нараас өөр. Та нар үүнийг ойлгохгүй.

Асуулт: Би үргэлжлүүлэн Фа унших тусам миний боддог зүйл улам бага болж байгаа санагдаж байна, заримдаа бүр юуны ч талаар бодохыг хүсэхгүй болох юм. Энэ нь миний Эзэн бодол сул болсноос уу? Миний бясалгал буруу тийшээ хазайв уу?

Багш: Үгүй, тийм биш. Би тэр байтугай үүнийг их сайн байдал гэж хэлнэ. Би үүнийг яагаад сайн байдал гэж байгаа вэ? Би хэлье, энгийн хүн хувийн сонирхлоо алдахгүйн тулд толгой нь маш хурдан ажилладаг. Энэ үед ойлгоц нь их хурдан, ой тогтоол ч их сайн. Би чиний тархи ингэж ажиллавал муу гэж хэлнэ, яагаад гэвэл энэ нь нүгэл үүсгэж болно. Хэрэв чиний тархи энэ тал дээр хэтэрхий хөгжсөн бол чамд бясалгахад саад учруулна, тэгвэл яах вэ? Бид ийм арга хэрэглэнэ: Эхлээд чиний тархины энэ хэсгийг хязгаарлана. Өөрөөр хэлбэл бид үүнийг эхлээд түгжинэ, тохиргоо хийнэ, энэ хэсгийг чиний тархины бясалгагч талын бодлоор солино, энэ талыг хөгжүүлнэ. Дараа нь тэр зальтай, харгис талыг янзлана, дараа нь аажмаар хориог сулруулна. Тэгэхэд чи өөрийгээ барьж чаддаг болсон байна. Чи өөрийнхээ муу бодлыг илрүүлж чадахгүй үед ч энэ талын тархи их хөгжсөн тул чамайг ямар нэгэн муу зүйлийн талаар дөнгөж бодонгуут тархины энэ тал руу унана. Тархины энэ тал чиний бясалгалд ноцтой саад учруулна. Тиймээс олон хүнд ийм байдал гарч болно, гэхдээ энэ бол түр зуурынх. Чи хувийн эрх ашгаа хамгаалахад ашиглах дуртай бодол бусдад хор учруулж болно, тархины тэр хэт хөгжсөн эсүүдийг түгжиж тохируулах

хэрэгтэй. Тиймээс ийм байдал гарч болно, гэхдээ түр зуурынх. Үүнийг түгжсэний дараа тохируулах хэрэгтэй, түүнийг тэгж хөгжүүлэхгүй, хэвийн байдалд нийцэхэд л хангалттай. Чиний зөв бодол гардаг талын эсүүд хөгжиж байг. Ингэж явагддаг. Эсрэг тохиолдолд ... би орон нутгийн хэллэг хэрэглэж үүнийг илүү тодорхой тайлбарлая: Чи Будда-д өгөөмөр бясалгаж байна, тиймээс чиний бодол зальтай, бусармаг байж таарахгүй!

Асуулт: Бусад сурагчид өөрсдийн туршлагаасаа хуваалцахад надад сургамжтай байдаг, надад урам зориг өгдөг, гэхдээ миний өөрөө ухамсарласнаас илүү үндэслэлтэй санагддаггүй.

Багш: Тийм, энэ үнэхээр тийм. Чиний өөрөө ухамсарласан зүйл гол төлөв бясалгалаар олддог. Энэ бол хамгийн үндэслэлтэй, нөгөө талаар бусдын хэлэхийг сонсоход сургамжтай, үүнээс чи бас санаа авахад тустай. Фа конференц ойр, ойрхон явагдахгүй. Бидний конференц үнэхээр ашиг тустай, гэхдээ хэтэрхий ойрхон бясалгалын туршлага солилцох хэрэггүй. Та бүхэн хүчээ Фа-д суралцах, номоо уншихдаа төвлөрүүлэх хэрэгтэй.

Зарим харьцангуй доод төвшний буюу энгийн болон давтагдсан асуултуудыг, мөн номоо уншаад ойлгож болох асуултуудыг орхилоо. Цаг хязгаартай учраас үүгээр асуултанд хариулахаа өндөрлөө. *(Алга нийжгэнэтэл ташив)*